ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

УЛААНБААТАР ХОТ
2024 он

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

АГУУЛГА

УДИРТГАЛ 2

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ 4

1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох 4

1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох 5

1.3 Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, томьёолох, харьцуулах хэлбэрийг сонгох 8

1.4 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох 8

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ 9

2.1 Үр дүнгийн үнэлгээний хүрээнд цуглуулсан мэдээлэл, боловсруулалт 9

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ 11

3.1 Шүүхийн практикт үүсч буй маргаан хянан шийдвэрлэлт 11

3.2 Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд, эрх зүйн үр дагавар 16

3.3 Салбарын оролцогч талуудаас ирүүлсэн санал, байр суурь 71

3.4 Хуулийн зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн байдал 73

ДӨРӨВ. ХАВСРАЛТУУД 81

УДИРТГАЛ

Эрчим хүчний тухай хууль /цаашид "хууль" гэх/-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ /цаашид "үнэлгээ" гэх/ хийх нь хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх болон харьцуулан үнэлэх ажиллагаа бөгөөд энэхүү үнэлгээ хийх ажлын зорилт нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход оршино.

Одоо үйлчилж буй Эрчим хүчний тухай хууль нь 2001 онд 6 бүлэг 38 зүйл, 288 заалттай батлагдсан бөгөөд хамгийн сүүлд 2024 онд нэмэлт өөрчлөлт оруулснаар 6 бүлэг 38 зүйл, 328 заалттай хуулийг мөрдөж байна. Хуулийн хэрэгжүүлэх хугацаанд 2002, 2007, 2008, 2009, 2011, 2012, 2015, 2017, 2022, 2023, 2024 онуудад нийт 16 удаа өөрчлөлт оруулж, 174 заалтад өөрчлөлт оруулсан байна. Эрчим хүчний тухай хууль хэрэгжсэн 24 жилийн хугацаанд зүйл заалтуудад цөөнгүй тооны өөрчлөлт оруулж байсан хэдий ч хуулийн агуулга, зарчмын хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлт байхгүй, тухайн зүйл заалтуудыг утга санааг нарийвчлах, тодорхой болгох чиглэлийн өөрчлөлүүд хийгдэж байсан.

Анх 2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуулиар удирдлагын босоо тогтолцоотой салбарыг ашгийн төлөө, бие даасан үйл ажиллагаатай компаниуд болгон задлах, хэвтээ чиглэлд үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаануудыг тусгаарлаж, цаашид зах зээлийн өрсөлдөөнт механизмуудыг хэрэгжүүлэх суурь бүтцийг бий болгох бодлогын томоохон шинэчлэл хийгдсэн байдаг.

Мөн эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг хангах, зах зээлийн зарчмаар хөгжүүлэх чиглэлд бие даасан үйл ажиллагаа явуулах, хараат бус зохицуулах байгууллагын статус, эрх, хэмжээг хуулиар тогтоосон байна.

Эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой байдал нь улс орны аюулгүй байдлын чухал шалгуур болохоос гадна эдийн засгийн салбаруудын өсөлт, тэлэлтийг хангахад онцгой үүрэгтэй, хөгжлийг дэмжигч дэд бүтцийн суурь салбар юм. Энэ нь улс орны хөгжил, эдийн засгийн тэлэлтийг хангахад шаардлагатай эрчим хүчний эх үүсвэр, дэд бүтэц урьдчилан төлөвлөгдөж барьж байгуулсан байх шаардлагыг илэрхийлэх ба эдийн засгийн бусад салбаруудаас түрүүлэн хөгжих зарчмыг тодорхойлж байдаг.

Энэхүү зорилтоо хангахад хамгийн түрүүнд бүрдсэн байх нөхцөл нь эрчим хүчний салбар бие даан хөгжих санхүү эдийн засгийн тогтолцоо, чадавхитай байх асуудал юм. Хууль хэрэгжсэн 24 жилийн хугацаанд тус салбар нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч тэргүүлэх салбар байх, салбар бие даан хөгжих эдийн засгийн тогтолцоог бүрдүүлэх хуулийн анхны зорилтоо хангасан эсэхийг үнэлгээний хүрээнд чухалчлан авч үзсэн.

Эрчим хүчний тухай хуулийн хүрээнд шүүхийн практикт үүсч буй асуудлууд, маргаан шийдвэрлэлт нь хуулийн зохицуулалтын эрх зүйн чадамж, үр дүнг илэрхийлэх бас нэг шалгуур үзүүлэлт болох тул энэ асуудлын хүрээнд тодорхой мэдээлэл, өгөгдлүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгсөн.

Хуулийн зохицуулалтын бодит үр нөлөө, хөгжлийн чиг хандлага, цаг үетэйгээ нийцсэн байдал, цаашид боловсронгуй болгох чиглэлд хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүдийн талаар эрчим хүчний салбарын оролцогч талуудын санал, байр суурийг агуулгын хувьд ангилан, нэгтгэж, зохих дүн шинжилгээг хийсэн.

Салбарын өнөөгийн нөхцөл байдал, үүсээд буй асуудлууд, тэдгээртэй холбоотой эрх зүйн зохицуулалтын шалтгаан, үр дагаврыг үнэлэх, сайжруулах, боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагыг тогтоосон аргачлалын дагуу судалж, үнэлэлт, дүгнэлтийг тайланд тусгалаа.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон тухайн хууль тогтоомжийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох ёстой. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлохдоо “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д тусгасан дараах үндэслэлүүдиийн хүрээнд авч үзсэн.

Аргачлалын заалт	Шалтгаан
3.2.1 тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал;	Эрчим хүчний тухай хуулийн зохицуулалттай хамааралтай шүүхийн практикт үүсч буй асуудлууд, голлох маргаанууд, шийдвэрлэсэн байдал зэргийг салбарын хэмжээнд судалгаагаар нэгтгэн харуулж, зохих үнэлэлт дүгнэлт өгөх;
3.2.2 хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, эсхүл нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эсхүл тэдгээрээс улбаалсан сөрөг үр дагавар бий болсон бол;	• Эрчим хүчний салбарт тулгамдаж буй дараах асуудлуудын хүрээнд хууль эрх зүйн зохицуулалтын үр дагаврыг үнэлэх; - Хэтийн төлөвлөлт, шинэ эх үүсвэр, хүчин чадал бий болгох; - Үнэ тариф, санхүүгийн алдагдал, өр төлбөр, хөрөнгө оруулалт - Компаниудын өмчлөл, засаглал, үр ашиг; - Эрчим хүчний зах зээл, өрсөлдөөний - Хэрэглэгчийн үйлчилгээний чанар, стандарт, хувийн өмчлөлийн сүлжээ - Мэдээллийн ил тод, нэгдмэл байдал - Төрийн байгууллагуудын эрх хэмжээ, уялдаа холбоо; • Хуулийн зүйл, заалт бүрийн хэрэгжилтийг үнэлснээр дараах нөхцөл байдлууд байгаа эсэхийг илрүүлэх; - Шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдал; - Тодорхойгүй, ойлгомжгүй, хэт ерөнхий зүйл заалтууд байгаа эсэх; - Чухал ач холбогдолтой гол харилцаануудыг дүрэм, журмаар зохицуулахаар заасан; - Цаг үе, нийгмийн хөгжлийн өөрчлөлттэй хамааралтай шинээр болон шинэчлэн тогтоох харилцаанууд бий болсон;
3.2.4 нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан;	Эрчим хүчний салбарын шинэчлэл, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар салбарын оролцогч талуудаас ирүүлсэн саналуудыг агуулга, зүйл, заалтаар ангилан нэгтгэж,үнэлэх

1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Эрчим хүчний тухай хууль нь эрчим хүчний салбарын компаниуд ашгийн төлөө, бие даасан компаниуд бий болон төлөвших, эрчим хүч үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэл үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа бүрээр төрөлжсөн, мэрэгшсэн үйл ажиллагаа явуулах, тогтоосон нөхцөл, шаардлага, үйлчилгээний түвшинг хангах чиглэлд тодорхой ахиц дэвшлүүд бий болж, салбар бүтцийн хувьд тогтворжсон үйл ажиллагаатай болсон нь хуулийн эерэг үр дүн юм.

Мөн хуулиар тогтоосон зарим чухал чиг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа хэдий ч Эрчим хүчний зохицуулах байгууллага институцийн хувьд төлөвшиж, эрчим хүчний салбар болон бизнес эрхлэгч, хэрэглэгчийн төлөөллийг хангасан бүтцээр тогтвортой ажиллаж, үнэ тариф, зохицуулалтын механизмуудыг тогтоон хэрэгжүүлж байгаа нь хууль хэрэгжих хугацаанд бий болсон сайн үр дагавар гэж үнэлж болохоор байна.

Эрчим хүчний салбарын хэмжээнд нэгдмэл байдлаар хүлээн зөвшөөрч, тодорхой тоо баримт, үр дагавраар илэрч байгаа, нэн даруй шийдвэрлэх шаардлагатай гэж тодорхойлсон дараах тулгамдсан асуудлууд байна.

Тулгамдсан асуудал	Илэрч буй үр дүн
1. Одоо болон ирээдүйд үүсэх хэрэгцээт хүчин чадлыг дотоодын эх үүсвэрээс хангах боломжгүй, чадлын дутагдалд орсон. Эрчим хүчний хүрэлцээ хангалтгүй болж, эрчим хүчний хязгаарлалт хийх нөхцөл үүссэн.	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал 2024 онд 1832МВт, дотоодын эх үүсвэрээс хангах чадал 1389МВт, импортоор хангах чадал 300МВт, чадлын дутагдал 143МВт байхаар байна. Чадлын дутагдал 2026 онд 289МВт хүрч нэмэгдэхээр байна.
2. Эрчим хүчний салбар, салбарын компаниуд санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаагаас өр төлбөр нэмэгдэж, санхүүгийн чадавхийн зохистой харьцаа, шалгуурыг хангах боломжгүй. Энэ нь компани бие даан хөрөнгө оруулах, хөрөнгө татах боломжийг хязгаарладаг.	Эрчим хүчний салбарын 2023 оны санхүүгийн алдагдал 98 тэрбум төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 355 тэрбум төгрөг байна. Сүүлийн 5 жилийн хуримтлагдсан дүнгээр нийт 806 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Салбар санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа шалтгаан нь: Цахилгааны бодит өртөг 2024 оны байдлаар 285 төгрөг/кВт.ц байхад борлуулалтын дундаж үнэ 216 төгрөг/кВт.ц, бодит өртгөөс 24 2%-аар доогуур; Дулааны бодит өртөг 69.8 мян.төг/Гкал байхад борлуулалтын дундаж үнэ 39.8 мян.төг/Гкал, бодит өртгөөс 51.4% доогуур байна.
3. Эрчим хүчний компаниуд төрийн өмч давамгайлсан засаглалтай, үр ашигт чиглэсэн менежмент, арга барил сул. Үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөшүүрэг хангалттай биш.	Эрчим хүчний үнэ тариф бодит өртөгтөө хүрээгүй нь санхүүгийн алдагдалтай ажиллах суурь шалтгаан болж байгаа хэдий ч нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ногдох өртгийг

	бууруулах, үр ашгийн нэмэгдүүлэх чиглэлд хангалттай хүчин чармайлт гаргадаггүй. Зах зээлд өрсөлдөөний механизмууд бүрдээгүй, салбарын хэмжээнд бүрдсэн орлогоос нэг тогооны зарчмаар хуваарилалт хийгдэх учраас аль болох их зардал батлуулах сонирхол үүсч байдаг.
4.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах хууль эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдээгүй.	Нэгж бүтээгдэхүүн борлуулалтын өртөг олон улсын жишгээс доогуур, тухайн салбарт хөрөнгө оруулснаар өгөөж хүртэл баталгаа байхгүй. Бодлогын тогтворгүй байдал нь хөрөнгө оруулалтын эрсдлийг нэмэгдүүлдэг.
5.Хэрэглэгчийн үйлчилгээний чанар стандарт хангалтгүй, мэдээллийн хүртээмж муу, ил тод биш	Эрчим хүчний чанар, үйлчилгээний хүртээмж, хурдан шуурхай байдалд хэрэглэгч сэтгэл ханамжгүй байдаг. Үйлчилгээний хүнд суртал, мэдээлэл ил тод биш, мэдээлэлд хүрэх боломж хязгаарлагдмал зэрэг шинж байдал нь хэрэглэгчийн сөрөг хандлагыг нэмэгдүүлдэг.
6. Хувийн шугам сүлжээ, хэрэглэгчийг шинээр холбохтой холбоотой үүсдэг харилцаа, өмчлөлийн болон төлбөрийн маргаан	Хувийн хөрөнгөөр шугам сүлжээ барих, тэдгээрт бусад хэрэглэгчийг холбохтой холбоотой түгээх компани болон хэрэглэгчийн түвшинд маш олон зөрчилтэй асуудлууд үүсч байгааг дэлгэрэнгүй тайлбарласан.

Салбарын хэмжээнд хэрэгжилт хангалтгүй, доголдолтой, сөрөг үр дагавар үүсгэж буй эдгээр асуудлуудтай холбоотой хуулийн дараах бүлэг, зүйл, заалтуудад үнэлгээ хийхээр хамрах хүрээг тогтоосон.

Хуулийн бүлэг	Хуулийн зүйл, заалт
Хоёрдугаар бүлэг: Төрийн байгууллагын бүрэн эрх	4.1.Улсын Их Хурал эрчим хүчний талаархи төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ. 5.1.1. эрчим хүчний талаархи төрийн бодлого, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; 6.1.1. эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх; 6.1.2. эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлогыг боловсруулах;
Гуравдугаар бүлэг: Тусгай зөвшөөрөл	12.2.Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах хороо олгоно.

	12.5.Иргэн, хуулийн этгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор 1.5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.
Дөрөвдүгээр бүлэг: Үнэ тариф	9.1.4.тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх; 9.1.5.эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох; 9.1.16.эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам батлах; 9.1.17.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах; Хуулийн 26 дугаар зүйл. Тариф тогтоох зарчим
Тавдугаар бүлэг: Хангагч хэрэглэгчийн харилцаа	Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт: стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах; Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дах заалт: “гэрээнд заасан үйлчилгээний түвшинг хангах; Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт: “стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хангагдах эрхтэй; Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9 дах заалт: Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй. Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дах заалт: Түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос бусад хэрэглэгчийн холбуулах; Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дах заалт: Өөрийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан эрчим хүч бусдад дамжуулах, түгээх, тухайн хангагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах;
Салбарын оролцогч талуудын эрх хэмжээ, үүрэг хариуцлага, харилцан уялдаа холбоо	УИХ, ЗГ, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн үндэсний төв, Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөл, Тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэсэн хүрээнд үнэлгээ хийсэн.

1.3 Шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, томьёолох, харьцуулах хэлбэрийг сонгох

Тухайн хуулийн зүйл, заалтаар зохицуулагдаж буй харилцааны онцлог, хэрэгжилтийг хэрхэн хэмжиж, үнэлэх боломжтой эргээс хамаарч шалгуур үзүүлэлт харилцан адилгүй байж олно. Аргачлалд тодорхойлсон шалгуур үзүүлэлтүүдээс зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөхүйц байдал, практикт нийцсэн байдал гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг голчлон хэрэглэж үнэлгээг хийсэн.

Мөн тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр хэрэгжилтийн үр нөлөөг тодорхой, оновчтой илэрхийлэхэд чиглүүлэх таамаглал, асуумжийг томьёолсон.

Хуулийн хэрэгжилтийн харьцуулалтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын хэлбэрийг нийтлэг сонгосон.

Үнэлэх үе шатанд хуулийн бүлэг, заалт бүрээр тодорхойлсон болон томьёолсон шалгуур шалгуур үзүүлэлтүүд, харьцуулах хэлбэрийг нэгдсэн хүснэгт байдлаар харах боломжтой.

1.4 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Эрчим хүчний хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ дараа мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах аргыг сонгохоор төлөвлөсөн.

	- Эрчим хүчний салбарын мэргэжилтэн, экспертүүдтэй биечлэн уулзах, хэлэлцүүлэг хийх; - Эрчим хүчний салбарын хуулиудын шинэлэлд цахим хуудсаар асуулга, санал авах; - Эрчим хүчний салбарын байгууллагуудаас хуулийн хэрэгжилт, өөрчлөлт оруулах талаар албан бичгээр санал авах; - Эрчим хүчний салбарын төрийн байгууллагууд болон компаниудаас тодорхой статистик тайлан, судалгаа, мэдээллүүдийг цуглуулах; - Салбарын тодорхой чиг үүргийн байгууллагуудаас тайлан танилцуулга авах, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах; - Хуультай холбоотой шүүх дээр үүсдэг маргаанууд, гол асуудлуудын талаар хуулийн мэргэжлийн холбоо, хуульчдаас санал, зөвлөмж авах; - Эрчим хүчний салбарын компаниудын цахим систем, веб хуудаснаас мэдээлэл авах;

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

2.1 Үр дүнгийн үнэлгээний хүрээнд цуглуулсан мэдээлэл, боловсруулалт

Эрчим хүчний салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бодитой үнэлэх, хуулийн зүйл заалтуудын хэрэгжилтийн үр дагаврыг тодорхой нотлогдсон тоо баримтаар илэрхийлэх зорилгоор нийт 24 нэр төрлийн мэдээллүүдийг төрийн байгууллагууд, салбарын компаниудаас гаргуулан авах ажлыг зохион байгуулсан.

Байгууллага компаниудаас ирүүлсэн мэдээллийг нягтлан шалгах, үнэн бодит байдлыг хянах, бусад эх сурвалжуудтай харьцуулах зэргээр өгөгдөлд боловсруулалт хийх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мэдээлэлд хийсэн боловсруулалт дүн шинжилгээ, тайлан графикуудыг хуулийн зүйл заалтын хэрэгжилтийн үнэлгээний зохих хэсэгт нотломж болгон ашигласан болно.

№	Мэдээлийн нэр	Хамрах хугацаа
Эрчим хүчний яам		
1	Цахилгаан эрчим хүчээр хангагдахаар техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгохыг хойшлуулсан, олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал /1МВт-аас дээш/	2022-2024он
2	Дулааны техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал (1 Гкал/цагаас дээш)	2022-2024 он
Эрчим хүчний зохицуулах хороо		
1	Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сунгахтай холбоотой гарсан шүүхийн маргааны судалгаа	2019-2024
2	Эх үүсвэрүүдийн цахилгааны суурилагдсан хүчин чадал, өөрчлөлтийн хамт	2014-2024он
3	Цахилгаан эрчим хүчний хэрэглээний болон дулаан түгээлтийн мэдээлэл	2014-2024он
4	Эрчим хүчний барилга байгууламж буюу шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олгосон судалгаа, үүнээс баригдсан эх үүсвэрийн судалгаа	2014-2024он
Диспетчерийн үндэсний төв		
1	Эх үүсвэрүүдийн өвлийн их, зуны бага ачаалалд оролцсон судалгаа (хоногийн ачааллын графикаар)	2023 он
2	Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгааны хэрэглээг хангахад эх үүсвэрүүдийн оролцсон судалгаа, энергиэр	2019-2023 он
3	Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчтэй байгуулсан худалдах, худалдан авах гэрээний судалгаа	2013-2024

№	Мэдээлийн нэр	Хамрах хугацаа
Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд		
1	Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, батлагдсан үнэ тарифын судалгаа	2022, 2023,2024ХБГ
2	Үндсэн тоноглолын насжилтын судалгаа	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
3	Цахилгаан дамжуулах,түгээх сүлжээнээс техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгохыг хойшлуулсан, олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал /1МВт-аас доош/	2022-2024 он
4	Дулааны техникийн нөхцөл авсан хүлээгдэж буй хэрэглээний чадал болон техникийн нөхцөл олгох боломжгүй байгаа хэрэглэгчийн тоо, чадал (1 Гкал/цагаас доош)	2022-2024 он
5	Техникийн өргөтгөл шинэчлэл, хүчин чадал нэмэгдүүлэх зорилгоор гадны банкнаас авсан зээлийн талаарх мэдээлэл	Зээлийг нь төлж дуусаагүй байгаа төслүүдийн мэдээлэл
6	Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, талаар 3 - 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	2021-2023
7	Хэрэглэгчдээс ирсэн гомдол, саналын тоо	(2022,2023,2024 ХБГ)
8	Цахилгаан дулааны эрчим хүчний чанарын шаардлага хангаагүйгээс үүдэн хэрэглэгчид учирсан хохирлын талаар статистик тоо	(2022,2023,2024 ХБГ)
9	Хамгаалалтын зурвас зөрчсөн иргэн, хуулийн этгээдүүдийн статистик тоо, судалгааг газрын гэрчилгээтэй, гэрчилгээгүй эсэх судалгаа	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
10	Цахилгаан дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлтийн талаарх мөрдөж ажиллаж байгаа дүрэм журам, норм ба дүрэм, стандартын нэр	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх
11	Эрчим хүчний хуулийн 29.1.9 дах заалт, 30.1.10 дах заалт, 30.1.11 дах заалттай хамааралтай иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, санал, маргааны талаар судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
12	1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэн, хуулийн этгээд хооронд үүссэн шүүхийн маргааны судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
13	1.2 Хамгаалалтын зурвастай холбоотой гарсан шүүхийн маргаан, шийдвэрлэлтийн байдал	(2022,2023,2024 ХБГ)
14	Эрчим хүчний тухай хуулийн 30.1.8 дах заалтын дагуу засвар үйлчилгээ хийдэггүй хэрэглэгчдийн судалгаа, гарч буй хүндрэлүүдийн тайлан	2024 оны 3 дугаар улирлын байдлаар
15	Орлого цуглуулалт, өр төлбөртэй хэрэглэгчдийн статистик судалгаа	(2022,2023,2024 ХБГ)
16	Цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй байгаа айл өрх, ААН-н тоо	2022-2024 он
17	Ухаалаг тоолуурын судалгаа	2024 оны байдлаар

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

3.1 Шүүхийн практикт үүсч буй маргаан хянан шийдвэрлэлт

Журмын 3.2.1 заалт: *тухайн хууль тогтоомжийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл гарах, ойлгомжгүй, зөрчилтэй зохицуулалттай байх, тэдгээр нь цаашид тухайн харилцаанд сөрөг үр дагавар үүсгэх шинжтэй байвал;*

Эрчим хүчний салбарын харилцаанд сүүлийн жилүүдэд үүссэн бүх төрлийн шүүхийн маргааныг судлах нь Эрчим хүчний тухай хууль нь тухай салбарын харилцааг бүрэн дүүрэн, оновчтойгоор зохицуулж чадаж байгаа эсэх, тухайн хуулийг хэрэгжүүлэх явцад түүний зохицуулалтууд бодит байдалтай нийцээгүй, тухайн харилцааг зохицуулах боломжгүй, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй, эдгээрээс үүдэн аливаа сөрөг үр дагавар бий болсон, тухайн хуулийг шүүхийн практикт хэрэглэн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд нэг мөр ойлгомжтой биш, хоорондоо зөрчилтэй зохицуулалтууд байгаа эсэх, эдгээр нь салбарын харилцаанд аливаа сөрөг үр дагаврыг бий болгож байгаа эсэх болон бусад хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг илрүүлэх зорилготой юм.

Эрчим хүчний салбарт сүүлийн 3 жилд гарсан маргааны талаарх судалгааг салбарт үйл ажиллагаа явуулж буй 45 байгууллагаас авлаа. Судалгаанаас үзэхэд Эрчим хүчний зохицуулах хорооны оролцсон 30 маргаан, бусад байгууллагууд оролцсон 41 шүүхийн маргаан үүссэн байх ба 106 маргааныг шүүхийн эвлэрүүлэн зуучлахаар шийдвэрлүүлсэн байна. Судалгаанд 34 байгууллагын зүгээс ямар нэгэн шүүхийн маргаан үүсээгүй хэмээн хариу ирүүлсэн байна.

Үүссэн нийт 177 маргааны 133 нь буюу 75 гаруй хувь нь дулааны эрчим хүчний харилцаанд үүссэн маргаан байна. Энэ нь дулааны салбарын харилцааг хуулиар хангалттай зохицуулагдаагүй, одоо байгаа зохицуулалтууд нь бодит байдалд нийцээгүй, хуулийн хэрэгжилтийг хангах механизм сул байгаа зэргийг тодорхой харуулж байна.

Захиргааны хэргийн маргаан

Эрчим хүчний зохицуулах хорооны оролцсон 30 маргааныг Захиргааны хэргийн шүүхээр сүүлийн 5 жилийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.[1] Үүний тэн хагас нь тусгай зөвшөөрөл хүчингүй болгосонтой холбоотой маргаан, нөгөө хагас нь үнэ тарифын зохицуулалттай холбоотой, мөн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөөгүйг гаргуулахтай холбоотой маргаанууд байна.

Эрчим хүчний зохицуулах хороо дээрх маргаануудад хариуцагчаас оролцсон байх бөгөөд эдгээр нь бүгд захиргааны эрх зүйн маргаан байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар үүссэн маргааны 13 нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаагүй тухай дүгнэлт, тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахаас татгалзаж шийдвэрлэсэн Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэр буюу захиргааны актыг хүчингүй болгуулах, эсхүл илт хууль буст тооцуулах шаардлага бүхий маргаанууд байна.

[1] Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан судалгаа, 2024 он

Захиргааны хэргийн шүүхээс эдгээр маргаануудыг бүгдийг нь хариуцагч Эрчим хүчний зохицуулах хорооны талд шийдвэрлэсэн байх буюу нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны гаргаж буй шийдвэрүүд нь хууль, эрх зүйн үндэслэлтэй гарч байгааг илтгэн харуулж байгаа хэдий ч нэг ижил асуудлаар шүүхийн маргаан их гарч байгаа нь салбарын оролцогч талуудын эрх ашгийг хангах, хуулийн дагуу хүлээж буй үүрэг хариуцлага, шаардлагыг зөв зүйтэй хэрэгжүүлэх талаар мэдээлэл, чиглэл, зөвлөгөөг эрх бүхий байгууллагын зүгээс өгөх, хуулийн хэрэгжилтийг сурталчлах, салбарын хөгжлийн бодлогыг нэгдмэл, тогтвортой, нээлттэй буюу оролцогч талууд оролцоог хангахуйцаар явуулах зэрэг ажлууд дутмаг хийгдэж байж болзошгүй байна.

Үлдсэн 2 маргаан нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 725 дугаар тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.1.12 дахь заалт болон 2, 3 дугаар бүлгүүдийг хүчингүй болгуулах тухай хууль бус захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргаан байна. Тухайн Дүрмийн заалтыг Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс хууль бус тул хүчингүй болгож шийдвэрлэсэн байх бөгөөд одоогоор тухайн маргаан нь эцэслэн шийдвэрлэгдээгүй давж заалдах болон хяналтын шатанд хянагдаж байна.

Эдгээр шүүхийн маргаануудаас онцлох маргаан нь захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах тухай маргаан байх бөгөөд энэ нь хуулийн хэм хэмжээг давсан дүрэм, журмууд гарсаар байгаагийн нэг тод жишээ болж байна.

	Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгуулах тухай маргаан
	Энэхүү маргаанаар нэхэмжлэгч ДЦ ХХК нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 181 дүгээр “Дүрэм батлах тухай” тогтоолын хавсралтаар батлагдсан Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийн 5.2.12-т “дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл олгоход дулааны эрчим хүчний тооцоот ачаалал 20 Гкал/ц-аас багагүй байх” гэсэн заалтыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох, мөн Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 725 дугаар тогтоолоор батлагдсан “Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэм”-ын 5.1.12-т заасан “Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хувьд Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцсэн, дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал нь 20 Гкал/ц-аас багагүй, дулаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэсэн байх” гэсэн заалтыг хууль бус тул хүчингүй болгуулах шаардлага гаргасан байна.

Маргаан нь дулааны эрчим хүчний тооцоот ачаалалтай холбоотой шаардлагууд, тусгай зөвшөөрөл олгох нөхцөлүүдтэй холбоотойгоор үүссэн байна.

Эрчим хүчний зохицуулах хорооноос дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал нь 20Гкал/цаг-аас бага байх нь эдийн засгийн үр ашиг гаргах боломжгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны зардлыг хааж чадахгүй тул ийнхүү хязгаар тогтоох нь үндэслэлтэй гэж үзэж Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрэмдээ тусгаж өгсөн боловч нэхэмжлэгчийн зүгээс тухайн заасан хэмжээ нь үндэслэлгүй, хэт өндөр шалгуур тавьж, бизнесийн орчныг хязгаарлаж байна хэмээн маргасан байна.

Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс маргааныг хянан хэлэлцээд нэхэмжлэгчийн зарим шаардлагыг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгосон байна. Тодруулбал, нэхэмжлэгчийн хоёр дахь шаардлагыг хүлээн авч ханган Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийн 5.1.12-т заасан “Дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хувьд Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтад нийцсэн, дулааны эрчим хүчний хэрэглэгчдийн тооцоот ачаалал нь 20 Гкал/ц-аас багагүй, дулаан түгээх сүлжээ үүсгэж өмчлөлдөө бүртгэсэн байх” гэсэн заалтыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрчим хүчний зохицуулах хорооны гаргасан хэм хэмжээний актын хуульд нийцсэн эсэхийг тодорхойлохын тулд холбогдох хууль, журмыг харгалзан үзсэн байна. Эрчим хүчний тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох эрх Хороонд байдаг тул шүүхийн шийдвэрт энэ эрхийг зөрчсөн эсэх буюу хуулиар олгосон эрхээ хэтрүүлэн хэрэглэсэн эсэхийг мөн шалгасан байна.

Шүүхээс тухайн заалтыг хүчингүй болгосон хууль, эрх зүйн гол үндэслэлүүд нь:	
	Аливаа хэм хэмжээний акт нь хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нийцээгүй байхын зэрэгцээ уг актын улмаас маргаж буй этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн бол шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэх хууль зүйн үндэслэлтэй
	Эрчим хүчний зохицуулах хороо нь тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох эрхтэй этгээд мөн боловч энэхүү эрх хэмжээг хэм хэмжээний акт гаргах хэлбэрээр хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэхээр байна. Учир нь Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасан байх тул тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээний акт гаргах боломжгүй байна
	Дулаан түгээх дамжуулах тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудал Зөвшөөрлийн тухай хуулиар олгох тусгай зөвшөөрлүүдийн жагсаалтад багтсан байх тул уг тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцаанд мөн хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасан хязгаарлалт үйлчлэхээр байна
	Тусгай зөвшөөрөл олгох эсэхэд хязгаарлалт болохуйц нөхцөл шаардлагыг тогтоож, журамласан нь Зөвшөөрлийн тухай хуулийн дээрх заалт болон Захиргааны ерөнхий хуулиар тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх гэсэн шаардлагад нийцсэн гэж үзэхээргүй байна.

Тухайн шийдвэрийн үр дагаварт нь тусгай зөвшөөрөл олгох үйл явц илүү уян хатан болох боломжтой боловч сөрөг тал нь чанар, аюулгүй байдалд нөлөөлж магадгүй байдал үүсч болох юм.

Шүүхийн шийдвэр нь Зөвшөөрлийн тухай хууль болон Эрчим хүчний тухай хууль хоорондын зохицуулалтын нийцлийг шалгаж, төрийн байгууллагын эрх хэмжээ хэтрэхээс сэргийлсэн байна.

Цаашид тусгай зөвшөөрлүүдийн шаардлагуудыг бодит байдалд нийцүүлэх, бизнесийн орчныг дэмжихэд анхаарах, тусгай зөвшөөрлийн шалгуур болон үйл явцыг илүү ил тод, хүртээмжтэй болгох, түүнчлэн энэ төрлийн хязгаарлалт тавих бол дүрмээр бус зөвхөн хуулиар зохицуулалт хийх, Монгол Улсын бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай байна.

Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн маргаануудаас Эрчим хүчний зохицуулах хороо оролцоогүй маргаан ганцхан байгаа нь Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-д холбогдуулан үүссэн маргаан байна. Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлээр зохицуулагддаг эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвас зөрчигдсөний улмаас эрх ашиг нь зөрчигдсөн тухай маргаан үүссэнийг Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн ч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс хэргийн нотлох баримт, нөхцөл байдлуудыг дутуу үнэлсэн гэсэн үндэслэлээр анхан шатаар дахин хянан шийдвэрлэхийг даалгаж буцааж шийдвэрлэсэн байх бөгөөд одоогоор хэрэг эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Үүнээс үзэхэд эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргахдаа шугам сүлжээний хамгаалалтын зурваст тавигдах шаардлагыг хангаагүйн улмаас иргэдийн эрх ашгийг хохироосон байж болзошгүй байх тул тухайн шаардлагыг амьдралд хэрэгжүүлэхэд стандарт, норм дүрэмд зөв зүйтэй тусгах, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, барилга болон инженерийн шугам сүлжээний төлөвлөлтөд хяналт, зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Иргэний маргаан

Иргэний шүүхээр шийдвэрлэгдсэн эрчим хүчний салбарын маргааны тухайд 2024 онд Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой, тухайлбал энэхүү гэрээний дагуу цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө төлөөгүйн улмаас үүдэн гарсан 75, 2023 онд 37 маргаан гарсан байна[2].

Үүний дийлэнх нь дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө төлөөгүй маргаан зонхилж байна. Үүнээс үзэхэд дулааны эрчим хүчний төлбөр төлөх хөшүүрэг бий болгох, төрөл бүрийн арга хэрэгслийг ашиглах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Нөгөө талаасаа, дулааны эрчим хүч нь өвлийн нөхцөлд тасралтгүй хангагдах шаардлагатай байдаг тул түр салгалт хийх боломжгүй байдаг нь төлбөрөө төлөхгүй байх, өр их хэмжээгээр хураагдах, түүнийг шүүхээр албадан төлүүлэх нөхцөл болж байна.

[2] https://shuukh.mn/cases/1/1

Эдгээр нөхцөл байдлууд нь дулааны салбарын эрх зүйн зохицуулалт дутмаг, хуулийн хэрэгжилтийг хангах механизмыг бий болгох хэрэгцээ шаардлага бий байгааг харуулж байна.

Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.

Эрчим хүчний тухай хуулийн 30.1.10 дахь заалтад “түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах” гэсэн заалттай холбоотойгоор сүүлийн 3 жилийн хугацаанд 3 маргаан үүсч Иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна. Эдгээрийн хоёр нь хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талд, нэг нь хэрэглэгчийн талд шийдэгдсэн байна.

Эрчим хүчний шугам сүлжээ, эд хөрөнгөд гэм хор учруулснаас үүдсэн эд хөрөнгийн хохирол гаргуулах тухай буюу Эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.12 дахь заалтад “эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах.

Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй” гэсэн заалттай холбоотой 10 гаруй маргааныг 2024 онд иргэний хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн байна[3].

Хуулийн тодорхой нэг заалттай холбогдуулан маргаан байнга үүсч байгаа нь тухайн заалтын зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, зайлшгүй зохицуулах шаардлагатай харилцааг бүрэн гүйцэд зохицуулаагүй, талуудын эрх ашгийг бүрэн гүйцэт харгалзан үзээгүй, эсхүл аль нэг талын эрх ашгийг нэг талыг барьж зохицуулсан байх магадлалтай тул цаашид энэхүү зохицуулалтыг оролцогч талуудын эрх ашгийг жигд хангасан, бүрэн гүйцэд зохицуулалттай болгон нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

[3] https://shuukh.mn/cases/1/1

3.2 Эрчим хүчний салбарын тулгамдсан асуудлууд, эрх зүйн үр дагавар

Анх 2001 онд батлагдсан эрчим хүчний тухай хууль нь эрчим хүчний салбарын босоо удирдлагатай төвлөрсөн тогтолцоог хэвтээ чиглэлд үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрлүүдийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бие даасан компаниуд бий болох, эрчим хүчний үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, үнэ тариф, хэрэглэгчийн харилцааг зохицуулах хараат бус зохицуулах байгууллага байгуулах томоохон реформуудын хийхэд эрх зүйн суурь зохицуулалт болсноороо ач холбогдолтой байна.

Мөн диспетчерийн зохицуулалт, арилжааны үйл ажиллагааг зааглаж, зохицуулалттай ба зохицуулалтгүй хангалт, аж ахуйн харилцааны дүрэм, холболтын журам гэх зэрэг шинэ ойлголтуудыг томьёолсноор цаашид зах зээлийн зарчмаар, өрсөлдөөний орчныг бүрдүүлэх суур нөхцлүүдийг хуульд тусгаж өгсөн байгаа нь салбарын хөгжлийг урт ба дунд хугацаанд харж гаргасан хууль гэж дүгнэж болохоор байна. Салбарын үндсэн харилцаануудыг бүхэлд нь сайн харж зохицуулсан, ерөнхий агуулгаараа харьцангуй сайн хууль гэж дүгнэсэн.

Эрчим хүчний тухай хууль нь эрчим хүчний салбарын компаниуд ашгийн төлөө, бие даасан компаниуд бий болон төлөвших, эрчим хүч үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэл үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах үйл ажиллагаа бүрээр төрөлжсөн, мэрэгшсэн үйл ажиллагаа явуулах, тогтоосон нөхцөл, шаардлага, үйлчилгээний түвшинг хангах чиглэлд тодорхой ахиц дэвшлүүд бий болж, салбар бүтцийн хувьд тогтворжсон үйл ажиллагаатай болсон нь хуулийн эерэг үр дүн юм.

Мөн хуулиар тогтоосон зарим чухал чиг үүргүүдийн хэрэгжилт хангалтгүй байгаа хэдий ч Эрчим хүчний зохицуулах байгууллага институцийн хувьд төлөвшиж, эрчим хүчний салбар болон бизнес эрхлэгч, хэрэглэгчийн төлөөллийг хангасан бүтцээр тогтвортой ажиллаж, үнэ тариф, зохицуулалтын механизмуудыг тогтоон хэрэгжүүлж байгаа нь хууль хэрэгжилтийн сайн үр дагавар юм.

Гэхдээ эрчим хүчний салбарын шинэчлэл 2001 онд хийгдсэн далайцтай шинэчлэлтээс хойш томоохон ахиц гараагүй, дараагийн шинэ реформын бодлогыг тодорхойлох болсон энэ цаг үед эрчим хүчний тухай хуулийн хэрэгжилтэд тулгарч буй асуудлууд, цаашид хөгжлийн бодлого, цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, сайжруулах шаардлага зүй ёсоор бий болж байна.

Монгол улс эрчим хүчний хэрэглээний эрчимжилт өндөр бус, 1.7ГВт суурилагдсан хүчин чадалтай, жижиг систем боловч өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээгээ бие даан хангаж чадахгүй, эрчим хүчний дутагдалд орж, хэрэглэгчдийг хязгаарлах түвшинд хүрсэн байгаа нь туйлын ноцтой асуудал юм.

Үүсээд буй нөхцөл байдал нь бодлого төлөвлөлт, хэрэгжүүлэлт, эдийн засаг санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын орчин, тогтвортой байдал, улс төрийн оролцоо, нөлөө зэрэг хүчин зүйлээс хамаарч байгааг эрх зүйн үр дагавар талаас нь судалж, үнэлэх, зохих өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлагай байна.

Тухайлбал салбарын санхүү эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилтод нийцсэн зохицуулалт хийгдэхгүй, маш удаан хугацаанд үргэлжилж урхагшсан олон асуудлуудыг бий болгосон байна. Тодруулвал үйлдвэрлэгчээс хэрэглэгч хүртэл бүх шатанд үнэ тарифыг зохицуулах байгууллага хянаж, үнэ тариф тогтоох монополь зах зээлийн загвар хэрэгжиж байгаа бөгөөд эцсийн хэрэглэгчийн үнэ тариф бодит өртөг зардлыг нөхөхүйц түвшинд тогтоогдохгүй байгаа нь салбарт үүсээд байгаа олон асуудлуудын суурь шалтгаан болж байна.

Асуудлуудыг нэгтэн томьёолбол:

Хэрэглээний өсөлтийг хангахуйц эх үүсгүүр, шугам сүлжээг барьж байгуулах хөрөнгийн эх үүсвэр байхгүйгээс эрчим хүчний салбар 2022 оноос чадлын дутагдалд орж, оргил ачааллын үед хэрэглэгчийг хэсэгчлэн хязгаарлах нөхцөл үүссэн.	Зах зээлийн багтаамж байгаа хэдий ч, эцсийн хэрэглэгчийн үнэ өртгөө нөхөх түвшинд хүрээгүй байгаа нь хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах шийдвэр гаргахгүй байх үндсэн шалтгаан болж байна.
Эрчим хүчний салбарын компаниуд санхүүгийн алдагдалтай ажиллаж, салбарын дүнгээр сүүлийн 5 жилийн дүнгээр 806 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байна. Энэ нь компаниудын төлбөрийн чадварын индекс буурч, өр төлбөр нэмэгдэх нөхцлийг үүсгэсэн.	Эх үүсвэр, дамжуулах түгээх компаниуд санхүүгийн алдагдалтай, ихээхэн хэмжээний өр төлбөртэй байгаа нь хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт татах боломжийг хязгаарласан. Эрчим хүчний компаниуд бие даан хөрөнгө оруулах боломжгүй байгаагаас олон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгөөр тулгамдсан техникийн шинэчлэлтүүдийг хэрэгжүүлж байгаа хэдий ч энэ нь зээлийн эргэн төлөлттэй холбоотой ирээдүйд үүсэх санхүүгийн ачааллыг нэмэгдүүлж байна.
Эрчим хүчний үнэ тариф бодит өртөгтөө хүрээгүй нь санхүүгийн алдагдалтай ажиллах суурь шалтгаан болж байгаа хэдий ч нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ногдох өртгийг бууруулах, үр ашгийн нэмэгдүүлэх чиглэлд хангалттай хүчин чармайлт гаргадаггүй. Зах зээлд өрсөлдөөний механизмууд бүрдээгүй, салбарын хэмжээнд бүрдсэн орлогоос нэг тогооны зарчмаар хуваарилалт хийгдэх учраас аль болох их зардал батлуулах сонирхол үүсч байдаг.	Сүлжээнд шинээр холбогдох иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, эрэлт нэмэгдсээр байгаа хэдий ч эрчим хүчний хангамжийн эх үүсвэр, дэд бүтцийн хүчин чадал хүрэлцэхгүй байдлаас шалтгаалж холбож чадахгүй байгаа нь том утгаараа улс орны эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна.
Хэрэглэгчийн үйлчилгээний чанар стандарт хангалтгүй, мэдээллийн хүртээмж муу, ил тод биш	Хувийн шугам сүлжээ, хэрэглэгчийг шинээр холбохтой холбоотой үүсдэг харилцаа, өмчлөлийн болон төлбөрийн маргаан

Эрчим хүчний салбарт тулгамдаж буй эдгээр асуудлууд, үүсч буй сөрөг үр дагаврууд нь хууль эрх зүйн зохицуулалтаас хамааралтай байгаа эсэхийг тодорхойлох шаардлага байна. Салбарын хэмжээнд үүсээд байгаа асуудлуудыг үр нөлөө, ач холбогдлоор нь 6 ангилан эрэмбэлж, хуулийн зохицуулалт талаас үр нөлөөг үнэлж тайланд тусгасан.

3.2.1 Хэтийн төлөвлөлт, шинэ эх үүсвэр, хүчин чадал бий болгох

Эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангахтай холбоотой бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа нь энэ хуулийн Төрийн байгууллагын эрх, Тусгай зөвшөөрөл бүлгүүдийн зохих заалтуудаар зохицуулагдсан байна.

3.2.1.1 Бодлого төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт

Эрчим хүчний хангамж нь аль ч улс орны стратегийн чухал асуудал бөгөөд оновчтой бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт ба хэрэгжилтийг бүхэлд нь багтаасан цогц үйл ажиллагааны үр дүнд амжилттай хэрэгждэг. Монгол улсын хөгжлийн бодлогод эрчим хүчний асуудал дээрх цогц ойлголтын хүрээнд харилцан уялдаатай системтэй төлөвлөгдөж чадаж байгаа эсэх нь чухал юм.

Бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээг дараах хуулийн заалтуудын хүрээнд, зорилгодоо хүрсэн түвшин, практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтээр, төлөвлөх үе шатны хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлтийн томьёоллоор, уг асуудлын үр дүнг илэрхийлэх 3 төрлийн суурь судалгаанд үндэслэн хийсэн.

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хуулийн зүйл: УИХ-н бүрэн эрх**
		4.1.Улсын Их Хурал эрчим хүчний талаархи төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.
		Хуулийн зүйл: МУЗГ-н бүрэн эрх
		5.1.1. эрчим хүчний талаархи төрийн бодлого, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
		Хуулийн зүйл: Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
		6.1.1. эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;
		6.1.2. эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлогыг боловсруулах;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж хэрэгжүүлж байгаа байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	Өсөн нэмэгдэх хэрэглээтэй уялдаж шинэ эх үүсвэр барих төрийн бодлого оновчтой тодорхойлогдож байсан эсэх?
		Төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд интитиуц хоорондын уялдаа холбоо хангагдсан эсэх?
		Төрийн бодлого хэрэгжих санхүү, эдийн засгийн суурь нөхцлүүд хангагдсан эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Эх үүсвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын статистик мэдээлэл
		2. Эрчим хүчний хэрэглээний өсөлтийн статистик мэдээлэл
		3. Шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олгосон болон түүнээс баригдсан эх үүсвэрийн судалгаа

ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

Эрчим хүчний тухай хуулийн 4.1 заалтын хүрээнд хууль хэрэгжих хугацаанд эрчим хүчний салбарт цөөнгүй тооны бодлогын баримт бичиг гарган, хэрэгжүүлж байсан байна.

	2000-2015 он
	Монголын эрчим хүчний салбарын 2000–2020 оны мастер төлөвлөгөө Эрчим хүчний салбарын тогтвортой хөгжлийн стратеги, 2002 он Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, 2002 он, 2007 он Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2005 – 2020 он Монголын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, 2007 – 2040 он, Түлш эрчим хүчний салбарын 2008 – 2015 оны төрийн бодлого Эрчим хүчний хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, 2015-2030 он 100 000 нарны гэр” үндэсний хөтөлбөр, 1999 - 2012 он
	2015-2020 он
	Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого, 2015-2030 он Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2005 он Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, 2017 он
	2020 оноос хойш
	Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2020 он Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай, 2021 он Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2020 он Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2024 он Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө

Эдгээрээс 2015 оноос хойш бодлогын гол чиглэл болгон барьж ирсэн баримт бичиг нь Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030 он) бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 онд батлагдан гарснаар нийгэм, эдийн засгийн салбаруудын бодлого улсын хөгжлийн нэгдсэн бодлогод нэгтгэгдснээр өмнө батлагдсан бодлогууд хүчингүй болсон байна.

Хэд хэдэн бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийг хүчингүй болгосон хэдий ч тэдгээрт туссан бодлогын асуудлууд бүрэн хэмжээнд улсын хөгжлийн бодлогод тусаагүйтэй холбоотой хэрэгжилтэд зарим хүндрэл тулгарч байна. Тухайлбал Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг батлах, зохион байгуулах асуудал аль ч түвшний баримт бичигт тусгагдахгүй орхигдсон нь ойлгомжгүй, тодорхойгүй байдлыг үүсгэсэн байна.

Хэрэгжихүйц оновчтой бодлого, төлөвлөлт хийгдэж байгаа эсэхийг өмнө мөрдөгдөж байсан Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030 он), одоо мөрдөгдөж буй Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хүрээнд судалж үнэлгээ хийсэн.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого (2015-2030 он)

Энэхүү бодлогын баримт бичгийг УИХ-аас 2015 оны 63 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг 2015 онд багтаан батлан хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон байна. Засгийн газар “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”-ийг 2018 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан байна.

	Төрийн бодлогыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөлт, хөтөлбөрийг бодлого батлагдснаас хойш 3 жилийн дараа гаргасан нь нэг талаас УИХ-аас батлагдсан бодлогыг зохион байгуулах чиг үүргээ хэрэгжүүлээгүй, нөгөө талаас УИХ гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтээ хянаагүй байдал харагдаж байна.
	Төрийн бодлогыг зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргээ Засгийн газар, Эрчим хүчний яам 3 жил хойшлуулж гүйцэтгэснээр эрчим хүчний салбарын хөгжил 3 жил тодорхой төлөвлөлтгүй, урсгал байдлаар үргэлжилж ахиц дэвшил гараагүй байна. Нөгөө талаар бодлого, төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт харилцан уялдаатай байхаар чиг үүргийг хуульчилсан хэдий ч хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, харилцан хяналт тавихгүй байгааг илтгэж байгаа бодит жишээ юм.

Зөвхөн энэ тохиолдлоор хязгаарлагдахгүй Эрчим хүчний тухай хуульд ерөнхий байдлаар чиг үүрэг хүлээлгэсэн заалтуудын хэрэгжилт, түүнээс гарах үр дагаварт хариуцлага хүлээлгэх байдал сул байгаа нь нийтлэг ажиглагдаж байна.

Дараагийн шатанд Засгийн газрын 2018 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөр”-ийн төлөвлөлт ба хэрэгжилтэд үнэлгээ хийсэн.

Уг хөтөлбөрт ирээдүйд өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах зорилгоор дараах шинэ эх үүсвэр, дамжуулах сүлжээ, өртгөлийн төслүүдийг төлөвлөсөн байна.



Нийт 2215 МВт хүчин чадал бүхий эх үүсвэр шинээр барих, одоо ашиглаж станцуудыг 795МВт-аар өргөтгөхөөр төлөвлөсөн бол 2024 оны байдлаар 170МВт-ын өргөтгөл хийгдэж, сүлжээнд 150МВт хүчин чадлаар холбогдохоор ажиллаж буй Бөөрөлжүүт цахилгаан станцаас өөр шинэ эх үүсвэр холбогдоогүй байна.

ТӨЛӨВЛӨГДСӨН ШИНЭ ЭХ ҮҮСВЭР	Хэрэгжсэн байдал
ШИНЭ ЭХ ҮҮСВЭР	**2215**
ДЦС-5 (450МВт)	✗
БАГАНУУР ЦС (700МВт)	✗
ТАВАН ТОЛГОЙ ЦС (450МВт)	✗
ЭГИЙН ГОЛ УЦС(315МВт)	✗
БӨӨРӨЛЖҮҮТ ДЦС(300МВт)	✓
Аймгийн төвүүдийн дулааны станц (10 аймаг)	✗
ӨРГӨТГӨЛ	**795**
ДЦС-2 (300МВт)	✗
ДЦС-3 (250+75МВт)	✗
ДОРНОД ДЦС (50МВт)	✓
ЭРДЭНЭТ ДЦС 35МВТ	✓
ДАРХАН ДЦС 35МВТ	✓
АМГАЛАН (50МВт)	✓

Шинэ эх үүсвэр, өргөтгөл нийлээд 2030 он хүртэл 3010МВт хүчин чадал бий болгохоор төлөвлөсөн хэдий ч өнөөдрийн байдал **10.6%**-ийн хэрэгжилттэй байна.

Тогтоосон шалгуур үзүүлэлт:



Цахилгаан ба дулаан үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадлын нөөц тус бүр 10% байх,



Эрчим хүчний үйлдвэрлэлд өндөр даралтад технологийг нэвтрүүлсэн байх

ЗОРИЛТУУД БИЕЛЭЭГҮЙ

Өсөн нэмэгдэх хэрэглээг хангахад цахилгаан дамжуулах сүлжээнд 4 дэд станц өргөтгөж, 7 шугам барихаар төлөвлөж, 2024 оны байдлаар Улаанбаатар-Мандалговь чиглэлийн 220кВ-ын ЦДАШ, Чойр дэд станцын өртгөтгөл хэрэгжсэн.

ТӨЛӨВЛӨГДСӨН ЦДАШ	Хэрэгжсэн байдал
БАГАНУУР-ЧОЙР	✗
УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ	✓
БАГАНУУР-УЛААНБААТАР	✗
БАГАНУУР-ЧИНГИС-ЧОЙБАЛСАН	✗
ЧОЙР-САЙНШАНД	✗
МАНДАЛГОВЬ-АРВАЙХЭЭР	✗
ДӨРГӨН-УЛИАСТАЙ-УЛААНБААТАР	✗

ТӨЛӨВЛӨГДСӨН 220 кВ-н ДЭД СТАНЦ	
ЧОЙР ӨРГӨТГӨЛ	✓
АРВАЙХЭЭР	✗
ӨНДӨРХААН	✗
ЧОЙБАЛСАН	✗



ДЭД СТАНЦ
ӨРГӨТГӨЛ 4
ЦДАШ 7

Дунд хугацааны хөтөлбөрт үнэ тарифыг бодит өртөгт хүргэх, индексжүүлэх, хөрөнгө оруулалтын дэмжих, хувьчлалыг хэрэгжүүлэх, хангах үйл ажиллагааг зааглаж, өрсөлдөөнт зах зээлийг нэвтрүүлэх зэрэг томоохон бодлогын зорилтууд тавьсан хэдий ч өнөөдрийн байдлаар эерэг өөрчлөлт гарсан заалт байхгүй байна. Хэрэгжих хугацаа, хариуцах эзэн, шалгуур үзүүлэлт зэргийг томьёолоогүй, хэрэгжилт маш хангалтгүй.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР. 2018-2023 ОН
3.14. Бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифын тогтолцоог бий болгож, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд: 3.14.1. цахилгаан, дулааны үнэ тарифын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгож, тарифыг улирал тутам индексжүүлэх; 3.14.2. эрчим хүчний нүүрсний уурхайнуудын нүүрсний үнийг бодит өртөг ашгийн зохих түвшинд үе шаттайгаар хүргэж, индексжүүлэх. 3.15. Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: 3.15.1. төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх; 3.16. Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд: 3.16.1. төвийн бүсийн цахилгааны Нэг худалдан авагчтай зах зээлийн загвараас Үйлдвэрлэгч, хангагчийн хоорондын өрсөлдөөнт зах зээлийн загварт шилжих урьтал нөхцөлийг бүрдүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах; 3.16.2. эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бие даасан хуулийн этгээд болгон ажиллуулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд өрсөлдөөний хэлбэрээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах;

Монгол улсын урт ба дунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн урт ба дунд хугацааны бодлогын баримт бичгүүд харилцан уялдаатай, өмнөх шатны баримт бичгээ үндэслэсэн байхаар системчилсэн байна.



*5.2.3."нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, мэдээлэл, арга члал нь **нэгдмэл, уялдаатай** байж, бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг;*

*5.2.4."тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчим" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхдээ **бодлогын тогтвортой байдлыг хадгалж**, өмнө батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүн, үнэлгээнд үндэслэхийг;*

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн бодлогын баримт бичгүүд нь тодорхой шатлал хугацаатай, хангасан байвал зохих бүрдэл хэсгүүдтэй, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, тайлагнах болон батлах хугацааг тодорхой зааж процессжуулсан нь дэвшилттэй байна.

ХӨГЖЛИЙН БАРИМТ БИЧИГ	Нэр	Хугацаа (жил)	Бүрдэл	Батлах	Тайлагнах
Монгол улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг	Алсын хараа 2050	30		Дуусгавар болохоос 6 сарын өмнө;	5 жил тутамд; дуусгавар болохоос 2 жилийн өмнө;
Хөгжлийн зорилтот хөтөлбөр	Шинэ сэргэлтийн бодлого	10	Зорилго, зорилт, Санхүүгийн эх үүсвэр Үйл ажиллагааны хөтөлбөр, Тоон болон чанарын шалгуур үзүүлэлт		5 жил тутамд; дуусгавар болохоос 1 жилийн өмнө;
Улсын хөгжлийн 5 жилийн үндсэн чиглэл	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	5	Зорилго, зорилт Хүрэх үр дүн, Тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, Хөрөнгө оруулалтын хөтөлбөр	Өмнөх үндсэн чиглэлийн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас нэг сарын өмнө батална.	Дуусгавар болохоос 4 сарын өмнө;
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Монгол улсыг засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	4	Зорилго, зорилт, Төсөл, арга хэмжээг салбар, бүс нутаг, байршил, санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулсан байх үр дүнд чиглэсэн шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг тооцож боловсруулсан байх.	Өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор	Жил бүрийн 04 сарын 01-ний дотор
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө	Батлагдаагүй	1	Санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, Шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, Хариуцах эзэнтэй, Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, Төсөл арга хэмжээг эрэмбэлсэн байх	Жил бүрийн 06 дугаар сарын 01-ны дотор батлах;	Жил бүрийн 04 дүгээр сарын 01-ны дотор хэлэлцэх;
Улсын төсөв	Монгол улсын 2025 оны төсвийн тухай	1	Төсвийн орлого Төсвийн зардал Урсгал зардал Хөрөнгийн зардал	Жил бүрийн 09 дүгээр сарын 01-ны дотор өргөн мэдүүлэх	Жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах

Хуулийн дагуу УИХ-аас 4 бодлого,үндсэн чиглэл, хөтөлбөрүүдийг баталсан байна. Бодлогын баримт бичгийн системчлэлийн дагуу бодлогын баримт бичгүүд батлагдсан байдлыг схемчлэн харууллаа.



“Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт улсын хөгжлийн бодлогыг 10 жилийн үечлэлтэй 3 хэсэгт хуваж тодорхойлсон ба эрчим хүчний салбарын 2020-2030 оны хөгжлийн зорилтыг “Эрчим хүчийг дотоодын эх үүсвэрээр хангах”, “Хүлэмжийн хийг бууруулж, нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” гэж томьёолж, түүнд үндэслэн Шинэ сэргэлтийн бодлого дунд хугацааны баримт бичгийг баталсан байна.

Шинэ сэргэлтийн бодлогоор өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахад нийт 2660МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөлийг төлөвлөсөн. Мөн салбарын санхүү эдийн засгийн бие даасан байдлын хангах зорилтын хүрээнд эрчим хүчний үнэ тарифыг улирал тутам индексжүүлэх заалтыг тусгасан байна.



Улсын хөгжлийн 10 жилийн төлөвлөгөө(Шинэ сэргэлтийн бодлого)-д үндэслэн Монгол улсыг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэл батлагдсан бөгөөд нийт 874МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөлийг төлөвлөсөн.



Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсыг хөгжүүлэх 2021-2025 оны үндсэн чиглэлтэй уялдаатай төлөвлөгдөх ёстой Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг “Эрчим хүчний шинэчлэл” гэж тодорхойлон нийт 3930МВт хүчин чадал бүхий эх үүсвэр, өргөтгөл, 2000МВт хүчин чадалтай нар, салхины эрчим хүчний парк байгуулахаар төлөвлөсөн. Яриа хэлэлцээр, таамаглалын түвшинд байгаа, засаглалын 4 жилийн хугацаанд бодитой хэрэгжих магадлал нь тодорхойгүй, системийн бодит эрэлтээс давсан хүчин чадлыг төлөвлөсөн байна.



Цахилгаан хангамжийн өнөөгийн байдал:


Эрчим хүчний систем чадлын дутагдалд орсон бодит нөхцөл байдалтай холбоотой хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нэн түрүүнд дотоодын эрчим хүчний хэрэглээг хангах зорилт, түүнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг тусгасан нь хэдий ч хэрэгжилт туйлын хангалтгүй байна.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний эх үүсвэрийн хүчин чадал сүүлийн 10 жилд 503МВт-аар нэмэгдсний 51.7% буюу 260МВт-ыг сэргээгдэх эрчим хүчний нар, салхины эх үүсгүүр, 48.3% буюу 243МВт-ыг ДЦС-ын эх үүсвэр бүрдүүлсэн байна. ДЦС-4 89МВт-аар, ЭДЦС, ДДЦС тус бүр 35МВт-аар, ДБЭХС 50МВт-аар, Эрдэнэ үйлдвэр 48МВт-аар тус тус өргөтгөсөн байна.

Бүс	Эх үүсвэрийн нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
ТБНС	ДЦС-2	24	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0	24.0
	ДЦС-3	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0	198.0
	ДЦС-4	683.0	683.0	683.0	683.0	683.0	772.0	772.0	772.0	772.0	772.0
	ДДЦС	48.0	48.0	48.0	48.0	83.0	83.0	83.0	83.0	83.0	83.0
	ЭДЦС	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	71.0	71.0	71.0	71.0
	Ухаахудаг ДЦС	18	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0	18.0
	ДалДЦС	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0	9.0
	Эрдэнэт үйлдвэр ХХК	5.0	5.0	5.0	53.0	53.0	53.0	53.0	53.0	53.0	53.0
	Монцемент билдинг ХХК	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0	5.0
	ДБЭХС	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	36.0	86.0
	ДЦС-ын дүн	**1062.0**	**1,026.0**	**1,026.0**	**1,074.0**	**1,109.0**	**1,198.0**	**1,233.0**	**1,233.0**	**1,233.0**	**1,319.0**
	Салхит СЦС		50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
	Сайншанд СЦС				55.0	55.0	55.0	55.0	55.0	55.0	55.0
	Цэций			50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0
	СЦС-ын дүн		**50.0**	**100.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**	**155.0**
	Дархан НС			10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Эвридэй ферм НС			10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Нарантээг НЦС				15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0
	Тэнүүнгэрэл НЦС					15.0	15.0	15.0	15.0	15.0	15.0
	Сүмбэр НЦС					10.0	10.0	10.0	10.0	10.0	10.0
	Дезерт солар вуан ХХК НЦС						30.0	30.0	30.0	30.0	30.0
	Солар повер монголиа ХХК НЦС										15.0
	НЦС-ын дүн		**0.0**	**20.0**	**35.0**	**60.0**	**90.0**	**90.0**	**90.0**	**90.0**	**105.0**
	ТБНС-ний нийт дүн		**1,076.0**	**1,146.0**	**1,264.0**	**1,324.0**	**1,443.0**	**1,478.0**	**1,478.0**	**1,478.0**	**1,579.0**
	ТБНС-ний СЭХ-ний нийт дүн		**50.0**	**120.0**	**190.0**	**215.0**	**245.0**	**245.0**	**245.0**	**245.0**	**260.0**
	ТБНС-ний СЭХ-ний эзлэх хувь		**5%**	**10%**	**15%**	**16%**	**17%**	**17%**	**17%**	**17%**	**16%**

Цахилгаан системийн ачааллын өсөлтийг хангах эх үүсвэр нэмж холбогдоогүйгээс 2023 оноос эхлэн оргил ачааллын үед хэрэглэгчдийг хэсэгчлэн хязгаарлах нөхцөл үүссэн бөгөөд 2024 онд 143МВт хүртэл чадлын хязгаарлалт хийх таамаглалтай байна.

Системийн хэтийн төлөвлөлтийг ДҮТ ТӨХХК-аас гаргасан цахилгаан системийн ачааллын таацад үндэслэн тооцвол 2028 оны түвшинд **1278МВт,** 2030 оны түвшинд **1919МВт** хүчин чадал шаардлагатай.



Улсын хөгжлийн бодлогод эрчим хүчний салбарын бодлого урт(30 жил), дунд(5,10 жил), ойрын(1-4 жил) хугацаанд төлөвлөгдсөн байдлыг дүгнэвэл:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу 2025 оны улсын хөгжлийн төлөвлөгөөнөөс бусад бодлогын баримт бичгүүд батлагдсан байна.
Хуулийн дагуу бодлогын баримт бичгүүд батлагдсан хэдий ч бодлогын агуулга, бүрдэл, хэрэгжихүйц төлөвлөгдсөн байдал нь хангалтгүй, оновчтой бус байна.
Бодлогын суурь судалгаа, үнэлгээ, төлөвлөлт чанартай хийгдэхгүй, хийсвэр байдлаар бодлогын асуудлуудыг томьёолж байгаа нь цогц, нэгдмэл, хэрэгжихүйц байх шинж байдлыг алдагдуулж байна.
Бодлого цэгцгүй, оновчтой бус байх нь эргээд түүнийг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд олон тодорхой бус байдлыг үүсгэж, зорилго зорилтоо хангахгүй, хөгжил дэвшилд ахиц гарахгүй байх нөхцлийг бүрдүүлж байна.

Батлагдсан бодлогын баримт бичгүүдэд логикийн хувьд зөрчилтэй байгаа асуудлуудыг жишээ байдлаар дурдвал:
Эрчим хүчний эх үүсвэрийн төлөвлөлт өсөн нэмэгдэх хэрэглээний эрэлт, тооцоололд суурилж төлөвлөгдөөгүй.
Бодлогын баримт бичиг бүрт тусгасан төсөл хөтөлбөрүүд маш их зөрүүтэй буюу харилцан уялдаатай, уламжлагдан хэрэгжих шаардлагыг хангаагүй.
Ерөнхий агуулга, хэлбэрийн хувьд бодлогод нийцсэн хэдий ч зөвхөн санал санаачлага, хөгжүүлэлтийн түвшинд явж байгаа төслүүдийг заавал хэрэгжих шинж чанарыг агуулах ёстой ойрын хугацааны бодлогод ямар нэг шалгуургүйгээр тусгасан.
Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төслүүд нь засаглалын 4 жилийн хугацаанд, хэд хэдэн онуудад хэрхэн хэрэгжих нь тодорхойгүй.
Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Эрчим хүчний шинэчлэлт”-ийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй.

ДҮГНЭЛТ:
Эрчим хүчний шинэ эх үүсгүүр шинээр баригдаж сүлжээнд холбогдох хамгийн боломжит богино хугацаа 3-4 жил байдаг тул системийн төлөвлөлтийг 4 ба түүнээс дээш жилээр, маш оновчтой төлөвлөх шаардлагатай байдаг. Гэтэл бид энэ төлөвлөлтийг маш үндэслэлтэй тооцож, бодитой хэрэгжих механизмыг бүрдүүлж чадахгүй байгаагаас өнөөдрийн хямралт нөхцөл байдал үүсээд байна.
Энэ хэмжээний ачааллыг хангах шинэ эх үүсвэр хэзээ, хэрхэн баригдах нь тодорхойгүй, бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан станцуудаас аль нэг нь төслөө урагшуулах байх гэсэн таамаг төдий төсөөлөлтэй байгаа нь маш ноцтой асуудал юм.
Системийн төлөвлөлтийг таамаглал, магадлалд найдаж төлөвлөх нь туйлын буруу бөгөөд түүнээс гарах үр дагавар, эрсдлийг урьчилан тооцоолох ямар ч боломжгүй юм. Иймээс системийн хэтийн төлөвлөлт хийх, түүнийг хэрэгжүүлэх механизмыг илүү системтэй, үр дүнтэй болгох, түүнд чиглэсэн хуулийн зохицуулалт шаардлагатай байна гэж дүгнэсэн.

Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичигт өсөн нэмэгдэх эрчим хүчний хэрэглээг хангахад чиглэсэн бодлого, төлөвлөлтүүд түлхүү туссан байх бөгөөд салбарын үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан нэгдмэл бодлого тодорхойлогдсон гэхэд учир дутагдалтай байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн бодлого гэдгийг дараах байдлаар томьёолсон байна.

4.1.1."хөгжлийн бодлого" гэж улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд, урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс батлсан баримт бичгийг;

Дээрхи заалт нь салбарын түвшинд хөгжлийн бодлогын баримт бичигтэй байх агуулгыг илэрхийлж байгаа бөгөөд хүний нөөц, аюулгүй байдал, техник, технологи, зах зээл, санхүү, эдийн засаг, засаглал, менежмент, хувьчлал, хөрөнгө оруулалт зэрэг олон чиглэлд салбарын хэмжээнд баримтлах бодлого, хөгжлийн төлөвлөлтүүд хийгдэх шаардлага байна гэж дүгнэсэн.

Салбарын хөгжлийн бодлогыг батлах, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой заалтуудын хэрэгжилтийн байдалд хийгдсэн үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн хуульд дараах сайжруулсан зохицуулалтуудыг тусгах шаардлага байна гэж дүгнэлээ.

	Одоогийн хуулийн заалт	Зохицуулалтыг сайжруулах санал
	4.1.Улсын Их Хурал эрчим хүчний талаархи төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.	Улсын их хурлаас баталсан бодлогын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, гаргасан шийдвэр бүрийг орхигдуулахгүйгээр хянаж, үр дүнг шаардах, хариуцлага тооцох механизм, тогтолцоог сайжруулах;
	5.1.1. эрчим хүчний талаархи төрийн бодлого, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Салбарын төрийн захиргааны төв байгууллагаас боловсруулсан бодлогын уялдаа холбоо, залгамж чанар, бодитой хэрэгжихүйц төлөвлөгдсөн байдлыг тодорхой процедурын дагуу байнга үнэлж, хянах; Үндэслэлгүй, чанаргүй, үр дүнгүй хэрэгжилтэд хүлээлгэх хариуцлагын механизмыг сайжруулах;
	6.1.1. эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;	Эрчим хүчний найдвартай, тогтвортой хангамжийг бий болгоход онцгой чухал нөлөөтэй **гол арга хэмжээ, арга хэрэгслүүдийг хуульд тусган**, хэрэгжүүлэх субьект, хугацаа зэргийг тодорхой заан процессжуулснаар, зайлшгүй хэрэгжих хуулийн хөшүүргийн бий болгох;
		◎ Эрчим хүчний хэрэглээний хэтийн төлөвлөлтийг хийх;
	6.1.2. эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлогыг боловсруулах;	◎ Эрчим хүчний хэрэглээний төлөвлөлтөд үндэслэсэн системийн төлөвлөлт;
		◎ Эрчим хүчний өсөн нэмэгдэх хэрэглээг хангах өрсөлдөөнийн зарчимд үндэслэсэн хүчин чадал(capacity market)-ын зах зээлийг төлөвлөх, хэрэгжүүлэх;
		◎ Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.2.1.2 Шинэ хүчин чадал бий болгох ба тусгай зөвшөөрлийн зохицуулалт

Эрчим хүчний системд шинэ эх үүсвэр барьж холбохын тулд Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авах бөгөөд тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт, түүний үр дагаврыг үнэлсэн.

Д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**12 дугаар зүйл.Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох**
		12.2.Улсын хилийг дайран өнгөрөх шугам, 5 МВт-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний барилга байгууламж барих, диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр Зохицуулах хороо олгоно.
		12.5.Иргэн, хуулийн этгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор 1.5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж хэрэгжүүлж байгаа байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	Тусгай зөвшөөрөл олголт нь эрчим хүчний өсөлтийг оновчтой хангах бодит механизм болж чадаж байгаа эсэх?
		Өөрийн хэрэгцээг хангах зориулалттай эх үүсвэрийн зохицуулалт практикт нийцэж байгаа эсэх?
		Тусгай зөвшөөрөл олголт нь бизнес эрхлэгчдийг зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарлаж байгаа эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Тусгай зөвшөөрөл олголтын статистик тайлан мэдээ
		2. Тусгай зөвшөөрөл авсан төслүүдээс сүлжээнд холбогдсон эх үүсвэрийн судалгаа
		3. Тусгай зөвшөөрөл авсан төслүүдээс худалдах, худалдан авах гэрээ байгуулсан эх үүсвэрүүдийн судалгаа

Шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл олголт, холбогдсон байдал

ЭХЗХ-оос 2014-2024 онд нийт уламжлалт ба сэргээгдэх эх үүсвэрийн 64 төсөлд 14.9ГВт хүчин чадал бүхий тусгай зөвшөөрөл олгож, нарны станцын 20 төслийн 0.5 ГВт хүчин чадал бүхий тусгай зөвшөөрлыг хүчингүй болгосон байна.

Нийт 14.4ГВт хүчин чадал нийлүүлэх хүчинтэй байгаа 44 төслөөс 2024 оны 10 дугаар сарын байдлаар сэргээгдэх эрчим хүчний 9 төслийн 210МВт хүчин чадал, уламжлалт эх үүсвэрийн өргөтгөлийн 1 төсөл 50МВт хүчин чадлаар сүлжээнд холбогдсон байна. Өөрөөр хэлбэл тусгай зөвшөөрөл олгосон төслүүдээс барьж байгуулж, сүлжээнд хүчин чадал үүсгэсэн төсөл маш цөөхөн байна.

Ангилал	Тусгай зөвшөөрөл авсан		Сүлжээнд холбосон	
	Төслийн тоо	Хүчин чадал	Төслийн тоо	Хүчин чадал
Усан цахилгаан станц	7	338	-	-
Салхин цахилгаан станц	3	155	2	105
Нарны цахилгаан станц	31	627	7	105
Био масс цахилгаан станц	3	61.4	-	-
Эрчим хүч хуримтлуурын станц	4	115	-	-
Сэргээгдэх дүн	48	1296	9	210
Уламжлалт эх үүсвэр	12	4300		
Бусад сүлжээнд нийлүүлэх	2	80	1	50
Экспортлох зориулалттай	2	9240		
НИЙТ ДҮН	**64**	**14916**	**10**	**260**

Нийт тусгай зөвшөөрөл олгогдсон 14.4ГВт хүчин чадлаас экспортын зориулалттай 9.2ГВт хүчин чадлыг хасвал нэгдсэн сүлжээнд нийлүүлэх зориулалттай эх үүсвэрийн нийлбэр хүчин чадал 5.1ГВт байхаар байгаа бөгөөд системийн ачааллын таац 2030 оны түвшинд 3.7ГВт буюу 1.9ГВт нэмэлт хүчин чадал шаардлагатай байхаар байна. Тусгай зөвшөөрөл авсан эх үүсвэрүүд 2030 оны түвшинд бүрэн залгагдаж, 5.1ГВт хүчин чадал нэмэгдэнэ гэж тооцвол бодит шаардлагатай хүчин чадлаас 90 гаруй хувийн хүчин чадлын илүүдэл үүсч, систем бүрэн шингээх боломжгүй байхаар дүр зураг харагдаж байна.

	Эдгээр тусгай зөвшөөрөл авсан станц бүр холбогдохгүй, зөвхөн хөрөнгийн эх үүсвэрээ босгож чадсан цөөхөн станцууд нь холбогдоно гэдгээр няцаалт хийж болох ч энэ нь системд болон хөрөнгө оруулагчдад маш тодорхойгүй байдлыг үүсгэж байна. Хөрөнгө оруулагчдын хувьд өрсөлдөгч эх үүсвэрүүдийн төслийн байдлыг байнга судалж, зах зээлд шингэх боломжтой эсэхээ магадлах, системийн хувьд тусгай зөвшөөрөл бүхий эх үүсвэрүүдээс аль нь, ямар хүчин чадлаар холбогдох боломжтойг тэднээс асууж ажлаа төлөвлөх нөхцөл байдлыг үүсгэж байна. Дээр нь хөрөнгө оруулагчдын хариулт ямар ч баталгаа болохгүй нь маш том асуудал юм.
	Хэрэгцээт шинэ хүчин чадлыг бий болгох зохицуулалт ийм аргачлалаар явагдаж байгаа үед бодитой хэрэгжүүлэх төслүүдээс гадна тусгай зөвшөөрөл аваад, түүнийгээ баталгаа болгож хөрөнгө оруулагчидтай төслийн хэлэлцээр хийх, тусгай зөвшөөрлөөр баталгаа болгож тухайн төслөө үнэлж зарах зэрэг зохисгүй үр дагаврууд үүсч, бодитой болон бодитой бус төслүүдийг ялгаж тодорхойлоход хэцүү байдал үүсгэж байна

Худалдах, худалдан авах гэрээ (PPA)

Тусгай зөвшөөрөл бүхий төслүүд Эрчим хүчний яамны зөвшөөрснөөр Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-тай цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээ байгуулдаг бөгөөд энэ нь эрчим хүчний зах зээлд үйлдвэрлэсэн эрчим хүчээ нийлүүлэх эрх зүйн баталгааг хангасан чухал баримт бичиг юм.

ДҮТ ТӨХХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулсан 56 төсөл байгаа бөгөөд нийт 7ГВт суурилагдсан хүчин чадал бүхий эх үүсвэр, үүсгүүрүүд 6.36-17.8 цент.кВт.ц тарифаар цахилгаан эрчим хүч нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Нийт гэрээ байгуулсан 7ГВт хүчин чадлаас 0.2ГВт суурилагдсан чадалтай 9 эх үүсгүүр системд холбогдсон байгаа бол 6.7ГВт хүчин чадалтай 47 төсөл нь 2025-2030 он холбогдохоор гэрээ байгуулсан байна.

Эх үүсгүүр ангилал	Хүчин чадал, (МВт)	Гэрээний үнэ, ам.доллар.цент	Гэрээний хугацаа, (жил)	Сүлжээнд холбогдсон төслийн тоо	Сүлжээнд холбогдсон хүчин чадал
Нарны станц	208	15-17.8 цент	20-25 жил	3	50
Нарны станц	285	12-17.3 цент	12-20 жил	4	70
Нарны станц дүн	**493**	**12-17.8 цент**	**12-25 жил**	**7**	**120**
Салхины станц	472.8	9.4-9.7 цент	15-26 жил	2	105
Био масс станц	22	10.95-13.5 цент	20-30 жил	-	-
Усан цахилгаан станц	114.6	7.93-8.60 цент	13-27 жил	-	-
Усан цэнэгт цахилгаан станц	310	10.1-15.6 цент	10-20 жил	-	-
СЭРГЭЭГДЭХ ДҮН	**1412.4**	**8.6-17.8 цент**	**10-30 жил**	**9**	**225**
Уламжлалт эх үүсвэр	5598	6.36-8.88 цент	25-30 жил	-	-
НИЙТ ДҮН	**7010.4**	**6.36-17.8 цент**	**10-30 жил**	**9**	**225**

Хэрвээ эдгээр станцууд бүгд системд холбогдож, цахилгаан эрчим хүч нийлүүлэх тохиолдолд хүчин чадал ба хэрэглээг баланслуулсан төлөвлөлт хийлгүйгээр маш олон тооны худалдах худалдан авах гэрээ байгуулсны үр дагаварт их хэмжээний гэрээний төлбөр төлөх нөхцөл байдал үүсэхээр байна.

Эрчим хүчний тухай хуулийн 12.2 заалтад 5МВт-аас дээш хүчин чадалтай шинэ эх үүсвэр барих тусгай зөвшөөрлийн Эрчим хүчний яамны зөвшөөрснөөр Зохицуулах хороо олгохоор заасан нь Эрчим хүчний яам бодлого төлөвлөлтийн түвшинд хэрэгцээт хүчин чадлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, түүнд нийцсэн тусгай зөвшөөрөл олгох механизмыг бүрдүүлэх зорилготой байсан гэж харагдаж байна. Гэтэл бодит амьдрал дээр эрчим хүчний эрэлт хэрэгцээнд үндэслэсэн бус, техник эдийн засгийн хувьд боломжтой гэсэн бүх төслүүдэд тусгай зөвшөөрөл олгож, худалдах, худалдан авах гэрээ байгуулж байгаа нь бодлогын алдаа гэж дүгнэсэн.

Мөн өөрийн хэрэгцээг хангах зориулалтаар 1.5МВт хүртэл чадалтай эх үүсвэр барихад тусгай зөвшөөрөл авахгүй байхаар зохицуулсан заалтын хувьд 1.5МВт гэдэг хүчин чадлын үзүүлэлт ямар шаардлагаар гарч ирсэн нь тодорхойгүй байна. Эрчим хүчний хууль хэрэгжсэн 20 гаруй жилийн хугацаанд эдийн засаг тэлэхийн хэрээр томоохон хүчин чадалтай аж үйлдвэрийн салбарууд нэмэгдэж байна.

Нөгөө талаар эрчим хүчний систем чадлын дутагдалд орсноос хэрэгцээт хүчин чадлыг хангахад асуудалтай тулгарч байна. Иймд өөрийн хэрэгцээг хангах зориулалтаар эсхүл бие даасан хэлбэрээр ажиллах эх үүсгүүрүүдийг заавал тусгай зөвшөөрөл шаардахгүйгээр барьж байгуулах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй гэж дүгнэсэн.

Хууль хэрэгжсэн 20 гаруй жилд эрчим хүчний системд томоохон чадлын нэг ч эх үүсвэр баригдаагүй, чадлын дутагдалд орж, цахилгаан хангамжийн найдвартай байдал маш өндөр эрсдэлтэй нөхцөл байдал буй болоод байгаа нь төлөвлөлт, тусгай зөвшөөрлийн зохицуулалтын оновчтой бус байдалтай тодорхой хэмжээгээр холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Хөрөнгө оруулалтыг татах хэт олон төслүүдтэй гэрээ байгуулснаас хатуу нөхцөлтэй худалдах худалдан авах гэрээний төлбөрт орж, эрчим хүчний салбараа хүнд байдалд оруулж байсан гадаад орнуудын туршлага ч их байна. Иймд бид өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах төлөвлөлтийг оновчтой хийх, түүнийг хангах худалдан авалтын ухаалаг схем, процедуртай байх нь чухал байна.

	САЙЖРУУЛАХ САНАЛ
	Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төсөл хэрэгжүүлж, сүлжээнд залгах хамгийн богино хугацаа нь 4-5 жил гэж үзвэл өнөөдөр шинээр бий болох хэрэглээг хангах төлөвлөлт дээрхи хугацаанаас өмнө хийгдсэн байх ёстой. Энэ утгаараа эрчим хүчний систем маш үндэслэлтэй төлөвлөлт, түүнийг зайлшгүй хангасан байх шалгуурт нийцсэн оновчтой, уян хатан зохицуулалттай байх нь чухал юм.
	Олон улсад өсөн нэмэгдэх хэрэглээг хангаж буй гол механизм нь **“чадлын зах зээл”** бөгөөд ихэвчлэн Эрчим хүчний яам түүнтэй адилтгах институц шинэ хүчин чадал бий болгох төслүүдийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалт **(Capacity market auction)**-аар шалгаруулж, тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах дараагийн шатны процесст шилжиж байна. Чадлын зах зээл дээр өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг 1 ба 4 жилээр зарлаж байна.
	Эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангаж, найдвартай систем бүрдүүлэхэд дээрх зах зээлийн зарчмыг ашиглах нь зүйтэй гэж дүгнэсэн.
	Нэгэнт сонгогдсон хэрэглэгч системийн найдвартай байдлыг хангахад зохих үүрэг хүлээж байгаа учраас тодорхой үүрэг хариуцлага, эдийн засгийн механизмуудыг тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, гэрээнд тусгах шаардлагатай.
	Сонгон шалгаруулалтаар сонгогдсон хэдий ч зах зээл, хөрөнгө оруулалт, бусад шалтгаанаар төсөл хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нөхцөлд дараагийн шатанд авах арга хэмжээг мөн төлөвлөсөн байх шаардлагатай.
	Сонгон шалгаруулалтад оролцох төслүүд нь төслийн санхүүгийн хаалтыг хийсэн эсхүл сонгогдсноос хойшхи 1 жилийн хугацаанд багтаж санхүүгийн хаалт хийсэн байхаар хэрэгжихүйц байдлыг баталгаажуулсан механизм байх шаардлагатай.
	Үр дүнд нь хэзээ, хэрхэн холбогдох нь тодорхойгүй, процессоо тайлбарласан олон төслүүд биш хөрөнгө оруулалт, санхүүжилт нь тодорхой болсон, системийн төлөвлөлтийн графикийг хангаж чадах, бодит төслүүд хэрэгжинэ.

3.2.2 Үнэ тариф, санхүүгийн алдагдал, өр төлбөр

Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн бие даасан байдлыг хангах чиглэлд хуулийн зохицуулалт, зүйл заалтууд хэрхэн хэрэгжсэн байдлыг үнэлсэн.

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хуулийн 9 дүгээр зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх**
		9.1.4.тариф тогтоох аргачлал боловсруулах, тарифын бүтэц тодорхойлох, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифыг хянаж батлах, хэрэглэгчдэд худалдах үнийг тогтоох, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх;
		9.1.5.эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох;
		9.1.16.эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам батлах;
		9.1.17.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;
		Хуулийн 26 дугаар зүйл. Тариф тогтоох зарчим
		26.2.1.үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;
		26.2.2.цахилгаан, дулааны хангалтад хэрэглэгчдээс тавих шаардлагатай уялдуулан хэрэглэгчийн ангилал тус бүрээр өртөг, зардлыг хуваарилах;
		26.2.3.эрчим хүчний хэрэглээг зохицуулах боломжтой байх;
		26.2.4.үнийг инфляцтай уялдуулан тооцох;
		26.2.5.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж хэрэгжүүлж байгаа байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	Бодит өртөг зардлыг хангахуйц үнэ тариф тогтсон эсэх?
		Салбарын компаниудын ашиг ажиллагаанд ямар өөрчлөлт гарсан бэ?
		Шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж чадаж байгаа эсэх?
		Өр төлбөрийн байдал санхүүгийн зохистой харьцааг хангаж чадаж байгаа эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийн судалгаа
		2. Салбарын цахилгаан борлуулалт, борлуулалтын орлогын статистик судалгаа
		3. Салбарын компаниудын техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн судалгаа
		4. Салбарын компаниудын урт хугацаат зээлийн судалгаа

ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

Эрчим хүчний зохицуулах хорооноос гаргасан судалгаа[4]-аар хууль хэрэгжсэн хугацаанд цахилгаан ба дулааны үнэ тарифт 11 удаагийн өөрчлөлт орсон байна.



Цахилгаан эрчим хүчний дундаж үнэ 2024 оны байдлаар 216 төгрөг/кВт.ц байгаа нь бодит өртгөөс 69 төгрөг/кВт.ц-аар буюу 24.2%-аар, дулааны эрчим хүчний дундаж үнэ 33862 төгрөг/Гкал байгаа нь бодит өртгөөс 35892 төгрөг/Гкал-аар буюу 51.4%-аар бодит өртгөөс доогуур байна.






Цахилгааны бодит өртөгт 2024 оны 4 дүгээр улиралд холбогдохоор төлөвлөсөн шинэ эх үүсвэрийн гэрээний үнийн нөлөөлөл, хуримтагдсан өр төлбөр зэргийн оруулж тооцсноор нэгжийн өртөг **285** төгрөг гарсан байна.

[4] Эрчим хүчний зохицуулах хорооны судалгаа

Дээрхи тоо баримтууд нь хуулийн 26.2.1 заалтад тусгасан үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах гэсэн зарчим хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Эрчим хүчний салбарын зардал нь хэрэглээний үнийн индекс, гадаад валютын ханшийн өөрчлөлт, түлшний үнийн өөрчлөлт зэргээс хүчтэй хамаардаг бөгөөд эдгээр хүчин зүйлсийн өөрчлөлт ба үнэ тарифын өөрчлөлтийн харьцуулсан судалгааг графикаар харууллаа. Цахилгаан эрчим хүчний үнэ тариф 2011 оныг суурь болгон тооцоход 2.6 дахин өссөн бол инфляци 2.6 дахин, гадаад валютын ханш 2.7 дахин өссөн байна. Энэ нь эдийн засгийн макро үзүүлэлтийн өөрчлөлттэй ойролцоо түвшинд тарифын өөрчлөлт хийгдсэн буюу зардлын өөрчлөлтийг хангах түвшинд байсан гэж дүгнэж болохоор харагдаж байна.



Гэхдээ сэргээгдэх эрчим хүчийг дэмжих бодлогын хүрээнд 2015 оноос эхэлж салбарын уламжлалт эх үүсвэрүүдээс өндөр тарифтай нар, салхины эх үүсгүүрүүд системд холбогдож, уламжлалт эх үүсвэр ба сэргээгдэх эх үүсгүүрийн үнийн зөрүүг дэмжих тарифаар хангах зохицуулалт хэрэгжиж эхэлсэн. Дэмжих тарифыг анх 2015 онд 4 төгрөг/кВт.ц-аар тогтоож байсан бол сэргээгдэх эх үүсгүүр нэмэгдэхийн хэрээр нэмж бүрдүүлэх орлогын хэмжээ нэмэгдэж, хамгийн сүүлд 2019 онд 23.79 төгрөгөөр тогтоон өнөөг хүртэл мөрдөж байна.

Бидний өмнө хийсэн харьцуулалтад 2011 оны буюу системд сэргээгдэх эх үүсгүүрүүд холбогдоогүй үеийн тарифыг суурь болгож авсан учраас түүнээс хойш хугацааны тарифт дэмжих тарифын үүсгэсэн нөлөөллийг хасч тооцсноор бодит харьцуулалт гарах юм. Сэргээгдэх эрчим хүчий дэмжих тарифын нөлөөллийг хасч тооцвол дундаж үнэ 195.2 төгрөг/кВт.ц буюу 2011 онтой харьцуулахад **2.2** дахин өссөн нь инфляци, гадаад валютийн ханшийн өсөлтөөс хоцорч байна.

Эрчим хүчний зохицуулах хороо нь эхний ээлжинд үнэ тарифыг бодит өртөг зардалд хүргэх, үүний дараа индексжүүлэлтийг тогтмол хэрэгжүүлэх стратеги баримталж байна.


Эрчим хүчний салбарын санхүүгийн байдал, өр төлбөр


Бодит өртөг зардалд тулгуурласан үнэ тариф батлахгүй байгаагаас эрчим хүчний салбар санхүүгийн алдагдалтай ажиллах, өр төлбөр нэмэгдэх суурь шалтгаан болж байна.

Эрчим хүчний үнэ тариф бодит өртөг зардлыг нөхөхүйц түвшинд биш байгаатай холбоотой түлш, эрчим хүчний салбар нь 2014 оноос хойш санхүүгийн алдагдалтай[5] ажиллаж байгаа бөгөөд 2024 онд **355** тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байгаа ба үүнд эрчим хүчний компаниуд 274 тэрбум төгрөг, нүүрсний уурхайнууд 81 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллахаар байна.

Эрчим хүчний үйлдвэрлэлд хэрэглэдэг анхдагч нөөц болох нүүрсийг Багануур, Шивээ Овоо, Шарын голын нүүрсний уурхайнуудаас хангадаг бөгөөд эрчим хүчний үнэ тарифаа бодит өртөгт хүргэж чадахгүй байгаагаас уурхайнуудын санхүүгийн байдал хүндрэх дам нөлөөллийг бий болгодог.

Сүүлийн 5 жилийн хуримтлагдсан дүнгээр санхүүгийн алдагдал 806 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд эх үүсвэрийн дутагдал нь өр төлбөр тасралтгүй нэмэгдэх үр дагаврыг бий болгож салбарын дүнгээр 2024 оны байдлаар 712 тэрбум төгрөгийн өр төлбөртэй гарахаар байна.





ЭХЗХ нь салбарын бодит орлогод нийцүүлж 2022 онд ТЭЭ-ийн саналаас 111.0 тэрбум төгрөгөөр, 2023 онд 108.9 тэрбум төгрөгөөр, 2024 онд 202.0 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, үнэ тариф баталсан байна. Эрчим хүчний салбарын алдагдлыг харахад ЭХЗХ-ны хянаж баталсан зардлын дүнтэй ойролцоо байгаа нь алдагдал үнэ тарифтай шууд холбоотой байгааг харж болохоор байна.

[5] Эрчим хүчний зохицуулах хорооны мэдээлэл

3.2.2.3 Хөрөнгө оруулалт, урт хугацаат зээл

Эрчим хүчний систем нь технологийн нарийн горим, процесстэй, найдвартай техник, технологид суурилж ажилладаг онцлогтой салбар учраас техникийн засвар үйчилгээ, өргөтгөл шинэчлэлтийн тасралтгүй хийж байх зайлшгүй шаардлагатай байдаг. Тиймээс техникийн засвар, өргөтгөл, шинэчлэлт, түүний хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нөхөн төлөхтэй холбоотой хуулийн зохицуулалтуудын хэрэгжилтийн байдлыг үнэлсэн.

Д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэхь заалт:**
		Цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагааг болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах, дамжуулах сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх үйл ажиллагаа эрхлэх;
		Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.15 дахь заалт:
		Энэ хуулийн 25.1.9-д заасан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;
		Хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.9 дэх заалт:
		Цахилгаан, дулаан дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан дамжуулах, түгээх сүлжээг өргөтгөх, шинэчлэх, талаар 3 - 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа харилцагч бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авч, тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр тодотгож мэдэгдэх;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж хэрэгжүүлж байгаа байдал
		3. Бусад үр дагавар
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн цахилгаан, дулааны найдвартай хэрэглээг хангахад шаардлагатай засвар, өргөтгөх үйл ажиллагааг хийж байгаа эсэх?
		Хөрөнгө оруулалтын өгөөжийг тарифын зохицуулалтаар шийдвэрлэж байгаа эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1.Эрчим хүчний салбарын компаниудын элэгдлийн зардал, үнэ тарифт туссан байдлын судалгаа
		2. Дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө
		3. Түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

Хуулийн 14.2.1-т заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад шаардлагатай засвар үйлчилгээг хийх эрхийг өгсөн боловч ЭХЗХ-ноос баталж өгсөн тариф буюу хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ нь шаардлагатай засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлт, хөрөнгө оруулалтыг хийхэд хүрэлцдэггүй байна. Энэ нь эрчим хүчний салбарын тоноглолын найдвартай ажиллагааг хангахад хүндрэл учруулдаг. Тухайлбал, жил бүр дамжуулах сүлжээнд 10-15 технологийн зөрчил гарч байгаа нь техник тоноглолын шинэчлэлт хангалтгүй байгааг харуулж байна. Дамжуулах сүлжээг өргөтгөх ямар ч хөрөнгийн эх үүсвэр байдаггүй. Үүнээс болж дамжуулах сүлжээ шинэ эх үүсгэвэр холбогдох, томоохон хэрэглэгчдийг ЦЭХ-ээр хангах боломжгүй байна.

Тухайн жилд төлөвлөгдөн хийгдэх засвар, шинэчлэлт, өргөтгөлийн ажлын хөрөнгийн эх үүсвэрийн тарифт тусгасан үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын эх үүсвэрээр бүрдүүлдэг. Сүүлийн 12 жил салбарын нийт элэгдлийн зардлын өөрчлөлт, өсөлтийн графикт харуулсан.



Төрийн өмчит компаниудын 2024 оны зорилтот түвшингээр элэгдлийн зардал 246 тэрбум төгрөг байхад тарифт нийт 184 тэрбум төгрөг буюу 75 %-иар хөрөнгийн эх үүсвэрийг тусгажээ.

ЭХЗХ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зорилтот элэгдлийн зардлыг 100 хувь тарифт тусгах ёстой боловч хөрөнгийн эх үүсвэргүй гэх үндэслэлээр дээр дурдсанчлан элэгдлийн зардлыг 70-75 %-аар тарифт тусгаж байгаа нь энэ хуулийн заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Шаардлагатай засвар шинэчлэлтийн ажлыг зохистой хэмжээнд хийж чадахгүй байгаа нь шугам тоноглолын ашиглалтын хугацаа уртсаж, насжилт өндөртэй хоцрогдмол систем болж буйг дараах судалгаагаар харууллаа.

Дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолын 69.3% нь 30-аас дээш ашиглагдсан тоноглолууд байх бөгөөд үндсэндээ маш хуучирсан станцууд эрчим хүчний системийн найдвартай байдлыг хариуцан ажиллаж байна.

Шинэ эх үүсвэр, шинэ тарифын бодлого, шинэ хөрөнгө оруулалтаар системийн тогтвортой найдвартай ажиллагааг хангах шаардлага цаг хугацааны хувьд тулгамдсан асуудал болсыг энэхүү судалгаа харуулж байна.

№	Станцын нэр	Үндсэн тоноглолын		Тоноглолын насжилт /жилээр/		
		Нэр	Тоо	10 хүртэл	10-30.	30-с дээш
1	ДЦС-2	Зуух	5	1		4
		Трубин	3	1		2
		Генератор	3	1		2
2	ДЦС-3	Зуух	13			13
		Трубин	9	1		8
		Генератор	9	1		8
3	ДЦС-4	Зуух	8			8
		Трубин	7	5	1	1
		Генератор	7	5	1	1
4	Дархан ДЦС	Зуух	9			9
		Трубин	5	1		4
		Генератор	5	1		4
5	Эрдэнэт ДЦС	Зуух	7			7
		Трубин	4	1		3
		Генератор	4	1		3
6	Дорнод ДЦС	Зуух	6			6
		Трубин	4			4
		Генератор	4			4
7	Эрдэнэт үйлдвэр ДЦС	Зуух	6			4
		Трубин	6		6	
		Генератор	6		6	
8	Даланзадгад ДЦС	Зуух	3		3	
		Трубин	3	1	2	
		Генератор	3	1	2	
Нийт дүн				**21**	**21**	**95**
Хувиар				**15.33**	**15.33**	**69.34**

Үйлдвэрлээд гаргасан эрчим хүчийг цахилгаан дамжуулах, түгээх сүлжээгээр дамжуулан эцсийн хэрэглэгч хүртэл тээврлэхэд сүлжээний дэд бүтцийн хүчин чадлын хүрэлцээ, найдвартай ажиллагааны асуудал яригдана.

Мөн хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр сүлжээний дэд бүтцийг өргөтгөх, шинээр барьж байгуулах ажлуудыг он дараалалтайгаар төлөвлөж, хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Цахилгаан дамжуулах сүлжээ нь системийн тогтвортой найдвартай ажиллагаанд онцгой чухал үүрэгтэй үндсэн сүлжээ бөгөөд түүний үндсэн тоноглолын 63% нь 30-аас дээш жилийн настай байна.

Цахилгаан түгээх компаниудын 35.5% нь 30-аас дээш жилийн настай байна.

№	Компанийн нэр	Үндсэн тоноглолын		Тоноглолын насжилт /жилээр/		
		Нэр	Нийт тоо, хэмжээ /шир,км/	10 хүртэл /шир, км/	10-30 /шир,км/	30-с дээш /шир,км/
1	БНЗӨБЦТС	Хүчний трансформатор	**658**	196	183	279
		ЦДАШ	**567**	331	163	73
		ЦДКШ	**816**	222	207	387
2	ДБЭХС	Хүчний трансформатор	**478**	171	199	108
		ЦДАШ	**2807**	1153	1367	287
		ЦДКШ	**23990**	7750	8740	7500
3	УБТЗ ЭХУХ-1	Хүчний трансформатор	**267**	85	18	164
		ЦДАШ	**52**	3	2	47
		ЦДКШ	**229**	24	18	187
4	ББЭХС	Хүчний трансформатор	**37**	11	14	12
		ЦДАШ	**1635.35**	110.45	954.6	570.3
		ЦДКШ	**0**			
5	ЦДҮС ТӨХК	Хүчний трансформатор	**165**	43	41	81
		ЦДАШ	**5289.48**	1182.44	765.3	3341.74
		ЦДКШ				
6	УБЦТС ТӨХК	Хүчний трансформатор	**4038.3**	2374	758	906.3
		ЦДАШ	**5205.1**	1967	906.3	2331.8
		ЦДКШ	**3494**	1023	1531	940
Шугамын нийт дүн			**44084.93**	**13765.89**	**14654.2**	**15664.84**
Хувь				**31.23**	**33.24**	**35.53**
Трансформаторын нийт дүн			5643.3	2880	1213	1550.3
Хувь				**51.03**	**21.49**	**27.47**

Дулаан дамжуулах, түгээх шугам нь хүйтний улиралд хэрэглэгчдэд дулаан тээвэрлэн хүргэдэг гол сүлжээ бөгөөд энэ шугам долголдвол хүйтний улиралд дулаан тасалдаж аюултай нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй, хор нөлөө нь маш өндөр байдаг онцлогтой. Дулаан түгээх сүлжээний 24.5% нь 30-аас дээш жил ашиглагдсан судалгаа гарсан байна.

№	Компанийн нэр	Үндсэн тоноглолын		шугамын насжилт /жилээр/		
		Нэр	Нийт хэмжээ /хос.метр/	10 хүртэл /хос.метр/	10-30 /хос.метр/	30-с дээш /хос.метр/
1	УБДС ТӨХК	Шугам	370000	185618.7	115026.2	69355.1
2	ДДС ТӨХК	Шугам	29295.1	16527.5	11104.95	1661.5
3	ОСНААУГ	Шугам	422068.1	209780.1	102329.5	109958.5
4	ЭДЦС	Шугам	29402	2028		27374
Нийт дүн			**850765.2**	**413954.3**	**228460.65**	**208349.1**
Хувиар				**48.66**	**26.85**	**24.49**

Хуульд өнөөгийн бодит өртгийг хангахаас гадна дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд ирээдүйн өсөн нэмэгдэх хэрэглээг хангахад дэд бүтцийн өртгөтгөл шинэчлэлт хийх 3-5 жилийн хийх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх гэсэн заалтыг оруулсан байдаг.

Салбарын томоохон дамжуулах, түгээх компаниуд болох “ЦДҮС” ТӨХК, “УБЦТС” ТӨХК-уудаас хуулийн энэ заалтын дагуу Эрчим хүчний зохицуулах хороо болон Эрчим хүчний яаманд хүргүүлсэн 3-5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд судалгаа хийсэн.

“ЦДҮС” ТӨХК нь 2023-2028 онд дамжуулах сүлжээнд хийгдэх өргөтгөл, шинэчлэлтийн хөрөнгө оруулалтыг 1410.6 тэрбум төгрөг, “УБЦТС” ТӨХК түгээх сүлжээнд хийгдэх өргөтгөл, шинэчлэлтийн хөрөнгө оруулалтыг 2010.0 тэрбум төгрөг байхаар тус тус хүргүүлсэн байна.

Дамжуулах түгээх сүлжээ шаардлагатай цахилгаан чадлыг дамжуулахад хүчин чадал хүрэлцэхгүй нөхцөл байдалд хүртэл асуудал хүндэрч, урхагшнаас хамаарч хөрөнгө оруулалтын хэрэгцээ өндөр байхаар байна. Гэтэл Эрчим хүчний зохицуулах хорооны хувьд зохих ашгийн түвшин бүхий, хөрөнгө оруулалтын өгөөжийг хангахуйц үнэ тарифын тогтолцоо бүрдүүлээгүй байгаатай холбоотой энэхүү эх үүсвэрийг шийдвэрлэх асуудал ч боломжгүй гэдэг хариултаар хаагдаж байна.

Гэтэл хэрэгцээт хүчин чадлыг дамжуулахад зайлшгүй дэд бүтцийн өртгөтгөл, шинэчлэлт хийх бодит шаардлага нь байсаар байх тул салбарын компаниуд шаардлагатай хөрөнгө оруулалтыг ихэвчлэн урт хугацаат зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байна.

Эрчим хүчний салбарын хэмжээнд техникийн өргөтгөл шинэчлэл хийх, хүчин чадал нэмэгдүүлэх зорилгоор гадны банк, санхүүгийн байгууллагаас 1,826.8 тэрбум төгрөгийн 1-7.5 хувийн, МУ-ын Хөгжлийн банкнаас 15.36 хувийн хүүтэй зээлүүдийг тус тус авсан байна.

№	ТЭЦ-ийн ангилал		Анх авсан зээлийн дүн	Зээлийн хүү %	Жилд төлөх үндсэн болон хүүгийн төлбөр	Зээл дуусах огноо	Хугацаарийн дагуу төлөгдөөгүй өр	Зээлийн үлдэгдэл
1	Үйлдвэрлэх ТЭЦ		594,087.8	1.1-15.36	117309.8	2028-2052	53618.4	529,496.1
2	Дамжуулах ТЭЦ		658,342.0	1.2-3.8	12750.7	2040		479,669.6
3	Түгээх ТЭЦ	Цахилгаан	145,190.3	1.75-3	13110.7	2036	4402.9	115,014.7
		Дулаан	162,625.3	2-2.75	22703.8	2044	4814.5	123,232.0
4	Баруун, Дорнод бүсийн ЭХС		266,573.9	1-7.63	54599.5	2026-2036	32242.8	239,430.6
5	**Нийт**		**1,826,819.3**		**220,474.4**		**95,078.6**	**1,486,842.9**

Салбарын нийт урт хугацаат зээлийн хэмжээ(1.8 наяд төгрөг) нь салбарын жилийн нийт орлого (2024 оны байлаар 2.8 их ная төгрөг)-ын 90 хувьтай тэнцэхээр байгаа нь маш өндөр босго юм. Тодруулвал эрчим хүчний салбарын бүтэн жилийн борлуулалтын орлоготой дүйцэхүйц өр төлбөртэй буюу энэ салбарт маш их өрийн дарамт бий болсныг харуулж байна.

Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт жилд 220.5 тэрбум төгрөг төлдөг ба эх үүсвэргүйгээс 95.1 тэрбум төгрөгийн өр төлбөр хугацаарийн дагуу төлөгдөөгүй байна. Зээлүүдийн төлөгдөж дуусах хугацаа 2026-2052 он хүртэл байгаа ба нийт зээлийн 74.9 хувь нь 2040-2052 онуудад төлөгдөж дуусахаар байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 80.9 тэрбум төгрөг, 2023 онд 169.0 тэрбум төгрөг, 2024 онд 226.0 тэрбум төгрөгийн тус тус техникийн шинэчлэлийн ажил хийгдсний 88.6% нь орон нутагт, 11.4% нь нийслэлд хийгдсэн.

Өөрөөр хэлбэл алслагдсан орон нутаг дахь эрчим хүчний асуудлуудыг шийдэхэд тодорхой хөрөнгө хуваарилж, системийн томоохон асуудлуудад анхаарал хандуулахгүй байгааг дээрхи тоо баримт харуулж байна.

Ийм бодит нөхцөл байдал байхад нэн шаардлагатай төслүүдэд улсын төсвөөс хөрөнгө хуваарилахгүй, туйлдаад байгаа эрчим хүчний салбарыг цаашид ч гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татах арга замаар буюу ялгаагүй урт хугацаат зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх бодлого, стратеги барьж буй нь оновчтой эсэхийг эргэн харж, маш сайн нягтлах, үнэлэх шаардлагатай юм.

Нэн шаардлагатай, стратегийн ач холбогдолтой төслүүдэд улсын төсвөөс хөрөнгө оруулах бодлогыг эрчим хүчний салбар санхүүгийн энэ хүндрэлтэй байдлаа даван туулах шилжилтийн тодорхой хугацаанд баримтлах нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ:

Эрчим хүчний салбар нь улс орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах суурь салбар боловч улс орны өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай хангах нь сүүлийн жилүүдэд тулгамдсан асуудал болоод байгаа ба санхүү, эдийн засгийн хүндрэлтэй байдалд ороод байна.

Салбарын санхүүгийн чадавхыг хангах үндэс суурь болсон эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудыг хамгийн бага өртөгт үндэслэгдсэн эдийн засгийн шалгууураар ажиллуулах талаар холбогдох зохицуулалтуудыг хуульчилсан, мөн салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хувийн хөрөнгө оруулагчдын итгэлийг олох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор бие даасан зохицуулах байгууллагыг байгуулж ажиллуулж байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байна.

Хэдийгээр Эрчим хүчний зохицуулах хороо нь статусын хувьд бие даасан, хараат бус зохицуулалт хийхээр хуульчилсан байгаа хэдий ч эдийн засагт бий болох үнийн өсөлт, хэрэглэгчдэд үүсэх санхүүгийн ачаалал зэргийн үндэслэн, үнийн өөрчлөлтийг Засгийн газрын түвшинд хэлэлцэж, хянадаг, хорооны шийдвэрт нөлөөлдөг албан бус жишиг тогтсон байна.

Эрчим хүчний үнэ тарифт өөрчлөлт оруулах асуудалд хязгаарлалт тавьж буй үндсэн шалтгаан нь хэрэглэгчдэд үүсэх санхүүгийн дарамтыг бууруулах нийтлэг зорилготой байдаг хэдий ч хэрэглэгчдэд ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэх хуулийн заалт мөн адил хэрэгжихгүй байна. Хуулийн 9.1.17-д заасны дагуу улсын төсвөөс 2024 онд 131 тэрбум төгрөгийн татаас олгосон нь энэ хуулийн заалтын хүрээнд хийгдсэн анхны зохицуулалт гэж үзэж болохоор байна.

Сайжруулах санал:

Эрчим хүчний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т “Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.” гэж заасан нь гүйцэтгэх засаглалаас хамааралтай байх, улс төрийн нөлөө орох нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

Иймд эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн үйл ажиллагааны бодит өртөг зардалд суурилсан, зах зээлийн зарчимд нийцсэн, улс төрийн нөлөөллөөс ангид үнэ тарифын оновчтой тогтолцоог бий болгох, улмаар эрчим хүчний салбар нь санхүү, эдийн засгийн хувьд бие даасан, улс орны эрчим хүчний хэрэгцээг найдвартай хангасан салбар болон хөгжихөд хуульд илүү тодорхой, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах шаардлагатай байна

	Эрчим хүчний зохицуулах хороог улс төрөөс ангид, хараат бус шийдвэр гаргах эрх зүйн орчин, статусыг хуульд тодорхой тусгах;
	Эрчим хүчний үнэ тариф бодит өртөг зардлыг нөхөхүйц, зохих ашгийн түвшин бүхий, хөрөнгө оруулалтын өгөөжийг хангасан байх зарчмыг эдийн засагчжуулсан тодорхой шалгуур нөхцлүүдээр хуульд тусгаж өгөх;
	Эрчим хүчний үнийн идексжүүлэлтийг жилд хамгийн багадаа нэгээс доошгүй удаа заавал хийдэг байх зохицуулалт оруулах;
	Эрчим хүчний идексжүүлэлт хийх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын саналыг хянах, гэрээний гарааны үнэ батлахад мөрдөх суурь зарчим, шаардлагуудыг хуульд тусгах;
	Зохицуулалтгүй хангалтын үнийн механизмыг хэрэгжүүлэх талаар хуулийн заалтуудыг тодорхой, ойлгомжтой болгох;
	Зохицуулах байгууллагын үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, зохицуулалтын чиг үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй үед хүлээх хариуцлагын асуудлыг тодорхой томъёолох;

3.2.3 Хангагч хэрэглэгчийн эрх, үүрэг

Эрчим хүчний тухай хуулийн хамгийн гол оролцогч талууд нь хангагч, хэрэглэгчийн харилцаа бөгөөд хангагчийн зүгээс хэрэглэгчид чанартай, шуурхай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлж чадаж буй эсэх болон хэрэглэгчийн зүгээс хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаа хэрхэн хангаж буй байдлыг тэнцвэртэйгээр үнэлж, аль аль талын эрх ашгийг тэгш шударгаар хангах нь чухал юм. Хэрэглэгч хангагчийн хооронд үүсдэг харилцаанаас анхаарал хандуулах шаардлагатай дараах хуулийн зүйл, заалтуудын хүрээнд үнэлгээ хийсэн.

Д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хангагч, хэрэглэгчийн харилцаа**
		Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт: стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах;
		Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дах заалт: “гэрээнд заасан үйлчилгээний түвшинг хангах;
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт: “стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хангагдах эрхтэй;
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дэх заалт: ”эрчим хүчээр хангагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс эрчим хүч дутуу нийлүүлсэн, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй бол эрчим хүчний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх”
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хэрэглэгчдийг стандартын шаардлага, үйлчилгээний түвшинд нийцсэн эрчим хүчээр хангах гэсэн зорилгодоо хүрсэн эсэх?
		2.Чанаргүй дутуу нийлүүлсэн эрчим хүчтэй холбоотой гомдол гардаг эсэх? Түүнийг барагдуулах эдийн засгийн механизм ажилладаг эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Хэрэглэгчдээс ирүүлсэн гомдол саналын тоо, чанарын шаардлага хангаагүйгээс үүдэн хэрэглэгчид учирсан хохирлын талаар статистик тоо, баримт, тайлан мэдээлэл, шүүхээр шийдвэрлүүлсэн байдал.

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуульд эрчим хүчний стандартын шаардлага, эрчим хүчний чанарын үзүүлэлтийн талаар тодорхой зохицуулалт байхгүй. Хэрэглэгч ямар тохиолдолд эрчим хүчний чанар стандарт хангаагүй гэж үзэж гомдол гаргах, түүнийг хэрхэн тодорхойлж магадлах, хохирлыг хэрхэн барагдуулах үйл явц тодорхойгүй. хэрэглэгчийн эрх зөрчигддөг.

Дулааны эрчим хүчний чанарын үзүүлэлт хангагдаагүй нөхцөлд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагчаас нэхэмжлэх боломж хязгаарлагдмал, хэрэглэчийн эрх зөрчигддөг. Дээрх ойлголтыг ЭХЗХорооны батлсан дүрмээр зохицуулдаг. Жишээ нь: Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын "Аж ахуйн харилцааны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлд дулааны эрчим хүчний чанарын стандартуудыг дурдсан хэдий ч тэдгээр стандарт нь хэрэглэгч дээрхи эрчим хүчний чанарыг хэмжиж тодорхойлох үндэслэл болж чадахааргүй байна.

Гэрээнд заасан болзол, чанарын шаардлага хангаагүй ажил, үйлчилгээ гүйцэтгэсний улмаас хэрэглэгчид учирсан хохирлын хэмжээгээр гэрээний үнийг багасган төлөх тохиолдол маш ховор, хэрэгжүүлсэн нөхцөлд ЭХЗХ-ны батлсан тарифаар тооцсон төлбөрийг шууд буруулан тооцох аргачлалаар явж байгаа нь хууль зөрчсөн нөхцлөл байдал үүсгэж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нэг талыг барьсан гэрээг хийдэг ба хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалсан заалт дутмаг байдаг. Жишээ нь: “УБЦТС” ТӨХК-д 2023 онд стандартын шаардлагад нийцээгүй эрчим хүчээр хангасан тухай 279 гомдол ирснээс 251 хэрэглэгчийн гомдлыг барагдуулсан байна. Энэ нь зөвхөн цахилгааны үзүүлэлтийн хэлбэлзлээс хамаарч тоног төхөөрөмж, хэрэгсэл шатсан, гэмтсэн тохиолдлуудыг авч үздэг бөгөөд чанарын үзүүлэлт хангагдахгүй нөхцөлд хохирлыг барагдуулах эдийн засгийн механизм үндсэндээ хэрэгждэггүй.

Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дах хэсэгт: Хэрэглэгч чанаргүй бараа, ажил, үйлчилгээний улмаас зөрчигдсөн эрхээ хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар дамжуулан хамгаалуулах эрхтэй”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх хэсэгт: мөн хуулийн 8.1.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас хэрэглэгчид учирсан гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан хэрэглэгчийн шаардлагыг үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч биелүүлэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй.

Хэрэглэгч хангагчийн үзүүлж буй үйлчилгээнд хэр сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх үзүүлэлт нь хэрэглэчдээс ирэх санал гомдол юм. Судалгаанд хамрагдсан 4 байгууллагын хэмжээн сүүлийн 3 жилд хэрэглэгчдээс 11666 гомдол хүлээн авсан байна.

№	Байгууллагын нэр	2022	2023	2024	Нийт
1	УБЦТС	1866	2299	1862	6027
2	ДБЭХС	410	247	186	843
3	УБДС	786	393	222	1401
4	ОСНАУГ	1297	964	1134	3395
	Нийт	**4359**	**3903**	**3404**	**11666**

Хэрэглэгчдээс ирж буй санал гомдолд компанийн үйлчилгээний хандлага, чанартай, түргэн шуурхай байдалд сэтгэл дундуур байгаа, тоолуур, хэмжүүр, төлбөр тооцооны маргаан, эрчим хүчний чанарын үзүүлэлт шаардлага хангахгүй байгаа тухай, техник үйлчилгээний үйлчилгээний чанартай холбоотой гомдлууд цөөнгүй байгаа нь хэрэглэгчийн үйлчилгээний чанар доголдолтой, хүнд сурталтай байгааг харуулж байна.

№	Гомдлын төрөл	2022	2023	2024	Нийт
1	Хүн амьтан, мал хүчдэлд нэрвэгдсэн тухай гомдол	2	5	3	10
2	ЦЭХ-ээр тасалдуулсан, хязгаарласан, чанаргүй эрчим хүчээр хангасан тухай гомдол/ давагдашгүй хүчин зүйлээс бусад/	1243	1671	1264	4178
3	Цахилгааны төлбөр, хэмжих хэрэгсэлтэй холбоотой	242	369	479	1090
4	Техникийн үйлчилгээтэй холбоотой	16	51	81	148
5	Компанийн үйл ажиллагаатай холбоотой	363	203	35	601
6	Хэрэглээний /халуун, хүйтэн/ усан хангамжийн гэмтэл, доголдол, саатлын тухай	367	99	233	699
7	Орон сууцны конторын төлбөр, хураамжийн тухай	261	234	277	772
8	Цахилгааны шугам сүлжээний техникийн тодруулга хүсэх тухай	169	179	132	480
9	Дулаан шугам сүлжээний техникийн тодруулга хүсэх тухай	157	122	111	390
10	Орон сууцны конторын үйл ажиллагааны тухай	134	155	208	497
11	Дулаан хангамжийн гэмтэл, доголдол, саатлын тухай	124	51	41	216
12	Усны шугам сүлжээний техникийн тодруулга хүсэх тухай	49	75	93	217
13	Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын үйл ажиллагааны тухай	36	49	39	124
14	Бусад	1196	640	408	2244
	Нийт	**4359**	**3903**	**3404**	**11666**

Тиймээс эрчим хүчний чанарын стандарт, үйлчилгээний түвшинг хангаж ажиллах чиглэлд хангагчийн үүрэг хариуцлагыг сайжруулах, үйлчилгээний чанарыг хянах шалгуур үзүүлэлтийг тогтоох, чанаргүй үйлчилгээнд эдийн засгийн хариуцлага хүлээдэг байх механизмуудыг хуульд тодорхой тусгах шаардлага байна.

Хангагч хэрэглэгчийн харилцаанд үүсч буй дараагийн нэг зөрчилтэй асуудал нь хувийн хөрөнгөөр барьсан хэрэглэгчийн өмчлөлийн сүлжээнд хангагч хэрэглэгч шинээр холбох, тэр тохиолдолд үүсэх эдийн засгийн зохицуулалтын асуудал юм.

Д/Д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хангагч, хэрэглэгчийн харилцаа**
		Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9 дах заалт: Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дах заалт: Түгээх, зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос бусад хэрэглэгчийн холбуулах
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дах заалт: Өөрийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан эрчим хүч бусдад дамжуулах, түгээх, тухайн хангагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практик нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах хуулийн зорилтод хүрсэн эсэх?
		2.Хуулийн зохицуулалт хангалтгүй улмаас практикт урьдчилан тооцоогүй, шинээр гарч ирж байгаа үр дагаварууд?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Энэ чиглэлээр ирсэн гомдол, санал, маргаан, шүүхийн шийдвэрүүдийн статистик тоо, баримт, материалууд

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хуулийн зохицуулалт нь хэтийн төлөв, сүлжээ төлөвлөлтийг үндэслэл болгон хувийн эзэмшлийн сүлжээнд хэрэглэгч нэмж холбох асуудалд түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч давуу эрхтэйгээр оролцож, зөвшөөрөл өгөхөөр заасан бөгөөд хэрэв хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмж ашиглаж бусад хэрэглэгчийг хангаж буй бол тухайн хэрэглэгчид үйлчилгээний төлбөр төлөхөөр заасан байна.

Гэтэл бодит байдал дээр хэрэглэгчийн өмчлөлийн түгээх сүлжээнд хэрэглэгч холбох шийдвэр гаргахад тухайн шугам, тоноглолыг өмчлөгч маш өндөр эрх мэдэлтэйгээр оролцдог бөгөөд түгээгч (хангагч) өмчийн эзнээс зөвшөөрөл авсан нөхцөлд сүлжээнд холбох зөвшөөрөл гаргах боломжтой гэсэн байдлаар зохицуулалтаа хийсэн байдаг. Өмчийн эзний хувьд тухайн шинээр холбогдох гэж буй иргэн, хуулийн этгээдээс ихээхэн хэмжээний төлбөр нэхэмжлэх, түүнийг хангахгүй бол холбохгүй гэдэг байрь суурийг илэрхийлдэг. Хуульд шугам, тоноглолыг эзэмшигч нь бусад хэрэглэгчийг өөрийн шугамаас холбосон бол хангагчаас гэрээний үндсэн дээр төлбөр авахаар заасан боловч энэ заалтыг огт хэрэглэдэггүй ба шинээр холбогдох хүсэлт гаргасан хэрэглэгчийн аргаггүй,


тугамдсан, сонголтгүй нөхцөл байдлыг давуу тал болгон үндэслэлгүй өндөр төлбөр шаардах байдал нийтлэг болсон байна.

Хуулийн зохицуулалт болон бодит амьдралд хэрэгжиж буй үйл явцын зөрчилдөөнтэй байдлаас хамаарч төлөвлөлтгүйгээр маш их хэмжээний хувийн өмчлөлийн сүлжээ бий болж, түүнийг дагасан шударга бус эдийн засгийн механизм, хэрэглэгчид ихээхэн хэмжээний санхүүгийн дарамт бий болох, сүлжээнд холбогдох боломжоор тэгш хангагдах эрх зөрчигдөх сөрөг үр дагаврууд үүсгэж байна.

Иймд ямар нөхцөлд хувийн өмчлөлийн шугам, сүлжээ гэсэн ойлголтыг зөвшөөрөх, нийтийн эзэмшлийн сүлжээний төлөвлөлт, түүнийг иргэн, хуулийн этгээд хувийн хөрөнгөөр барьж байгуулсан бол эдийн засгийн зохицуулалтын ямар харилцаа, механизмыг хэрэглэх асуудлыг нэг мөр цэгцэлж, аль аль оролцогч талын эрх ашгийг тэгш хангах, шинээр холбогдох иргэн, ААН-ийг үндэслэлгүй үнийн дарамтаас хамгаалах зохицуулалтын хийх шаардлагатай.

Олон улсад энэ харилцааг холболтын төлбөрийн механизмаар дамжуулж зохицуулдаг бөгөөд хэрэглэгч сүлжээнд шинээр холбогдох техникийн болон санхүүгийн шаардлагуудыг холболтын журамд тодорхой тусгаж зохицуулсан байна. Иймд зохицуулалтын энэ арга механизмыг судалж, өөрийн эрчим хүчний салбарын онцлог байдалд нийцүүлж зохицуулж хуульчлах зайлшгүй шаардлага байна.

Нөгөө талаар төлөвлөлтгүйгээр хувийн өмчлөлийн сүлжээ тэлж өргөжих нь эргээд системийн аюулгүй, найдвартай байдалд сөргөөр нөлөөлж, үр ашигтай төлөвлөлтийн бодлогыг алдагдуулах сөрөг үр дагавартай юм. Тухайлбал “УБЦТС” ТӨХК-ийн үйлчлэх хүрээний шугам сүлжээний 51 хувь нь гадны эзэмшлийн сүлжээ байгааг судалгааг зурагт харуулсан бөгөөд энэхүү нөхцөл байдал нь систем төлөвлөлт, горим төлөвлөлт, тогтвортой, найдвартай ажиллагаа зэрэгт сөргөөр нөлөөлж буйг салбарын мэргэжилтнүүд ярьж байна.



Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалахаас гадна түүний хуулиар хүлээсэн үүргийг хангуулах, зөрчил, хохиролд хариуцлага тооцох зохицуулалтыг хуульд тодорхой тусгах шаардлагатай.

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хангагч, хэрэглэгчийн харилцаа**
		Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.7 дэх хэсэгт: Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах гэрээг цуцлах, энэ хуулийн 33.1-д заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах;
		Хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт: Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
		Хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дах хэсэгт: Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дах заалтад “Эрчим хүчний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх”
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практик нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас хангагдаж байгаа эсэх?
		2. Түүнээс хамааралтай практикт үүсч буй үр дагаврууд?
		3. Эрчим хүчний салбарын хуримтлагдсан өр төлбөрийн үүсэх шалтгаан, хэрэглэгч эрчим хүч хэрэглэсэн төлбөрөө хугацаанд нь төлөх урамшуулал, хөшүүрэг өнөөгийн нөхцөлд байна уу?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1.Салбарын хэмжээнд хамгаалалтын зурвас зөрчсөн иргэн хуулийн этгээдүүдийн статистик тоо тайлан, баримт материал , шүүхийн шийдвэрүүд
		2. Орлого цуглуулалтын статистик судалгаа;
		3. Өр төлбөртэй хэрэглэгчдийн тайлан, мэдээлэл, шүүхийн шийдвэрлэлт, найдваргүй авлагын судалгаа;
		4. Төлбөрөө хугацаандаа төлдөг хэрэглэгчийн статистик, төлбөрөө төлөхгүй хуримтлагдсан өр төлбөр үүсгэдэг хэрэглэгчдийн статистик судалгаа;

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Шугам сүлжээний хамгаалалтын зурвас хангагдаагүй зөрчил маш нийтлэг байна. Тухайлбал УБДС ТӨХК, УБЦТС ТӨХКомпанийн хүрээнд хамгаалалтын зурвасын зөрчилтэй айл өрх 5418, аж ахуй нэгж 1203, хашаа болон авто зогсоол, тохижуулсан зам талбай, эдэлбэр газар 197, граж павильон, контейнер 1015 нийт 7838 зөрчил байна. Үүний 51 хувь нь газрын зөвшөөрөлтэй, 49 хувь нь газрын зөвшөөрөлгүй байна.

Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйл ”Шугам сүлжээний хамгаалалтын зурвас”, мөн “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм” гэх мэт зохицуулалт хийх хууль, дүрэм, журам олон байгаа ч практикт хэрэгжихгүй байгаа юм.

Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 33.2-т заасан үүргээ биелүүлдэггүй, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд хүлээх хариуцлагын тогтолцоо байхгүй байна. Хууль практикт хэрэгжихгүй байгаагаас үүдэн шугам сүлжээг өмчлөгч, эзэмшигч ашиглалтын үед засвар үйлчилгээ хийж чадахгүй, хэвийн найдвартай тасралтгүй үйл ажиллагаа алдагдах зэрэг хүндрэлүүд үүсдэг.

Шинээр газар олгох захирамж, шинээр баригдах барилгын зөвшөөрөл олгохдоо зайлшгүй дулаан, цахилгаан дамжуулах, түгээх шугамын хамгаалалтын зурвасын зай талбайг хангасан эсэх талаар хангагч байгууллагын тодруулгыг үндэслэж олгох, одоо байгаа хамгаалалтын зурвас дотор шинээр газар олгохгүй байх арга хэмжээг авах шаардлагатай. Газар олгох захирамж гаргах эрх бүхий газрууд болох Дүүрэг, Нийслэлийн газар зохион байгуулалтын алба, Байгаль орчин аялал жуулчлалын яамтай холбогдох харилцааг тодорхой болгож зохицуулах шаардлагатай.

Газар зохион байгуулалтын албаны тухайн жил бүрийн төлөвлөгөөнд хамгаалалтын зурвасыг зөрчиж баригдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагын барилга байгууламжийг чөлөөлөхөд шаардлагатай зардлын төсвийг жил бүр тодотгон тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хуульд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байна. Мөн шинээр хийгдэж байгаа авто зам нь дулааны шугамын дээгүүр ихэвчлэн тавигдаж байгаа тул шинээр авто замыг тавьсан нөхцөлд дулааны шугам сүлжээг нэвтрэх сувагт оруулах зардлыг төсөвт тусгах талаар зохицуулалт оруулах шаардлага байна.

<u>Орлого цуглуулалт, өр авлага</u>

Эрчим хүчний төлбөрөө гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх төлсөн нөхцөлд урамшуулал, хөшүүргийн систем байдаггүй улмаас хэрэглэгч төлбөрөө хугацаанд нь төлөх сохирхол бага байдаг. Мөн цахилгааны эрчим хүчний хэрэглээ харьцангуй тоолууржсан байдаг бол дулааны эрчим хүчний хувьд айл өрхийн дулааны хэрэглээг тоолууржаар тооцдоггүй тул хэрэглэгч төлж байгаа төлбөртөө сэтгэл ханамжгүй байдаг. Өнөөдөр “УБДС” ТӨХК нь хотын хэмжээнд ОСНААУГ, 60 гаруй ХОСК, ААНэгжүүдийг дулааны эрчим хүчээр хангаж байгаа бөгөөд нийт 310 мянга орчим айл өрхийн 1% хүрэхгүйн дулааны төлбөрөө тоолууржаар тооцон төлж байна.

УБДС ТӨХК нь ОСНААУГ, ХОСК-той тоолууpаар тооцоо хийдэг ба ОСНААУГ, ХОСК нь хэрэглэгчээс дулааны тоолуурыг задгайгаар тооцож авч байна.

Мөн төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчээр хангах гэрээг цуцлана гэж заасан нь практикт хэрэгждэггүй. Жишээ нь:Дулааны эрчим хүчний тухайд төлбөрөө төлөөгүй нэг айлын халаалт, хэрэглээний халуун усыг хязгаарлах нь одоо байгаа технологийн хувьд боломжгүй байдалд байгаа юм. Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдийг хэрэглэгчийн эрх ашиг, суурь хэрэглээ гэсэн үндэслэлээр удирдах дээд шатны байгууллагууд эрчим хүчийг тодорхой хугацаагаар хязгаарлах, түдгэлзүүлэхийг зогсоох шийдвэр өгдөг нь салбарын хэмжээнд өр төлбөр үүсгэх шалтгаануудын нэг юм.

Төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлдөггүй, 3 сараас дээш хуримтлуулдаг, хуримтлагдсан өр төлбөр үүсгэдэг хэрэглэгч нарыг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгэгдэж тухайн хэрэглэгчийн зээлжих зэрэглэл чанарт нөлөө үзүүлэгдэг механизм бий болгох боломжтой эсэхийг судлах шаардлагатай. Шинээр орон сууцны барилга барихдаа дулаан алдагдал багатай пассив барилга барих, айл өрхүүдэд дулааны тоолуур суурилуулсан байх зэрэг шаардлагыг барилгын салбарын хууль, эрх зүйн баримт бичигт тусгах шаардлагатай.

Салбарын орлого цуглуулалтын судалгааг нэгтгэн харвал цахилгаан түгээх компаниуд борлуулалтын орлогыг үндсэндээ бүрэн цуглуулж чадаж байгаа бол орон нутгийн дулааны станцуудын орлого цуглуулалт 93%, авлага өр төлбөр үүсч байгааг харагдаж байна. Дулааны эрчим хүчийг техникийн хувьд хэрэглэгч тус бүрээр хязгаарлах боломжгүй байдаг нь орлого цуглуулалтад нөлөөлж байгааг судалгааны үр дүн харуулж байна.

№	Үзүүлэлт		УБЦТС	ЭБЦТС	ДСЦТС	БНЗӨБЦТС	БХЦТС	ББЭХС	Нийт
1	Бичилтийн орлого		619,346.7	318,862.8	93,663.19	132,285.9	12588.7	9,889.58	1,186,637.0
2	Цуглуулсан орлого		624,846.0	310,822.3	96,575.84	131,141.4	11818.9	10,123.29	1,185,327.8
3	Орлого цуглуулалт %		100.9	97.5	103.1	99.1	94.0	102.4	99.9
4	Хэрэглэгчийн тоо	Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлдөг (30 хоног)	352,420	87943	41,858	50,719.00	12342	32453	577,734.7
		30-60 хоногт төлдөг	66,450	255	10,063	3.00	1634	18638	97,043.0
		90 хоногоос дээш хугацаанд төлдөг	8,061	1872	3,512		545	1494	15,484.4

№	Үзүүлэлт		Ховд ДС	БНДС	Увс ДС	ДДС	ЭДЦС	Нийт
1	Бичилтийн орлого		5549.1	8,063.3	3,965.4	15,696.7	12,470.47	45,745.0
2	Цуглуулсан орлого		4961.1	4,878.9	4,548.8	15,744.2	12,400.57	42,533.6
3	Орлого цуглуулалт %		89	61.0	114.7	100.3	99.4	93.0
4	Хэрэглэгчийн тоо	Гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлдөг (30 хоног)	2208	587	52	13836	325	17,008.0
		30-60 хоногт төлдөг	762	1425	65	2671	4	4,927.0
		90 хоногоос дээш хугацаанд төлдөг	196	2011	46	1268	4	3,525.0

Хэрэглэгч өөрийн эзэмшлийн шугам тоноглолын ашиглалт үйлчилгээг стандарт шаардлагын дагуу явуулах хуулиар хүлээсэн үүрэгтэй хэдий ч энэ үүргийн хэрэгжилт маш хангалтгүй байна. Энэ нь нэг талаар шугам, тоноглолтой харьцаж буй хүний аюулгүй байдалд өндөр эрсдэлтэйгээс гадна хэрэглэгчийн шугам тоноглолоос хамаарсан тасралт, аваар, саатал үүсэх суурь шалтгаан болдог учраас маш хор нөлөөтэй юм.

Д/Д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хангагч, хэрэглэгчийн харилцаа**
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дах хэсэгт: “Хэрэглэгч техникийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх”
		Хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.8 дах хэсэгт: “Хэрэглэгч өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах”
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Хэрэглэгч техник ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу өөрийн шугам, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж байгаа эсэх?
		2. Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн ашиглалтаас хамаарч эцсийн хэрэглэгч хохирох, системийн хэвийн найдвартай байдал алдагдах үр дагавар үүсч байгаа эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Засвар үйлчилгээ хийдэггүй хэрэглэгчдийн судалгаа, гарч буй хүндрэлүүд

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Жил бүр л хангагч компаниас шугам тоноглолын засвар хийлгэх албан шаардлага өгч, хяналт тавьж ажилладаг боловч улс, орны нийгэм эдийн засаг, хэрэглэгчдийн хөрөнгө санхүүгийн байдлаар шалтгаалж хэрэглэгчдийн засварын ажил төлөвлөгдсөн хэмжээнд хийгддэггүй.

Хэрэглэгч техник ашиглалтын дүрмийн дагуу шугам тоноглолд засвар үйлчилгээг тогтмол хийдэггүйгээс шугам тоноглолын ашиглалтын хугацаа багасах, гэмтэл саатал гарч хангагчийн үйл ажиллагаанд доголдол үүсгэж улмаар бусад хэрэглэгчийн хэрэглээг хязгаарлах сөрөг үр дагавартай байна. Дээрх заалтын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоог сайжруулах шаардлагатай.

Жишээ нь: УБДС ТӨХК-н 2024 оны 10 дугаар сарын байдлаар хэрэглэгчдийн (ОСНААУГ, ХОСК, Аж ахуй нэгж, Төсвийн байгууллагын) зуны засварын ажлын гүйцэтгэл 73%-тай хийгдсэн байна. Цахилгаан түгээх сүлжээнд холбогдсон .... хэрэглэгчийн шугам тоноглол ашиглалтын шаардлага хангахгүй, шаардлагатай засвар үйлчилгээг зохих түвшинд хийгээгүй гэсэн судалгаа гарсан байна.

3.2.4 Мэдээллийн нэгдмэл ил тод байдал, өгөгдөл

Салбарын оролцогч талууд нууцлах шаардлагаггүй мэдээллүүдийг ил тод байлгах, нэгдсэн сан байдлаар зохион байгуулж, хүртээмж хэрэглээг нэмэгдлүүлэх нь талуудын хооронд ойлгомжтой хялбар харилцаа бий болж, итгэлцлийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй. Салбарын мэдээллийн хүртээмж, ил тод байдал, зохион байгуулалт зэрэгт суурилсан үнэлгээг хийсэн.

Д/Д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Мэдээллийн нэгдэл, ил тод байдал**
		9.1.9. тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн санг бий болгож чадсан эсэх?
		2. Хэрэглэгчдэд чиглэсэн мэдээллийн ил тод хүртээмжтэй байдал ямар түвшинд байгаа вэ?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд
		2. E-LICENSE Тусгай зөвшөөрлийн цахим систем
		3. Эрчим портал

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Зохицуулах хороо энэхүү заалтын дагуу жил бүр цаасан хэлбэрээр тайлан, статистик хэвлэлийг эмхэтгэн гаргаж байна. Энэхүү арга хэлбэр нь бусад салбарт ашиглагдаж буй цахим системүүд болох статистикийн мэдээллийн нэгдсэн сан, төрийн мэдээллийн нэгдсэн сан гэх мэт системүүдтэй харьцуулахад цаасан суурьтай, мэдээлэл солилцох хурд удаан, дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал зэрэг хүндрэлүүдийг дагуулж байгаа бөгөөд орчин үеийн цахим нэгдсэн мэдээллийн системийг бий болгон хөгжүүлэх, мэдээлэл солилцох хурдыг нэмэгдүүлэх, ил тод байдлыг дээшлүүлэх, шийдвэр гаргалтанд ашиглах зэрэг олон эрэлт, хэрэгцээ үүсээд байна.

2024 оны байдлаар Эрчим хүчний яамны харьяа 29 байгууллага, мөн цахилгаан дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх, цахилгаан импортлох, эрчим хүчний барилга байгууламжийг барих тусгай зөвшөөрөл эзэмшиж буй 150 гаруй байгууллага байна. Эдгээр байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, цахим харилцааг нэмэгдүүлэх, салбарын статистик үзүүлэлт мэдээллүүдийг ил тод болгох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, зохион байгуулснаар мэдээлэлд хүрэх хурд, хүртээмж, судалгаа, шинжилгээнд ашиглах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Цаашид эрчим хүчний салбарт цахим нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл цуглуулах хөтлөх, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулах, мэдээллийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг хэрхэн зохицуулах бодлого нэн шаардлагатай.

3.2.5 Оролцогч талууд, тэдгээрийн эрх хэмжээ, үүрэг хариуцлага, хоорондын харилцаа, уялдаа холбоо

Эрчим хүчний салбарын оролцогч талуудад хуулиар олгосон эрх хэмжээ, хүлээх үүрэг хариуцлага, харилцан уялдаа холбоо нь зохистой, ойлгомжтой, хэрэгжихүйц тодорхойлогдсон эсэх, гарч буй үр дүн, практикт үүсч буй асуудлуудын хүрээнд үнэлгээ хийсэн.

Улсын их хурал

Д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэхь заалт:**
		Улсын Их Хурал эрчим хүчний талаархи төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.
		Харин түүний үүрэг, хариуцлагын талаар тухайлсан заалт байхгүй байна.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Эрчим хүчний салбарын бодлогыг УИХ тодорхойлох зорилгодоо хүрсэн эсэх?
		2. УИХ хуульд заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй бол ямар үүрэг, хариуцлага хүлээх?
		3. Эрчим хүчний салбарын асуудлаар УИХ-аас бусад оролцогч талуудтай харилцах харилцаа Эрчим хүчний тухай хуульд тухайлан заагдаагүй хэдий ч бусад хуулиар зохицуулагдсан эсэх?
		4. Хэрэв тийм бол эдгээр зохицуулалт нь эрчим хүчний салбарт УИХ өөрийн эрх хэмжээ, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бусад оролцогч талуудтай харилцан уялдаа холбоотой ажилладаг эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Улсын их хурлаас баталсан бодлогын баримт бичгүүд

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

УИХ-ын Эрчим хүчний тухай хуулиар олгогдсон эрх хэмжээ буюу эрчим хүчний салбарын бодлого боловсруулах эрх хэмжээний тухай заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ энэхүү үнэлгээний 3.1 дэх хэсэгт хийгдсэн бөгөөд үүгээр бодлого тодорхой хэмжээнд тодорхойлогдсон ч нэгдмэл биш, уялдаа холбоо муу, оновчтой бус, хамгийн гол нь түүний хэрэгжилт нь хангалтгүй байгааг харуулсан.

Эрчим тухай хуульд заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар үр дагавар үүсэх талаар тус хуульд тухайлан заагаагүй байна. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж

санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.”, Улсын Их Хурлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох. 34.1.Улсын Их Хурлын нэгэн бүрэн эрх дараах тохиолдолд энэ хуулийн 33.1-д заасан хугацаанаасаа өмнө дуусгавар болно: 34.1.1.Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж хугацаанаасаа өмнө тарах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол; 34.1.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн Улсын Их Хурал хугацаанаас өмнө тарах тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол. 34.5.Улсын Их Хурал өөрөө тарах бол тогтоол, Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах бол зарлиг гаргах бөгөөд эдгээр шийдвэр эцсийнх байна.” хэмээн УИХ өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлж чадаагүй тохиолдолд өөрөө болон Ерөнхийлөгч УИХ-ын Даргатай зөвшилцсөний үндсэн дээр тарах тухай хуульчилсан байна.

Үүнээс үзэхэд, УИХ өөрийн хуулиар олгогдсон эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй тохиолдолд зөвхөн улс төрийн хариуцлага буюу тарах хариуцлага л хүлээх боломжтой байна.

Иймд УИХ илүү үр ашигтай, оновчтой, цаг үеэ олсон, салбарыг хөгжилд хөтөлсөн бодлого боловсруулахыг эрх бүхий этгээдээс шаардах, мөн түүнчлэн өөрийн тодорхойлсон бодлогын хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангуулах хөшүүргийг бий болгосон зохицуулалтыг хуульд нэмж оруулах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын бусад оролцогч талуудтай харилцах харилцаа, уялдаа холбоо

Энэ талаар тухайлсан заалт Эрчим хүчний тухай хуульд байхгүй. Харин, Эрчим хүчний тухай хуулиар салбарын бодлогыг Төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх) боловсруулж (6.1.2), УИХ баталж (4.1), ЗГ салбарын яамны хамтаар хэрэгжүүлэх (5.1.1, 6.1.1) ёстой хэмээн зааж төрийн бодлогын асуудлаар УИХ, ЗГ, яам хэрхэн уялдаа холбоотой ажиллах талаар заасан байна. Гэсэн хэдий ч, салбарын төрийн бодлогын хэрэгжилт хангалттай бус байгаа талаар энэхүү үнэлгээний 3.1 дэх хэсгээс харж болно.

Түүнчлэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 3.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал хууль тогтоох, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүрэгтэй.” гэж заасны дагуу УИХ өөрийн тодорхойлсон аль ч салбарын бодлого болон баталсан хуулийн хэрэгжилтийг хянан шалгах эрхтэй байхаар хуульчилсан байна. Энэхүү хянан шалгах эрхээ Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх бүрэн боломжтой байна. Гэвч эрчим хүчний салбарын бодлогын хэрэгжилт болон салбарын хууль тогтоомжийн биелэлтийг тухайлан хянан шалгаж байсан тохиолдол одоогоор байхгүй байна.

Үүнээс харахад эрчим хүчний салбарын бодлогын асуудлаар харилцан уялдаа холбоотой ажиллах, бодлогоо тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар арга хэмжээ авах зэрэг асуудлууд бусад хуулиудаар тодорхой түвшинд зохицуулагдсан байгаа хэдий ч бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа нь

- Бодлогоо зөв зохистой тодорхойлж чадаж байгаа эсэх
- Бодлого ямар шалтгаанаар хэрэгжихгүй байгааг тогтоох эрх зүйн орчин нөхцөл бүрдсэн эсэх
- Бодлого хэрэгжүүлэх ямар арга хэмжээ авахыг хуулиар тодорхойлох шаардлагатай байна
- Бодлогыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хэн хэнд ямар хариуцлага хүлээлгэх

зэрэг асуудлуудыг хуульд тодорхой заагаагүйтэй холбоотой байна.

Иймд цаашид Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэн боловсруулахдаа салбарын бодлогыг УИХ тодорхойлох, энэ чиглэлээр бусад этгээдтэй уялдаа холбоотой ажиллах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлсэн, дээрх асуудлуудыг нарийвчилсан зохицуулсан заалтуудыг нэмж оруулах шаардлагатай байна.

Засгийн газар

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**5 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх**
		5.1.Засгийн газар эрчим хүчний талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
		5.1.1.эрчим хүчний талаархи төрийн бодлого, эрчим хүчний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
		5.1.2.эрчим хүчний зохицуулах хороог байгуулах, дүрмийг нь батлах;
		5.1.3.эрчим хүч хэрэглэх болон эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, дамжуулах сүлжээний хамрах хүрээг тогтоох;
		5.1.4.эрчим хүчний аюулгүйн нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нөөцийн жагсаалтыг батлах;
		5.1.5.эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг гаргах судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах;
		5.1.6. бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.
		Харин түүний үүрэг, хариуцлагын талаар тухайлсан заалт байхгүй байна.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		3. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилгодоо хүрсэн эсэх?
		2. ЗГ-ын эрх хэмжээг бүрэн, гүйцэд зохицуулсан эсэх?
		3. ЗГ хуульд заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй бол ямар үүрэг, хариуцлага хүлээх?
		4. ЗГ хуулиар хүлээсэн эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх үүрэг, хариуцлага?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Засгийн газрын эрх хэмжээний хүрээнд боловсруулсан, баталсан баримт бичгүүд, хэрэгжилтийн тайлан

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Засгийн газар Эрчим хүчний зохицуулах хороо цаашид /“Хороо” гэх/-г байгуулж, дүрмийг батлах нь түүний бие даасан байдалд хөндлөнгөөс нөлөөлөх, тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Учир нь ЗГ-н үйл ажиллагаа тогтворгүй, нэг ЗГ дунджаар 1.5 жил орчим хугацаанд үйл ажиллагаа явуулж байгаа нь Хорооны бүрэлдэхүүнийг мөн тогтворгүй байлгах, эсхүл үйл ажиллагаагаа тогтвортой бодлогоор явуулахад сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлж байна.

ЗГ-ын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, 2 дугаар хавсралтаар “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”, 3 дугаар хавсралтаар “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийг тус тус шинэчлэн баталсан[1]. Харин Дамжуулах сүлжээний хамрах хүрээ тогтоогоогүй байна[2]. Иймд хуулийн 5.1.3 дахь заалт зорилгодоо бүрэн нийцээгүй байна гэж дүгнэж болохоор байна.

ЗГ эрчим хүчний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түүний хөрөнгийн эх үүсвэрийг мөн бүрдүүлэх ийм нөөцийн жагсаалт батлаагүй байна.[3] Эрчим хүчний тухай хууль батлагдсанаас хойш 23 жил өнгөрсөн хэдий ч эрчим хүчний аюулгүйн нөөц гэсэн нэн чухал асуудлаар аливаа шийдвэр гаргаагүй байгаа нь тухайн заалтын зорилгод хүрсэн түвшинг хангалтгүй гэж дүгнэхээр байна.

ЗГ 2015 оны 360 дугаар тогтоолоороо "Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний нөөцийн үндэсний балансыг тооцоолохтой холбогдох зардлыг санхүүжүүлэх журам"-ыг баталсан.[4] Эрчим хүчний хөгжил, стратегийн судалгаа, шинжилгээний байгууллагын чиг үүргийг 1959 онд байгуулагдсан Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨҮГ хэрэгжүүлж байгаа бөгөөд 2014 оноос хойш Эрчим хүчний яамтай хамтран салбарын бодлого боловсруулах, норм нормативыг шинэчлэх, Эрчим хүчний салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх ойрын болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулах, эдийн засгийн тооцоо судалгаа хийх, тусгай зөвшөөрөл болон цахилгаан дулааны аудит хийх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.[5]

Эрчим хүч үйлдвэрлэгч нарт шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх талаар ЗГ-н зүгээс гаргасан ямар нэгэн шийдвэр, арга хэмжээ байхгүй. Хуулийн 5.1.6 дахь заалт ийнхүү хэрэгжээгүй шалтгаан нь тухайн заалтын гипотез нь тодорхой биш байгаагатай холбоотой байх магадлалтай бөгөөд хэрэгжүүлсэн тохиолдолд нэг мөр хэрэгжихүйц биш, хууль хэрэгжүүлэгчид үзэмжээр хандаж шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлсэн байгаа нь тухайн заалт зохицуулалтын зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй, практикт нийцээгүй гэж дүгнэхээр байна.

Засгийн газрын үүрэг, хариуцлага

ЗГ Эрчим хүчний тухай хуулиар салбарын төрийн бодлогын хэрэгжилт болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэгтэй хэдий ч хэрэв энэ үүргээ биелүүлээгүй бол ямар хариуцлага хүлээх талаар Эрчим хүчний хуульд тухайлан заагаагүй байна.

Харин Монгол Улсын Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар ЗГ нь УИХ-ын өмнө үйл ажиллагаагаа тайлагнах бөгөөд УИХ төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар ЗГ-т итгэл хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх, эсхүл Ерөнхий сайдыг огцруулж ЗГ-ыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах замаар түүнд улс төрийн хариуцлага тооцдог. Эрчим хүчний салбарын бодлогын асуудлаар УИХ-с ЗГ-т хариуцлага тооцож, огцруулах механизм хууль тогтоомжид байгаа хэдий ч ийнхүү хариуцлага тооцож байсан тохиолдол байхгүй. Үүнээс үзэхэд салбарын бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцох тухай заалтын хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Засгийн газрын бусад оролцогч талуудтай харилцах харилцаа, уялдаа холбоо

Д/Д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**5,6 дугаар зүйл. Засгийн газрын бусад оролцогч талуудтай харилцах харилцаа, уялдаа холбоо**
		5.1.2.эрчим хүчний зохицуулах хороог байгуулах, дүрмийг нь батлах;
		5.1.6.бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.
		6.1.Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
		6.1.1.эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. ЗГ-ын бусад оролцогч талуудтай харилцах харилцаа тодорхой, аливаа зөрчил, давхцалгүй, уялдаа холбоотой байдаг эсэх?
		2. УИХ, Засгийн газрын эрх хэмжээг дээрх заалтуудаар бүрэн гүйцэд, оновчтой зохицуулсан эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм 2. ЭХЯ-аас Засгийн газарт хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн байдал

ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

Засгийн газар Хороог байгуулах, дүрмийг батлах эрхтэй хэдий ч түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, чиглэл өгөх, шийдвэрт нөлөөлөх эрх хуулиар олгогдоогүй. Эрчим хүчний салбарын бодлогыг хэрэгжүүлэх нь ЗГ-ын үндсэн чиг үүрэг нь юм. Харин Эрчим хүчний хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах эрхтэй хэмээн Хорооны хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэгт халдах замаар Хорооны хэрэгжүүлэх заалтыг хэрэгжүүлэх ёсгүй юм. Иймд ЗГ, Хорооны бүрэн эрхийн зааг хязгаарыг хуулиар нарийвчлан зааж, зохицуулалт хийх шаардлагатай байна.

Төрийн захиргааны төв байгуулагын бүрэн эрх

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**
		6.1.1.эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;
		6.1.2.эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлогыг боловсруулах;
		6.1.6.тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах;
		6.1.8.эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэлийн статистик мэдээллийг авах, эрчим хүчний үндэсний баланс гаргах, нормативын баримт бичгийг батлах, стандарт боловсруулах;
		6.1.9.эрчим хүчний нөөцийн үнэлгээ хийх журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж хэрэгжүүлэх;
		6.1.10.эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах;
		6.1.12.эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаарх төрийн бодлого боловсруулахад шаардагдах тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;
		6.1.13.эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Яамны эрх хэмжээг бүрэн, оновчтой зохицуулж чадсан эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. Тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж дүгнэлт гаргах талаарх мэдээлэл

ҮНЭЛСЭН БАЙДАЛ.

Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эрчим хүчний яам (цаашид “Яам” гэх) нь Эрчим хүчний тухай хуулиар 17 бүрэн эрхийг эдэлдэг байх бөгөөд эдгээр эрхүүдийг холбогдох асуудлаар нь багцалж үнэлгээ хийлээ.

Эрчим хүчний салбарын төрийн бодлогыг болосвруулах бүрэн эрх (6.1.2, 6.1.10, 6.1.12) болон тухайн болдлогын үндсэн асуудал-эрчим хүчний эх үүсвэртэй холбоотой судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх; шинэ эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг баталгаажуулах, магадлал хийх; төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах; концессоор хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, санал гаргах, хэрэгжилтэнд хяналт тавих зэрэг эрхийг Яам эдэлдэг. Гэвч салбарын бодлого боловсруулалт болон түүнд шаардлагатай тооцоо, үнэлгээ, дүн шилжилгээ хийх ажил, бодлого тодорхойлолт, хэрэгжүүлэлт, мөн төсөл

арга хэмжээний хэрэгжилт тун хангалтгүй байгаа нь энэхүү Үнэлгээний 1.1 дэх хэсэгт үнэлэгдсэн байдлаас үзэхэд эдгээр заалтын зорилгодоо хүрсэн түвшин тун хангалтгүй гэж дүгнэхээр байна. Иймд тухайн заалтуудын хэм хэмжээний гипотезыг нарийвчлан тодорхой тогтоох, түүнчлэн эрчим хүчний салбарын байх ёстой болон ирээдүйд хүрэхээр зорьж буй түвшинг зорилго, эсхүл зарчим болгон тодорхойлж хуульчилж өгөх нэн шаардлагатай байна.

Яамнаас батлан гаргах ёстой дүрэм, журмуудын талаарх заалтын хэрэгжилтийн тухайд 6.1.4 дэх заалтад заагдсан "Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүсэх тохиолдолд түлш, эрчим хүчний хангамжийн талаар мөрдөх журам"-ыг Эрчим хүчний сайдын 2019 оны 158 дугаар тушаалын хавсралтаар баталсан[6]; 6.1.5 дахь заалтад заагдсан дүрэм, журмуудыг Дэд бүтцийн сайдын 2003 оны 125 дугаар тушаалын хавсралтаар "Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтыг дүрэм"[7], Түлш, эрчим хүчний сайдын 2005 оны 87 дугаар тушаалын хавсралтаар "Эрчим хүчний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, засварын ажлын журам"[8], Эрчим хүчний сайдын 2015 оны 188 дугаар тушаалын хавсралтаар “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх журам”[9]-г тус тус баталсан; харин 6.1.9 дэх заалтад заагдсан эрчим хүчний нөөцийн үнэлгээ хийх журмыг өнөөдрийг хүртэл батлаагүй байна. Иймд Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заагдсан Яам дүрэм, журам батлахтай холбоотой заалтууд бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэхээр байна.

Бусад оролцогч талуудтай уялдаа холбоо, үүрэг хариуцлага

Д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Төрийн захиргааны төв байгууллагын бусад оролцогч талуудтай уялдаа холбоо, үүрэг хариуцлага**
		6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
		6.2.Эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөхөд эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө.
		37 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
		37.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		3. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Эрчим хүчний яамны бусад оролцогч талуудтай харилцах харилцаа уялдаа холбоотой байгаа эсэх?
		2. Яам хуулиар заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлээгүй тохиолдолд зохих үүрэг хариуцлагыг бүрэн оногдуулж чаддаг эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Эрчим хүчний сайд эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүгийн удирдлагыг томилох, чөлөөлөхдөө эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө гэж заасны “эрх бүхий байгууллага” гэдэг нь тодорхой биш, эрх бүхий хэмээн тухай асуудлыг хариуцах этгээдэд хэн ч байж болохоор урвуулж ашиглах боломжтой орон зай үүсгэсэн заалт байна, иймд цаашид тодорхой болгон хуульчлах шаардлагатай байна.

Түүнчлэн салбарын компаниудын удирдлагыг чөлөөлөхдөө ямар үндэслэлээр, хэрхэн чөлөөлөх талаар заалт байхгүй байгаа нь тухайн компаниудын удирдлагыг хариуцлагажуулах сэдэлгүй болгох үндэслэлтэй тул энэ талаар мөн нарийвчлан зааж, Яамнаас салбарын компаниудыг хянан тогтолцоог мөн бий болгох шаардлагатай байна. Иймд энэхүү заалтын зохицуулалтын зорилгодоо хүрсэн түвшинг хангалтгүй гэж дүгнэхээр байна.

Яамны хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой заалт нь Эрчим хүчний тухай хуулийн “37 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага. 37.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн заалт байна.

Харин Төрийн албаны тухай хуульд “37.1.Төрийн албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 37.1.8.өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;” гэж заасан байна. Дээрх заалтуудаас Яамны бүрэн эрхийг холбогдох сайд нь тушаал гаргах замаар хэрэгжүүлдэг. Тиймээс дээрх заалтуудын дагуу Сайд /төрийн улс төрийн албан хаагч/ Эрчим хүчний тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд яг ямар хариуцлага хүлээх тодорхой биш, хэт ерөнхий тухайн заалтуудын хэм хэмжээний санкцын элементгүй байгаа нь хэрэгжилт нь бүрэн хангагдах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.

Бүрэн эрх гэдэг нь зөвхөн эрх бус, мөн үүргийг заадаг эрх зүйн ойлголт юм. Гэтэл Яамны бүрэн эрхийн талаарх заалтууд нь зөвхөн эрх олгосон, харин үүрэг болгосон шинжийг агуулаагүй байгаа нь түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг мөн бүрдүүлээгүй байна.

Иймд дээрх заалтууд нь хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцээгүй, зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй байна гэж дүгнэхээр байна.

Эрчим хүчний зохицуулах хороо

Д/Д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**8 дугаар зүйл. Эрчим хүчний зохицуулах хороо**
		8.1.Эрчим хүчний зохицуулах хороо /цаашид "Зохицуулах хороо" гэх/ нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах, үнэ тарифыг тогтоох, эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.
		8.2.Зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдана.
		8.2.Зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдана.
		8.3.Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 3 жилийн хугацаагаар томилно. Томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.
		37 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
		37.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		3. Практикт нийцэж буй байдал
		4. Бусад үр дагавар
		1. Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн статусыг тодорхойлох буюу ямар бүтэцтэй, ямар байгууллага байх талаар хуульчлах зорилгодоо хүрсэн эсэх?
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Эрчим хүчний зохицуулах хорооны бүтэц оновчтой эсэх?
		2. Түүний томилгооны процедур оновчтой эсэх?
		3. Бүтэц, томилгоо нь түүний бие даасан байдлыг хангаж чадаж байгаа эсэх?
		4. Хорооны хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд, эсхүл хууль зөрчсөн тохиолдолд зохих үүрэг, хариуцлагыг оногдуулж чаддаг эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1.“Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” гэж ямар байгууллагаас зохицуулагчийн томилгооны санал өгдөг талаар ЭХЗХ-с мэдээлэл гаргуулах, өөрөөр хэлбэл энэ төрлийн ямар байгууллага МУ-д үйл ажиллагаа явуулдгаас аль байгууллагаас нь санал авдаг талаар тодруулах
		2. Бүтэц, томилгооны улмаас ЭХЗХ-ны бие даасан байдал хангагдахгүй байх нөхцөл байдал үүсгэдэг талаарх мэдээлэл
		3. Үндэсний аудитын газрын холбогдох шийдвэрүүд

Эрчим хүчний зохицуулах хорооны статус

Эрчим хүчний зохицуулах хорооны эрх зүйн статус буюу төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээд зэргийн аль нь болох нь тодорхойгүй байна. Эрх зүйн статус тодорхойгүй байх нь түүний бие даасан байдлыг хэрхэн хангах асуудлыг тодорхойгүй болгохоос гадна, түүнд аливаа хэлбэрээр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж, нөлөөлсөн тохиолдолд ямар үүрэг, хариуцлага хүлээх нь тодорхойгүй байх үндэслэлийг бий болгосон байна. Түүнчлэн, ЭХЗХ хууль зөрчсөн тохиолдолд ямар үүрэг хариуцлага хэрхэн хүлээлгэх асуудал мөн тодорхойгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд түүний эрх зүйн статусыг тодорхой болгож хуульчлах зайлшгүй шаардлагатай байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны бүтэц, томилгоо, бие даасан байдал

Эрчим хүчний зохицуулах хороо бүтцийн хувьд 5 зохицуулагчийн 3-г ЭХЯ-с, 1-г бизнес эрхлэгчдийн эрх ашгийг төлөөлүүлэн МҮХАҮТ-с, 1-г хэрэглэгчийн эрх ашгийг төлөөлүүлэн Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс санал авснаар Ерөнхий сайдтомилдог.

ЭХЗХ шийдвэрээ зохицуулагчдын зөвлөлийн хурлаараа хэлэлцэж, тогтоол гаргах замаар гаргадаг. 9.2. Хуульд ЭХЗХ тогтоол гаргахдаа ердийн олонх эсхүл дийлэнх олонхийн аль зарчмаар шийдвэрээр гаргадаг талаар нарийвчлан тусгаагүй байх тул түүнийг ердийн олонхоор шийдвэрээ гаргадаг гэж үзнэ. Ердийн олонхоор шийдвэр гаргахад 3 зохицуулагч санал нэгдвэл шийдвэр гаргаж чадна гэсэн үг. Гэтэл Хорооны шийдвэрийг гаргах боломжтой олонхийг бүрдүүлэхүйц хэмжээний буюу гурван зохицуулагчийг нэг ашиг сонирхол бүхий оролцогч тал буюу эрчим хүчний асуудал эрхэлсэн сайдын санал болгосноор томилж байгаа нь зөвхөн нэг оролцогч талын эрх ашгийн төлөөллөөр Хорооны шийдвэр гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, үлдсэн хоёр ашиг сонирхлын бүлгүүдийн эрх ашгийн төлөөлөл Хорооны шийдвэрт тусахгүй байх бүрэн боломжтой байх нөхцөл бүрдсэн байна.

Үүрэг хариуцлага

Хорооны эрх зүйн статус тодорхой хуульчлагдаагүйгээс түүний зохицуулагчид болон бусад ажилтнуудыг төрийн албан хаагч гэж үзэх эсэх тухай асуудал тодорхой биш байна. Хэрэв тийм биш бол Эрчим хүчний тухай хуульд дээр заасан 37.1 дэх хэсгийн заалтаас өөр тухайн салбарын албан тушаалтнуудын хариуцлагын асуудлыг зохицуулалт өөр заалт байхгүй байна.

Иймд Эрчим хүчний тухай хууль тухайн салбарын албан тушаалтнууд, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон заалтуудыг хуульчлах шаардлагатай байх бөгөөд дээрх заалт нь хэрэгцээ, шаардлага, зорилготойгоо нийцээгүй, зорилгодоо хүрээгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй, практикт нийцээгүй байна гэж дүгнэхээр байна.

Диспетчерийн үндэсний төв

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**10 дугаар зүйл. Диспетчерийн үндэсний төв**
		10.1.Диспетчерийн үндэсний төв нь нэгдсэн сүлжээгээр эрчим хүч импортлох, экспортлох, эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.
		10.2.Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулна.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		3. Практикт нийцэж буй байдал
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Диспетчерийн үндэсний төвийн чиг үүрэг, ямар бүтэцтэй, ямар статустай байгууллага байх талаар хуульчлах шаардлагатай эсэх?
		2. Нэгдсэн сүлжээгээр эрчим хүч импортлох, экспортлох, эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байна гэх заалт зорилгодоо хүрсэн эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1. "ДҮТ" ТӨХХК-ийн чиг үүрэг хууль болон засгийн газрын тогтоолтой зөрчилддөг эсэх үүний улмаас түүний үйл ажиллагаанд ямар нэгэн хүндрэл бэрхшээл учирдаг талаар мэдээлэл гаргуулах,
		2. Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг хэрхэн зохицуулах эрх зүйн үндэслэлийг гаргуулах
		3. Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх тухай мэдээлэл гаргуулах

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

МУ-ын Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн дугаар 164 тогтоолоор “Цахилгаан, дулааны эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх, энэ чиглэлээр эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, салбарын боловсон хүчнийг дадлагажуулах, мэргэшүүлэх, холбогдох байгууллагуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий "Диспетчерийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани”-ийг үүсгэн байгуулсан.

Гэтэл хуулиар ДҮТ-д олгогдсон бүрэн эрх нь нэгдсэн сүлжээгээр эрчим хүч импортлох, экспортлох, эрчим хүчний диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байхаар зохицуулсан байна. Иймд түүний чиг үүргийг тодорхой болгож зөрчилтэй зохицуулалтыг арилгаж хуульчлах шаардлагатай.

Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулна гэх зохицуулалтыг ойлгомжтой байдлаар томьёолох шаардлагатай байна.

ДҮТ-ийн бүтэц, түүний томилгоо, бие даасан байдлын талаар хуулийн зохицуулалт байхгүй байна. ЭХТХ-ийн 10.3-т “Диспетчерийн үндэсний төв нь диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний хөлс, тухайн жилийн төсвөө эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг түүнд жил бүр тайлагнана” гэж заасан байна.

Энэ зохицуулалт үндсэндээ тус байгууллагыг яамны хэрэгжүүлэгч агентлагтай адил статустай төрийн байгууллага нөгөө талаар үндсэн үйл ажиллагаа нь диспетчерийн зохицуулалт хийх, цахилгаан импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч байхаар тусгасан нь төсөв, томилгооны хувьд хараат эрх хэмжээ хязгаарлагдмал байгууллага болохыг харуулж байна.

Чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтын хувьд мэргэжлийн чиглэл рүү хандсан ил тод нээлттэй, бие даасан болгох эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна. "ДҮТ" ТӨХХК-ний хэт төвлөрсөн ажлын ачааллыг Дорнод, Төв, Өмнөд, Улиастай Алтайн гэсэн байдлаар бүсчлэн диспетчерийн зохицуулалт хийх боломжтой эсэхийг судлах шаардлагатай.

Мөн системийн техникийн зохицуулалт болон арилжааны зохицуулалтыг нэг субьект хэрэгжүүлж байгаа нь оновчтой эсэх, сонирхлын зөрчил үүсэх боломжтой эсэх зэргийг нарийвчлан судалсны үндсэн дээр, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатай гэж дүгнэсэн.

Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөл

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**11 дугаар зүйл. Аймаг нийслэлийн зохицуулах зөвлөл**
		7.1.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаархи бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
		11.1.Аймаг, нийслэлд эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл хэрэгжүүлнэ.
		11.2.Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь нийт гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Гурван гишүүний нэг нь орон тооны байна. Зохицуулах зөвлөлийг байгуулах, түүний гишүүнийг томилох журмыг Зохицуулах хороо тогтооно.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж буй байдал
		3. Бусад үр дагавар
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн эрх зүйн статусыг тодорхойлох буюу ямар бүтэцтэй, ямар байгууллага байх талаар хуульчлах зорилгодоо хүрсэн эсэх?
		2. АНЗЗ-ийн бүтэц оновчтой эсэх?
		3. Түүний томилгооны процедур оновчтой эсэх?
		4. Бүтэц, томилгоо нь түүний бие даасан байдлыг хангаж чадаж байгаа эсэх?
		5. АНЗЗ-ийн шийдвэрийг мэргэжлийн байгууллага хянаж үзэх боломжтой эсэх?
		6. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх хэмжээ, үүргийг эрчим хүчний салбарт зөв тодорхойлсон эсэх?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
5	Мэдээлэл цуглуулах	1.АНЗЗ-ийн эрх зүйн статус тодорхойгүй байгаагийн улмаас түүний үйл ажиллагаанд ямар нэгэн хүндрэл бэрхшээл учирдаг талаарх мэдээлэл гаргуулах
		2.Хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх талаар мэдээлэл гаргуулах
		3.Бүтэц, томилгооны улмаас АНЗЗ бие даасан байдал хангагдахгүй байх нөхцөл байдал үүсгэдэг талаарх мэдээлэл
		4.АНЗЗ ажлын ачааллын судалгааг авах
		5.АНЗЗ-үүдээс АНЗД түүний үйл ажиллагаанд ямар нэгэн бодитой дэмжлэг үзүүлдэг эсэх талаарх мэдээлэл гаргуулах

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аймаг,нийслэлийн зохицуулах зөвлөлийн эрх зүйн статус буюу төрийн байгууллага, хуулийн этгээд аль нь болох нь тодорхойгүй Төрийн албаны тухай хуульд заасан ангилалд хамаарахгүй байна. Иймд түүний эрх зүйн статусыг тодорхой болгож хуульчлах шаардлагатай байна.

- АНЗЗ асуудлыг хурлаараа хэлэлцэж, тогтоол баталж мөрдүүлэн ажилладаг. Гэвч энэхүү үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад тухайн хурлаар асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах процесс, дагаж мөрдөх заалтыг хуульчилж оруулаагүй байна. Энэ нь хуулиар тусгайлан эрх олгогдсон байх гэсэн зарчимтай зөрчилддөг, цаашид захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр мөн эсэх, шүүхэд маргаан шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл үүсэх нөхцөл бүрдсэн байна гэж үзэхээр байна.
- Ердийн олонхоор шийдвэр гаргахад 2 зохицуулагч санал нэгдвэл шийдвэр гаргаж чадна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, үлдсэн 1 гишүүний санал ашиг сонирхлын бүлгүүдийн эрх ашгийн төлөөлөл шийдвэрт тусахгүй байх нөхцөл бүрдсэн байна.
- АНЗЗ асуудлыг шийдвэрлэхдээ илтэд хууль зөрчсөн, нийтийн эрх ашигт хохирол учруулсан талаар хараат бус мэргэжлийн байгууллагыг дүгнэлтийг үндэслэн ЭХЗХ шийдвэрийг хянаж үзээд уг тогтоолыг хүчингүй болгох, сэргээх, түдгэлзүүлэх эрхтэй байхаар зохицуулалт хийх. Учир нь ЭХЗХ нь АНЗЗ-ийг томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэй байгууллага.
- АНЗЗ-ийн гишүүн нь эрчим хүчний салбарт 3-аас доошгүй жил ажилласан байх гэсэн туршлагыг заасан зохицуулалт хийх салбарын мэргэжлийн хүн байх шалгуурыг тавих шаардлагатай.
- АНЗЗ-ийн үнэ тариф батлах, тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаанд мэргэшсэн ажилтны орон тоог бий болгох, уг ажилтны цалин урамшууллын асуудлыг тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлснөөс санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгох.
- Аймаг,нийслэлийн зохицуулах зөвлөл нь албан өрөө тасалгаа байдаггүй, хурал хэвийн явуулах нөхцөл боломж хязгаарлагдмал байдаг тул Аймаг, нийслэлийн Засаг дарга зохицуулах зөвлөл хэвийн ажиллах нөхцөл боломжоор хангах, бодитой дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид

д/д	ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	
1	Үнэлгээний хүрээ	**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн статус, тэдгээрийн эрх хэмжээ, үүрэг хариуцлага, хоорондын харилцаа, уялдаа холбоо**
		Хуулийн 9, 13-20 дүгээр зүйл
		14.4.Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.
		16.5.Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байх бөгөөд эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байж болно.
		9.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх;
		14.2.2.энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмыг боловсруулах, батлуулах, мөрдөх;
		16.3.2.энэ хуулийн 9.1.13.-т заасан холболтын журмыг боловсруулах, батлуулах, мөрдөх;
		12.5.Иргэн, хуулийн этгээд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй, хүн амын хэвийн амьдралд хохирол учруулахааргүй аргаар зөвхөн өөрийн хэрэгцээг хангах зорилгоор 1.5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрөл авахгүй.
2	Тогтоосон шалгуур үзүүлэлт	1. Зорилгод хүрсэн түвшин
		2. Практикт нийцэж буй байдал
		3. Бусад үр дагавар
3	Томьёолсон шалгуур үзүүлэлт	1. Дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээнд өмчлөлийн маргаан байдаг уу, Хэрэглэгчдийн эрх ашиг хохирдог уу? Энэ талаарх зохицуулалтыг эргэн харах шаардлагатай юу?
		2.Түгээх хангах тусгай зөвшөөрлийг хамтад нь эзэмшсэн тохиолдолд монополь үүсэж хэрэглэгч хохирох эрсдэлтэй юу?
		3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой маргааныг хөндлөнгийн /Хуучнаар мэргэжлийн хяналтын байгууллага, одоогийн салбарын хяналт, хотын стандарт хяналтын газар/ мэргэжлийн байгууллага дүгнэлт гаргасан тохиолдолд түүнийг ЭХЗХ бүрэн эрхийн хүрээнд авч шийдвэрлэх эрх зүйн үндэслэл шаардлагатай эсэх?
		4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч холболтын журмыг боловсруулсан тохиолдол байгаа юу, хуулийн заалт хэрэгжиж байна уу?
		5. 1.5 МВт-аас дээш 5 МВт хүртэлх хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрлийг ямар субъект олгох бэ?
4	Харьцуулах арга	Байх ёстой ба одоо байгаа
		Тохиолдол судлах
5	Мэдээлэл цуглуулах	1. Дулаан дамжуулах, түгээх шугам сүлжээний өмчлөлтэй холбоотой ямар нэгэн хүндрэл бэрхшээл учирдаг талаар мэдээлэл гаргуулах
		2. Эрчим хүчний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дах заалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэх мэдээлэл гаргуулах
		3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаатай холбоотой гомдлын тоо, шийдвэрлэлтийн байдлын судалгааг гаргуулах
		4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч ЭХЗХ-д холболтын журмыг боловсруулсан төслөө хүргүүлсэн мэдээллийг гаргуулах
		5. 1.5 МВт-аас дээш 5 МВт хүртэлх хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр зөвшөөрөл авах хүсэлт гаргасан тохиолдлын судалгааг авах

ҮНЭЛСЭН БАЙДАЛ

ЭХТХ-ийн 16.5-т “Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байх бөгөөд эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байж болно”. гэсэн заалт нь бодит амьдрал дээр монополыг дэмжсэн зохицуулалт байна. Учир нь эрчим хүч түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн нутаг дэвсгэртээ хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийг орон зайг оруулдаггүй өрсөлдөөнийг хязгаарладаг улмаар дагнан мэргэжлийн үйл ажиллагаа үзүүлэх боломжгүй байдлыг бий болгож байна. Иймд хуульд “түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүчээр хангагч байж болохгүй” гэсэн зохицуулалтыг тусгах шаардлагатай.

Эрчим хүчний зохицуулах хорооны бүхэн эрхэд хамаарах ЭХТХ-ийн 9.1.6.-т “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэх” гэж заасан нь Хороо хэрэглэгчийн бүх өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хэт их ачааллыг бий болгож байна. Иймд хуульд “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн харьяаллын дагуу шийдвэрлэх” гэж өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчийн гомдлыг орхигдуулж байгаа хэлбэр биш харин иргэнээс ирсэн гомдлын дагуу хөндлөнгийн мэргэжлийн байгууллага эрх ашиг нь зөрчигдсөн тухай дүгнэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл байхаар тусгаж уг эрхийг ЭХЗХ-д өгөх хэрэглэгчийн эрх ашгийг бодитой хамгаалж байгаа хэлбэр юм.

ЭХТХ-ийн 14.2.2-т заасан холболтын журамнь иргэн хуулийн этгээд сүлжээнд шинээр холбогдоход тавигдах техникийн болон санхүүгийн шаардлагыг тодорхойлсон чухал ач холбогдолтой бичиг баримт бөгөөд энэ харилцаа олон улсын түвшинд мөрдөгддөг үндсэн зарчмаар бус хэрэгжиж байгаагаас сүлжээ төлөвлөлтийн маш олон асуудлууд үүссэн. Тиймээс шинэ холболтын журамд .тавигдах нийтлэг шаардлагуудыг хуульд тусгаж өгөх шаардлагатай

1.5 МВт-аас дээш 5 МВт хүртэлх хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр, түүний дамжуулах, түгээх шугам барих, ашиглахад тусгай зөвшөөрлийг ЭХЯ, ЭХЗХ, АНЗЗ –ийн алин олгох нь ойлгомжгүй байгаа тул хуульчлах шаардлагатай.

[1] https://legalinfo.mn/mn/detail?lawId=15260

[2] https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=33&active=1&sort=title&page=1

[3] https://legalinfo.mn/mn/law?page=law&cate=33&active=1&sort=title&page=1

[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11314

[5] http://meei.energy.gov.mn/timeline

[6] https://legalinfo.mn/mn/detail?lawId=14704

[7] https://legalinfo.mn/mn/detail?lawId=13087

[8] https://legalinfo.mn/mn/detail?lawId=8071


[9] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11554

3.3 Салбарын оролцогч талуудаас ирүүлсэн санал, байр суурь

Эрчим хүчний тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд оролцогч талуудын санал байр суурийг тандан судлах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 15-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ний өдрийн хүртэл “Санал авах нэг сарын аян”-г зохион байгуулсан.

Энэхүү санал асуулгад санал асуулгын хүрээнд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн саналуудыг нэгтгэн, зохицуулалтын хувьд зөрчилтэй, ойлгомжгүй, практикт нийцээгүй зүйл заалтууд, шинээр тусгах болон шинэчлэн тусгах зарчмын шинжтэй заалтуудаар ангилж, судалгаа хийсэн.

Нийт саналын тоо	216
Санал өгсөн байгууллага	10
Санал өгсөн иргэний тоо	22
Байгууллагаас ирсэн саналын тоо	128
Иргэнээс ирсэн саналын тоо	88
Саналын агуулга	
Хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	47
Шинээр заалт нэмэх	22
Заалт хасах	4
Зарчмын шинжтэй санал	143



Агуулгын буюу зарчмын шинжтэй 143 санал ирснийг энэхүү тайланд хавсралтаар оруулсан бөгөөд гол хуулийн агуулга, үзэл баримтлалын хүрээнд илэрхийсэн санал, байр сууриудыг дурдвал:

- Зохицуулах байгууллагын бие даасан, хараат бус зохицуулалт хийх эрх зүйн орчныг сайжруулах, УИХ-ын харъяаллын байгууллага болгох;
- Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог боловсронгуй болгож, бодит өртөг зардлыг хангахуйц, зах зээлийн зарчимд нийцсэн байх шаардлагыг зайлшгүй хэрэгжүүлэх зарчим болгон тусгаж өгөх;
- Хөрөнгийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, тарифыг түүнд үндэслэн хянах механизмыг бий болгох;
- Төрийн өмчит эрчим хүчний компаниудын удирдлагыг сонгон шалгаруулалтаар томилдог байх. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгон шалгаруулалтаар томилох;
- Салбарын хүний нөөцийн бодлого, стратегийн оновчтой болгох, мэргэжлиийн ур чадвар, чадавхийг дэмждэг, үнэлдэг тогтолцоог бүрдүүлэх;
- Салбарын ажиллагсдын нийгмийн баталгааг хангах асуудлыг эрх зүйн хүрээнд тодорхойлж өгөх;
- Төрийн өмчит компаниудыг олон нийтийн компани болгож, засаглал, менежментийг сайжруулах;
- Хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, зах зээлд нэвтрэхэд хязгаарлалт тавьж буй зохицуулалтуудыг эргэж харах, шинэчлэх;


- Хувийн хөрөнгө оруулалт бүхий эрчим хүч үйлдвэрлэгч, хангагчийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагыг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулсан нь нийцэл муутай, салбарын хуулиар зохицуулах, нөхцөл шаардлагад хуулиас давсан хэм, хэмжээ ашиглаж бизнесийн орсныг хязгаарлахгүй байх;
- Техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, үр ашгийн сайжруулах, урамшуулах бодит механизмуудыг бий болгох;
- Эрчим хүчний компаниудын ашиглалтаас бусад үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэх;
- Салбарын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх шаардлагуудыг хуульд тусгаж өгөх;
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах заалтуудыг тодорхой зохицуулалттайгаар тусгаж өгөх;
- Эрчим хүчний зүй бус хэрэглээ, төлбөрөө төлдөггүй зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах хуулийн зохицуулалттай болох;
- Төвлөрсөн бус сүлжээ, системийг дэмжих, эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах;
- Төрийн байгууллагуудтай харьцахад хүнд суртал, эс үйлдэл, шудрага бус явдал хувийн хэвшилд тулгардаг;
- Шугам тоноглолын эзэмшил, өмчийн харилцаа, хариуцлагын зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Зах зээлд өрсөлдөөний орчныг бий болгох, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих;
- Эрчим хүчний сайд, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга албан тушаалд 5,10-аас доошгүй жилийн туршлагатай, мэргэжлийн хүн томилох шаардлагыг хуульчлах;
- Тоолуур, хэмжих хэрэгслийн өмчлөл, тооцооны болон хяналтын тоолуур гэсэн ойлголтуудыг нэг мөр болгон зохицуулах;
- Захиалагчийн хяналт, зургийн экпертиз зэрэг ажлуудыг зөвлөх үйлчилгээгээр, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх;
- Эрчим хүчний дэвшилтэт технологи, бүтээгдэхүүнүүдэд гааль, НӨАТ-ын татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

Дээрхи жагсаалт санал, байр сууриуд нь олон нийтийн санал асуулгын хүрээнд салбарын оролцогч талуудаас ирүүлсэн саналууд бөгөөд, хуульд тусгахаар сонгосон саналууд гэж ойлгож болохгүй юм. Эдгээр асуудлуудыг хуулийн зохицуулалтын хамрах хүрээ, харилцан уялдаа холбоо, хөгжил дэвшлийг бий болгох үндэслэл, боломж, бодитой хэрэгжих орчин нөхцөл бүрдсэн эсэх зэрэг олон талын судалгаа шинжилгээнд үндэслэн хуульд хэрхэн тусгахыг тодорхойлох шаардлагатай. Тайланд оролцогч талуудаас ирүүлсэн саналын дэлгэрэнгүй судалгааг хавралт-1-т харуулсан болно.

3.4 Хуулийн зүйл, заалт бүрийн хэрэгжилтийн байдал

Эрчим хүчний тухай хууль анх 2001 онд 6 бүлэг, 38 зүйл, 288 заалттай батлагдсан бол хууль хэрэгжих хугацаанд нийт 15 удаа, хамгийн сүүлд 2024 онд өөрчлөлт орсноор 6 бүлэг, 38 зүйл, 328 зүйл заалт бүхий хуулийг мөрдөж байна. Хуульд нийт 15 удаагийн өөрчлөлтөөр нийт 174 заалтад өөрчлөлт орсон байна. Судалгаанаас 2011, 2015 онуудад томоохон хэмжээний өөрчлөлтүүд орсон байна.

Огноо	Нийт заалт	Нэмсэн	Нэмэлт оруулсан	Өөрчлөлт оруулсан	Өөрчлөн найруулсан	Өөрчлөн оруулсан	Хүчингүй болгосон
2001.11.30	2	-	-	1	-	-	1
2002.07.04	6	1	1	2	-	2	-
2007.01.11	2	2	-	-	-	-	-
2009.07.16	1	1	-	-	-	-	-
2011.12.09	52	18	1	13	15	-	5
2012.08.17	6	5	-	-	-	-	1
2015.06.09	1	1	-	-	-	-	-
2015.06.19	81	22	10	32	12	4	1
2015.12.04	1	-	-	-	1	-	-
2017.01.26	1	-	-	-	1	-	-
2022.04.22	3	-	-	2	-	1	-
2022.11.11	2	-	-	-	-	2	-
2022.12.09	1	1	-	-	-	-	-
2023.01.06	14	5	1	-	7	-	1
2024.06.05	1	1	-	-	-	-	-
Нийт	**174**	**57**	**13**	**50**	**36**	**9**	**9**



Хуулийн өөрчлөлт орсон заалтын дэлгэрэнгүй судалгааг хавсралт-2-т харуулсан.

Хуульд оруулсан өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл Эрчим хүчний талаарх төрийн байгууллагын бүрэн эрх (хоёрдугаар бүлэг), тусгай зөвшөөрөл(гуравдугаар бүлэг)-т голлох өөрчлөлтүүд хийгдсэн байна.

Огноо	Нийт заалт	1 дүгээр бүлэг	2 дугаар бүлэг	3 дугаар бүлэг	4 дүгээр бүлэг	5 дугаар бүлэг	6 дугаар бүлэг
2001.11.30	2	-	2	-	-	-	-
2002.07.04	6	-	-	-	-	6	-
2007.01.11	2	1	1	-	-	-	-
2009.07.16	1	1	-	-	-	-	-
2011.12.09	52	2	32	13	5	-	-
2012.08.17	6	-	6	-	-	-	-
2015.06.09	1	1	-	-	-	-	-
2015.06.19	81	12	27	20	10	10	2
2015.12.04	1	-	-	-	-	-	1
2017.01.26	1	-	-	-	-	-	1
2022.04.22	3	-	2	-	-	1	-
2022.11.11	2	-	-	-	-	1	1
2022.12.09	1	-	1	-	-	-	-
2023.01.06	14	-	-	14	-	-	-
2024.06.05	1	-	1	-	-	-	-
Нийт	**174**	**17**	**72**	**47**	**15**	**18**	**5**

Өөрчлөлтийн төрлөөр ангилж үзвэл нэмсэн заалт 57, өөрчлөлт оруулсан заалт 50 байгаа нь нийт өөрчлөлтийн 61.4%-ийг эзэлж байна.

Огноо	Нийт заалт	Нэмсэн	Нэмэлт оруулсан	Өөрчлөлт оруулсан	Өөрчлөн найруулсан	Өөрчлөн оруулсан	Хүчингүй болгосон
1 дүгээр бүлэг	17	9	3	2	3	-	-
2 дугаар бүлэг	72	31	6	18	9	-	8
3 дугаар бүлэг	47	10	2	18	15	-	1
4 дүгээр бүлэг	15	2	-	8	5	-	-
5 дугаар бүлэг	18	4	2	4	1	7	-
6 дугаар бүлэг	5	-	-	2	3	-	-
Нийт	**174**	**57**	**13**	**50**	**36**	**9**	**9**

Хуулийн зүйл заалт бүрээр хэрэгжилтийг зорилгодоо хүрсэн байдал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцсэн байдал зэргийг шалгуур болгон дүгнэсэн бөгөөд шалгуур үзүүлэлт тус бүрээр хангалтгүй хэрэгжилттэй байгаа заалтуудыг дараах байдлаар нэгтгэсэн.

Эрчим хүчний тухай хуулийн гол үзэл санаа, концепцийг илэрхийлэх гол гол зохицуулалтуудын хэрэгжилт, түүний үр нөлөө

***Журмын 3.4.1 заалт**: зорилгод хүрсэн түвшин-тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтооно.*

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Хэрэгжилт, үр дагавар
1	4.1.Улсын Их Хурал эрчим хүчний талаархи төрийн бодлогыг тодорхойлж, цөмийн эрчим хүчний эх үүсвэр барих асуудлыг шийдвэрлэнэ.	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах чадамжгүй, чадлын дутагдалтай, санхүүгийн алдагдалтай, найдвартай байдлын өндөр эрсдэлтэй өнөөгийн нөхцөл байдал нь бид урт хугацаанд оновчтой бодлого төлөвлөлт, стратеггүй ажиллаж ирсний тодорхой илрэл юм. УИХ-аас 2021 онд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлт удирдлагын тухай хуулийн хүрээнд Монгол улсын урт, дунд, богино хугацааны бодлого төлөвлөлтөд эрчим хүчний салбартай холбоотой зорилт, төслүүд тусгагдсан хэдий ч харилцан уялдаагүй, нарийн төлөвлөлт хийгээгүй, бодитой хэрэгжихүйц байдал нь тодорхойгүй зэрэг асуудлууд байна.
2	5.1.4.эрчим хүчний аюулгүйн нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нөөцийн жагсаалтыг батлах;	Стратегийн чухал салбарын хувьд аюулгүйн нөөцийн жагсаалт батлах, түүнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх нь эрсдлийн үед бэлэн байдлыг хангах онцгой ач холбогдолтой. Засгийн газар хуулийн энэ заалтын дагуу тодорхой арга хэмжээ аваагүй байна.
3	6.1.1.эрчим хүчний тухай хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх;	Хуульд төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр томьёолсон хэд хэдэн заалтууд хэрэгжээгүй, эрчим хүчний талаар төрөөс гаргасан бодлогын хэрэгжилт хангалтгүй байгаа зэргээс дүгнэхэд ерөнхий чиг үүргийн энэ заалт чанартай хэрэгжихгүй байгааг илтгэж байна.
4	6.1.2.эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаархи төрийн бодлогыг боловсруулах;	Улс орон бүр дунд ба урт хугацаанд эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах эх үүсвэр, дамжуулах түгээх сүлжээг барьж байгуулах зохион байгуулалтыг 4 ба түүнээс дээш жилийн үечлэлтэйгээр төлөвлөж хэрэгжүүлдэг. Гэтэл Монгол улсын хувьд энэхүү төлөвлөлтийг оновчтой хийгээгүй, хэрэгжүүлэх механизмыг бодитой төлөвлөөгүй байгаа нь өнөөгийн хямралт нөхцөл үүссэн нэг гол шалтгаан юм.
5	6.1.9.эрчим хүчний нөөцийн үнэлгээ хийх журмыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж хэрэгжүүлэх;	Эрчим хүчний ирээдүйн хангамжийг төлөвлөхөд нөөцийн үнэлгээ чухал ач холбогдолтой учраас энэ ажлыг тогтоосон журмын хүрээнд тогтмол хийгдэж байх ёстой. Эрчим хүчний нөөцийн үнэлгээ хийх журам батлагдаагүй.
6	6.1.10.эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах;	Хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, баталсан баримт бичиг байхгүй. Эрчим хүчний салбар хүний нөөцийн хомсдолд орох нь бодит хүндрэл байгаа өнөө үед салбарын хүний нөөцийн бодлогын асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай.
7	6.1.16. уламжлалт бус эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах;	Техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, нутагшуулах талаар тодорхой үзэл баримтлал, бодлого гаргаагүй.
8	7.3.Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, мод, бут, сөөгийг зайлуулах, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авна.	Хамгаалалтийн зурвас зөрчсөн газар олголт хавтгайрснаас энэ төрлийн зөрчилтэй иргэн, хуулийн эдгээдийг нүүлгэн шилжүүлэх ажил ямар ч үр дүнгүй, аюултай нөхцөл байдалд байсан хэвээр байна.

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Хэрэгжилт, үр дагавар
9	9.1.5.эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох;	Эрчим хүчний салбарын санхүү эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чухал нөлөөтэй байсан хуулийн энэ заалт үндсэндээ хэрэгжээгүй нь салбарын хэмжээнд санхүүгийн алдагдалтай, хуримтлагсан өр төлбөр үүссэн, бие даан хөрөнгө оруулалт хийх санхүүгийн чадавхи бүрдээгүй.
10	9.1.9.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах;	Эрчим хүчний салбарын мэдээлэл зохих хэмжээнд нэгтгэгдэж, нийтлэгдэж байгаа хэдий ч мэдээллийн нэгдсэн сан байдлаар зохион байгуулагдаагүй, хэрэгцээт мэдээллийг ил тод, хүртээмжтэй байлгах, судалгааны эргэлтэнд оруулах чиглэлд ахиц дэвшил гараагүй, хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн.
11	9.1.15.энэ хуулийн 25.1.9-д заасан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;	Үнэ тариф бодит өртөг зардлыг нөхөх түвшинд хүрээгүй байгаатай холбоотой дамжуулах түгээх сүлжээний 3-5 жилийн хөрөнгө оруулалтыг хуульд заасны дагуу хянах, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх заалт хэрэгжихгүй хэвээр байна.
12	9.1.17.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;	Хэрэглэгчид үүсэх ачааллыг бага байлгах зорилгоор эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөс бууруулж тогтоож байсан хэдий ч тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудал хуулийн заалтын дагуу хэрэгждэггүй. Эрчим хүчний реформын хүрээнд 2024 онд 130 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгасан нь анхны зохицуулалт болсон.
13	15.2.1.цахилгаан, дулааныг стандартын шаардлагад нийцүүлэн найдвартай хангах зорилгоор цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн шуурхай зохицуулах;	Эрчим хүчний салбарын хэмжээнд харилцан адилгүй хүчин чадалтай, техник, технологийн ялгамжаат онцлогтой, өртгийн хувьд харилцан адилгүй үйлдвэрлэгчдийн хувьд өрсөлдөөн үүсэх боломж хязгаарлагдмал. Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон эрчим хүчийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байгаа зэргээс хамаарч хамгийн бага өртгийн зарчимд нийцсэн диспетчерийн зохицуулалт хийх асуудал цэвэр эдийн засгийн утгаар хэрэгжих боломжгүй нөхцлийг үүсгэж байна.
14	16.3.4.цахилгаан, дулаан түгээх сүлжээгээр дамжуулан зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалт эрхлэх тэнцүү боломжийг эрчим хүчээр хангагч нарт олгох;	Хуулийн 16.5 заалтаар түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч байна гэсэн заалтын дагуу түгээх хангах үйл ажиллагааг нэг компани эрхэлж байна. Цаашид хангах үйл ажиллагааг зааглаж, зах зээлд өрсөлдөөн бий болгох суурь бүтцийг үүсгэх шаардлагатай.
15	16.3.6.түгээх сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх;	Эрчим хүчний үнэ тарифаас хамааралтай түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэл зохих түвшинд хийгдэхгүй байгаагаас хэрэглэгч сүлжээнд шинээр холбогдох боломжийг хязгаарласаар байна. Тодорхой статистик судалгааг тайлангийн хавсралт-3-т хэсэгт тусгасан.
16	18.1.Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авч, Зохицуулах хорооноос тогтоосон хэрэглэгчид худалдах болон цахилгаан экспортлох эрхийг олгоно.	Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон хэрэглэгчдэд зохицуулалтгүй хангалтаар эрчим хүч худалдах эрхийг аль нэг хуулийн этгээдэд олгосон тохиолдол одоогоор байхгүй байна.
17	26.2.4.үнийг инфляцтай уялдуулан тооцох;	Эрчим хүчний үнэ тариф инфляцаас хамаарч индексжих аргачлал, журмыг баталсан хэдий ч хэрэгжүүлээгүй.
18	26.2.5.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байх;	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүрдүүлж буй орлого нь түүний санхүүгийн чадавхи хэвийн байлгахуйц хэмжээнд байхгүй байгаасгаас санхүүгийн алдагдалтай ажилладаг.
19	27.3.Зохицуулах хороо нь зохицуулалтгүй хангалтаар үйлчлүүлж болох хэрэглэгчийг тэдгээрийн цахилгаан, дулааны хэрэглээг үндэслэн тогтооно. Эдгээр хэрэглэгч нь зохицуулалттай, эсхүл зохицуулалтгүй хангалтын алинаар үйлчлүүлэхээ сонгох эрхтэй.	Зохицуулалтгүй хангалт нь хангах ТЗЭ-дийн хооронд өрсөлдөөн бий болгохыг дэмжсэн зохицуулалт юм. Өнөөгийн зах зээлийн загварын хүрээнд хангагчдын хооронд өрсөлдөөн бий болох нөхцөл бүрдээгүй байна.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтээр хангалтгүй хэрэгжилттэй заалтууд:

***Журмын 3.4.4 заалт**: хүлээн зөвшөөрөгдсөн байдал-иргэд, хуулийн этгээдээс хууль тогтоомжийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана.*

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл тайлбар
1	6.2.Эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөхөд эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө.	Улс төрөөс хамааралтай томилгоонууд ихэвчлэн хийгддэг. Өрсөлдөөний зарчмаар, сонгон шалгаруулалтын үр дүнгээр удирдлагыг томилох нь сайн менежментийг бий болгох суурь зарчим болно.
2	9.1.19.тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэл, суурь зарчмыг техник, эдийн засгийн хувьд үр ашигтай, оновчтой байх нөхцөлийг шалгуур болгон тогтоох;	Заалт хэт ерөнхий байна. Нөхцөл, шалгуурыг Эрчим хүчний зохицуулах хороо журам гарган зохицуулсан хэдий ч журмаар захиргааны хэм хэмжээ тогтоох ёсгүй гэж шүүх үзсэн. Шүүх дээр үүсч байгаа маргаанууд ихэвчлэн тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаанууд байна.
3	9.1.24.нийслэл Улаанбаатар хот болон бусад хотын дэд бүтцийн санд хуульд заасан орлого төвлөрүүлэх.	Үндэслэл нь тодорхойгүй. Хэрэв энэ нь үндэслэлтэй бол тариф тооцох зарчим хэсэгт тусгах шаардлагатай.
4	12.6.Хэрэглэгчийн өөрийн технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тухайн хуулийн этгээдэд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдэд цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй.	Энэ заалт нь технологийн зориулалтаар баригдсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тусгай зөвшөөрөл олгохгүй байх нөхцлийг хуульчлах агуулгатай. Гэтэл тухайн хуулийн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд олгохгүй гэж заасан нь энэ шалгуурт хамаарахгүй бусад хуулийн этгээд тусгай зөвөшөөрөл авахыг хориглоогүй агуулгыг илэрхийлж байгаа нь үндсэн агуулгатайгаа зөрчилдсөн.
5	14.2.1.цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагааг болон хэрэглэгчийн цахилгаан, дулааны хэрэглээг найдвартай хангах, дамжуулах сүлжээг ашиглах, засвар үйлчилгээ хийх, өргөтгөх үйл ажиллагаа эрхлэх;	Эрчим хүний үнэ тариф бодит өртгөө нөхөхүйц түвшинд биш байгаагаас шаардлагатай их, урсгал засвар, өртгөтгөл шинэчлэлтийн зохих хэмжээнд гүйцэтгэж чадахгүй байна. Тухайлбал ЦДҮС ТӨХК нь жилд дунджаар 30-40 тэрбум төгрөгийн зардлаар ИЗА, ТБЗАХ, ХО, УЗА-г гүйцэтгэх ёстой боловч 12-16 тэрбум төгрөгт багтаан хийж байгаа нь дамжуулах сүлжээг өргөтгөх төслийг санхүүжүүлэх ямар ч боломжгүй нөхцлийг үүсгэдэг. Цахилгаан дамжуулах сүлжээ нь системийн найдвартай байдалд онцгой чухал үүрэгтэй, төрийн мэдлийн сүлжээ учраас эрчим хүчний үнэ тарифаар өргөтгөл шинэчлэлтийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломжгүй нөхцөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах зохицуулалт нэн шаардагатай байна
6	14.2.3.тусгай зөвшөөрөл эзэмшигчийг тэгш эрхтэйгээр дамжуулах сүлжээнд холбогдох нөхцөлийг бүрдүүлэх.	Дамжуулах сүлжээнд холбогдох техникийн нөхцлийг 1 МВт-аас дээш хүчин чадалтай бол ЭХЯ, 1МВт-аас доош хүчин чадалтай бол тухайн дамжуулах сүлжээ компани олгож байгаа. Эрчим хүчний систем чадлын дутагдалд орж, хэрэгцээт хүчин чадлыг хангах боломжгүй байгаагаас дамжуулах сүлжээнд холбогдох тэгш боломжийг хангаж чадахгүй байна. Дамжуулах сүлжээг хэт урт буюу стандарт бус 400-600 км урт нэг хэлхээт ЦДАШ-н онцлогоос хамаарч шинэ хэрэглэгч холбоход бараг боломжгүй нөхцөл үүсдэг. Тэгэхээр дамжуулах сүлжээнд шинээр кольцо схем үүсгэх, шугамын төгсгөлд хүчдэл уналт үүсдэг асуудлыг тархмал эх үүсгэврийн төслүүдийг хэрэгжүүлэх, эх үүсгэврийг оновчтой газарт барих зэрэг арга хэмжээг авах.
7	15.2.3.цахилгаан, дулаанаар хангах гэрээг Зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу бүртгэх;	Цахилгаан, дулаанаар хангах гэрээ нь хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хооронд байгуулдаг гэрээ бөгөөд ДҮТ ХХК-ийн чиг үүрэгт байх шаардлагаггүй заалт

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл тайлбар
8	16.3.7.энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 17.3-т заасан гэрээг байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох;	Хэрэглэгчийн эзэмшлийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох, түүнтэй борлуулалтыг гэрээгээр гүйцэтгүүлэх заалт бодит байдалд маш олон сөрөг үр дагаврыг үүсгэх заалт болох бөгөөд өнөөг хүртэл хуулийн энэ заалтын дагуу борлуулалтыг гэрээгээр хариуцуулсан тохиолдол гараагүй. Хуулийн 17.3-т заасан борлуулалтыг гэрээгээр гүйцэтгүүлэх гэсэн агуулгатай авцалдаагүй заалт гэж үзсэн. Хэрэглэгчийн шугам, дэд станц бүрээс хэрэглэгч холбосон тохиолдол бүрт гэрээт борлуулагч үүсэх агуулгатай байгаа нь зөрчил үүсгэж байна.
9	16.3.8.үйлдвэрлэгч, дамжуулагчтай байгуулсан гэрээний дагуу урьдчилан төлбөр хийсний үндсэн дээр цахилгаан, дулааныг худалдан авах.	Өнөөгийн байдлаар эрчим хүчний салбарт гэрээт зах зээлийн загвар хэрэгжиж эхлээгүй, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч үйлдвэрлэгч болон дамжуулагчтай гэрээ байгуулдаггүй.
10	16.4.Энэ хуулийн 16.3.3-т заасан тоолуур нь цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч байж болно.	Хөрөнгийн эх үүсвэриийн хязгаарлагдмал байдлаас хамаарч хэрэглэгч өөрийн тоолуурыг худалдан авч тавих нөхцөл үүсдэгээс хамаарч энэ заалтыг 2015 онд өөрчлөн найруулсан байна. Зарчмын хувьд түгээх компанийн өмч байж, тоолуурын нэгдсэн менежмент хэрэгжиж явах шаардлагатай.
11	25.1.11.үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх жил бүрийн төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулж мөрдөх;	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ нь харьцангуй өндөр өртөгтэй, түүний хүрээнд хийгдэх шаардлагатай ажлууд нь тодорхой хөрөнгийн эх үүсвэр шаардахаар байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8 заалтын дагуу шинээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төдийгүй, одоо үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдүүд ч нөлөөллийн үнэлгээ ба үнэлгээний дагуу байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах үүрэг хүлээж байна.
12	17.1.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах эрхийг олгоно.	Зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзмшигчээс бус зах зээлийн нэг худалдан авагч ДҮТ ТӨХХК-аас худалдан авч байна.
13	28.4.Эрчим хүчээр хангагч нь хэрэглэгчийн төлбөрийн чадварын талаар харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгааг үндэслэн эрчим хүчээр хангах гэрээг байгуулж болно.	Одоогоор хуулийн этгээдийн төлбөрийн чадварын талаар тодорхойлолт, баталгаа авдаг практик байхгүй байна. Төлбөрийн чадварын баталгаагүй бол цахилгаанаар хангахгүй байх нөхцөл нь нэг талаар хэрэглэгчид хүндрэл, дарамт үүсгэсэн заалт болохоор байна.
14	29.1.9.хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй.	Хангагч нь сүлжээ төлөвлөлтийн үндсэн дээр хэрэглэгчийн шугам, дэд станцад хэрэглэгч холбох эрх хэмжээ байхгүй. Зөвхөн хэрэглэгч зөвшөөрсөн тохиолдолд хэрэглэгчийг холбодог. Шугам сүлжээг өмчлөгч хэрэглэгч шинээр холбогдох хэрэглэгчээс өөрийн хөрөнгө оруулалтыг нөхөх гэсэн тайлбартайгаар хууль бус төлбөр нэхэмжлэх байдал түгээмэл байна. Мөн хяналтгүйгээр маш их хэмжээний хувийн өмчлөлтийн шугам, дэд станцууд бий болж байгаа нь сүлжээ төлөвлөлтийн бодлогыг алдагдуулж байна.
15	33.2.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.	Энэ заалтыг хэрэгжүүлдэггүй. Хамгаалалтын зурвас баталгаажуулах ажлыг хийхгүй байгаагаас хүн ам, нийгэмд аюултай нөхцөл байдал үүсэх эрсдэл ихэссээр байна.
16	37.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Эрчим хүчний тухай хууль нь эрчим хүчний салбарын харилцааг бүхэлд нь зохицуулж байгаа суурь хууль бөгөөд энэ хуулийг салбарын харилцаанд оролцож буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллага компаниуд дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Гэтэл хариуцлага хүлээлгэх асуудлыг Төрийн албаны хуулиар зохицуулна гэсэн нь зөрчил үүсгэж байна.

Практикт нийцсэн байдал шалгуур үзүүлэлтээр хангалтгүй хэрэгжилттэй заалтууд:

***Журмын 3.4.4 заалт**:практикт нийцэж байгаа байдал-тухайн хууль тогтоомжийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байгаа эсэхийг тодорхойлно.*

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл тайлбар
1	5.1.6.бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.	Шаардлагатай дэмжлэг гэдэг нь хэт ерөнхий, өргөн хүрээний ойлголт байж болохоор байна. Дэмжлэг үзүүлэх зарчим, нөхцлийг тодорхой заахгүй бол хэт субьектив үйлчлэлтэй заалт болохоор байна.
2	7.3.Тухайн нутаг дэвсгэр дэх эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, мод, бут, сөөгийг зайлуулах, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авна.	Хамгаалалтийн зурвас зөрчсөн газар олголт хавтгайрснаас энэ төрлийн зөрчилтэй иргэн, хуулийн эдгээдийг нүүлгэн шилжүүлэх ажил ямар ч үр дүнгүй, аюултай нөхцөл байдалд байсан хэвээр байна.
3	9.1.9.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах;	Эрчим хүчний салбарын мэдээлэл зохих хэмжээнд нэгтгэгдэж, нийтлэгдэж байгаа хэдий ч мэдээллийн нэгдсэн сан байдлаар зохион байгуулагдаагүй, хэрэгцээт мэдээллийг ил тод, хүртээмжтэй байлгах, судалгааны эргэлтэнд оруулах чиглэлд ахиц дэвшил гараагүй, хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн.
4	9.1.17.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;	Хэрэглэгчид үүсэх ачааллыг бага байлгах зорилгоор эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөс бууруулж тогтоож байсан хэдий ч тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудал хуулийн заалтын дагуу хэрэгждэггүй. Эрчим хүчний реформын хүрээнд 2024 онд 130 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусгасан нь анхны зохицуулалт болсон.
5	15.2.1.цахилгаан, дулааныг стандартын шаардлагад нийцүүлэн найдвартай хангах зорилгоор цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагааг техник, технологийн шаардлага, хамгийн бага өртгийн шалгуурт нийцүүлэн шуурхай зохицуулах;	Эрчим хүчний салбарын хэмжээнд харилцан адилгүй хүчин чадалтай, техник, технологийн ялгамжаат онцлогтой, өртгийн хувьд харилцан адилгүй үйлдвэрлэгчдийн хувьд өрсөлдөөн үүсэх боломж хязгаарлагдмал. Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон эрчим хүчийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж байгаа зэргээс хамаарч хамгийн бага өртгийн зарчимд нийцсэн диспетчерийн зохицуулалт хийх асуудал цэвэр эдийн засгийн утгаар хэрэгжих боломж хязгаарлагдмал.
6	16.3.3.эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан цахилгаан, дулааны тоолуурыг холболтын цэгт суурилуулах;	Техникийн хувьд холболтын цэгт суурилуулах боломжгүй нөхцлүүд байдаг. Тусгайлсан зохицуулалт шаардлагатай байдаг.
7	18.1.Эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авч, Зохицуулах хорооноос тогтоосон хэрэглэгчид худалдах болон цахилгаан экспортлох эрхийг олгоно.	Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон хэрэглэгчдэд зохицуулалтгүй хангалтаар эрчим хүч худалдах эрхийг аль нэг хуулийн этгээдэд олгосон тохиолдол одоогоор байхгүй байна.
8	25.1.3.санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр, тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх;	Санхүүгийн тайлан бүртгэлийн үйл ажиллагааны төрөл бүрээр тусад нь хөтлөх заалт бүрэн хэмжээнд хэрэгждэггүй.
9	28.5.Хэрэглэгч энэ хуулийн 27.5-д заасны дагуу мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор хангагчтай байгуулсан гэрээндээ зохих өөрчлөлт оруулах бөгөөд гэрээндээ өөрчлөлт оруулаагүй нь энэхүү өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.	Дулааны сүлжээ, хувийн орон сууцны компаниуд харьцангуй цөөн тооны хэрэглэгчтэй учраас үнэ тарифт өөрчлөлт орсон тухай бүр хангах гэрээнд өөрчлөлт оруулж, хэрэглэгчид утсаар, имэйлээр, мсж-ээр, биетээр зэрэг сувгаар хэрэглэгчид мэдэгддэг. Цахилгаан түгээх компаниуд ЭХЗХ-ны батлсан үнэ тарифыг мөрдөж ажиллана гэсэн гэрээний ерөнхий заалтыг баримталдаг. Хэрэглэгч нэг бүртэй гэрээ шинэчлэх нь механик ачаалал бий болгодог.

д/д	Хуулийн зүйл, хэсэг, заалт	Үндэслэл тайлбар
10	29.1.1.стандартын шаардлагад нийцсэн эрчим хүчээр хэрэглэгчийг хангах;	Дулааны сүлжээ төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, барилгын норм ба дүрэм баримт бичигт тусгасан шаардлагыг хангаж ажилладаг. Барилгын хийц, хуучралт, барилгын дулаан өөрийн дулаан алдагдлаас хамаарч дотор агаарын температур норм дүрмээ хангахгүй байх тохиолдлууд байдаг. Дулааны эрчим хүчний чанарын стандарт гэж байдаггүй. Цахилгаан түгээх сүлжээний хувьд алслагдсан цэгүүд, урт шугам, фазын ачаалын тэнцүүлэлт зэргээс хамаарч хүчдэл унах, ихсэх зэргээр стандарт зөрчих тохиолдлууд байдаг. Хангагчаас хамаарч стандартын шаардлага хангагдахгүй нөхцөлд хэрэглэгчийн эрхийг хэрхэн хамгаалах зохицуулалт тодорхой байх шаардлагатай
11	29.1.7.хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах гэрээг цуцлах, энэ хуулийн 33.1-д заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах;	Төлбөр, хамгаалалтын зурвасын зөрчлөөс хамаарч хангах гэрээг цуцалсан практик байхгүй. Ялангуяа хамгаалалтын зурвасын зөрчлийг шийдэх шийдэл огт байхгүй байна. Дулааны сүлжээний хувьд хамгаалалтын зурвас зөрчсөн 498 барилга, цахилгаан түгээхийн хувьд 2300 гаруй хэрэглэгч байна.
12	30.1.3.техникийн ашиглалтын болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх;	Сүлжээний ашиглалт, аюулгүй ажиллагааны талаарх хэрэглэгчийн мэдлэг мэдээлэл муу, мэдээллийн хүртээмж бага, хууль дүрмийг мөрдөх сахилга бат муу, хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоо сул байна. Өргөн хүрээнд хяналт тавих байнгын механизм ажиллаж чадахгүй байгаатай холбоотой.
13	30.1.5.эрчим хүчээр хангагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс эрчим хүч дутуу нийлүүлсэн, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй бол эрчим хүчний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;	Дутуу түгээсэн, стандартын шаардлага хангаагүй эрчим хүчээр хангасан нөхцөлд төлбөрийг хэсэглэн болон бүрэн төлөхөөс татгалзах, нөхөн төлөх, хохирол барагдуулах практик үндсэндээ байхгүй. Хэрэглэгч эрчим хүчний салбарын маш том хүнд суртал гэж хардаг.
14	30.1.8.өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах;	Хэрэглэгч техник ашиглалтын дүрмийн дагуу шугам тоноглолд засвар үйлчилгээ хийлгэх, стандартыг хангах асуудал туйлын хангалтгүй. Хэрэгжилтэнд хяналт тавих тогтолцоо сул, хүртээмж муу.
15	30.1.9.байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гэрээнд заасан эрчим хүчийг авахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа эрчим хүчээр хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэх;	Хэрэглээний захиалгын өөрчлөлт дээр зах зээлийн арилжаа хийгддэггүй учраас хангагч ямар нэг хариуцлага хүлээдэггүй, хэрэглэгчээс шаарддаггүй. Хэрэглэгч хэрэглээний төлөвлөлтөнд ач холбогдол өгдөггүй.
16	30.1.11.өөрийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан эрчим хүч бусдад дамжуулах, түгээх, тухайн хангагчаас үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу авах;	Өөрийн шугам, тоноглолоор дамжуулан эрчим хүч бусад дамжуулах, түгээх нөхцлүүд практикт олон байдаг боловч хэрэглэгч хангагчтай үйлчилгээний төлбөр авах гэрээ байгуулах тохиолдол маш цөөн, ихэнх тохиолдолд тухайн холбогдсон хэрэглэгчээс төлбөр гаргуулах байдлаар явагддаг.
17	31.1.Эрчим хүчээр хангагч, хэрэглэгчийн хооронд хийх эрчим хүчний хэрэглээний тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтыг үндэслэн мөрдөгдөж байгаа тариф, гэрээний үний дагуу тооцно.	Дулааны ахуйн хэрэглэгч болон жижиг аж ахуйн нэгжүүдийн дулааны төлбөр тооцоог тоолуураар биш, талбай, эзэлхүүнээр тооцож авдаг. Энэ нь эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг төлөвшүүлэхэд хязгаарлах хүчин зүйл болж байна.
18	31.2.Гэрээнд өөрөөр заагаагүй бол хэрэглэгч нь нийлүүлээгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн 5.0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг эрчим хүчээр хангагчаас нэхэмжлэх эрхтэй.	Хэрэглээний захиалыг сар улирал, өдрөөр өгөх, зах зээл дээр үйлдвэрлэл хэрэглээг тэнцвэржүүлэх процесс хэрэглэгчийн захиалга дээр үндэслэж төлөвлөгдөх үйл явц тасралтгүй хэрэгждэггүй учраас энэ заалт практикт хэрэгжих нөхцөл боломж хангагдаагүй байна.
19	33.1.Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	Газрын алба, Ерөнхий төлөвлөгөөний газар, хангагчийн ажлын уялдаагүй байдлаас шалтгаалан хамгаалалтын зурваст газар олгох хийгдэж эскиз зураг гарсаны улмаас зөрчлүүд ихсэж байна. УБДС ХК-д бүртгэгдсэн зөрчил 498 байна

ДӨРӨВ. ХАВСРАЛТУУД

Хавсралт-1

№	Хуульд ирүүлсэн саналууд
1	Хуулийн зохицуулалт, нэр томъёог хувийн хэвшлийн эх үүсвэр, шугам сүлжээний хувьд хэрхэн ойлгож хэрэглэх, дамжуулах сүлжээнд холбогдсон тохиолдолд хэрэглэгчтэй тохиролцон гэрээний үнээр эрчим хүч нийлүүлэх боломжгүй гэдэг ойлголтыг арилгаж, хувийн хөрөнгө оруулалт бүхий эрчим хүч үйлдвэрлэгч, хангагчийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бий болгох.
2	ЭХЗХ-г байгуулах, дүрмийг тогтоох бүрэн эрхийг УИХ-д шилжүүлэх;
3	**Эрчим хүчний тухай хуулийн 5.1.5 ЭХ-ний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, ЭХ-ний үндэсний балансыг гаргах судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах;** Шинэчилсэн хуульд энэ төрлийн дүрэм журам батлах, байгууллага байгуулах, тэдгээрийн зардлыг санхүүжүүлэх талаарх заалтыг тусгахдаа эдгээр нь холбогдох хууль тогтоомжийн шаардлагаас давсан болон хууль тогтоомжийг зөрчсөн, дордуулсан нөхцөл тусгахгүй байх, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хуулиар тогтоогоогүй татвар, хураамжийг бий болгохгүй байх, төрөөс ийм байгууллагуудыг байгуулахдаа үйл ажиллагаа нь төсвөөс санхүүждэг байх гэсэн үндсэн зарчмуудыг баримтлах шалгууртай болгох.ативын баримт бичиг боловсруулах, ЭХ-ний үндэсний балансыг гаргах судалгаа, шинжилгээний байгууллага байгуулах, түүнтэй холбогдох зардлыг санхүүжүүлэх журам батлах;
4	**Эрчим хүчний тухай хуулийн 5.1.6. бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх.** Ямар төрлийн дэмжлэг үзүүлэхийг тодорхой болгох. Санхүүжилт татаас өгөх, Засгийн газрын баталгаа гаргах гэх мэт.
5	Хуульд эрх бүхий байгууллагаас дүрэм журам батлах асуудлын үндсэн шалгуурыг хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамрах эсэхийг тодорхой тогтоож, хэт өргөн хүрээг хамрахаас хязгаарлах нөхцөлийг оруулах.
6	Эрчим хүчний тухай хуулийн 6.1.5 нэгдсэн сүлжээ, хийн хангамж, төвлөрсөн дулаан хангамжийн дүрэм, ЭХББ, тоног төхөөрөмжийн угсралт, засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны болон магадлал хийх дүрэм, журам батлах, хэрэглэгчийн зэрэглэлийг тогтоох;**Эрчим хүчний тухай болон холбогдох хуулиудад байнгын ашиглалтанд оруулах удирдлага, зохион байгуулалтын талаар тодорхой болгож нэмж оруулах. Хуульд зохицуулалтыг бий болгох. Холбогдох харилцааг журмаар биш хуулиар зохицуулдаг байх.**
7	Эрчим хүчний тухай хуулийн 6.1.15 ЭХ худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг холбогдох байгууллагад олгох; **Тус чиг үүргийг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхээс хасаж, энэхүү бүрэн эрхийг ДҮТ-рүү шилжүүлэх саналтай.**
8	Зарчмын санал: Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоохдоо хуульд зааснаас илүү шаардлага дотоод дүрэм, журмаар нэмж үүсгэхгүй байх, хувийн хөрөнгө оруулалтаар эрчим хүчний эх үүсвэр барих, ашиглалтад оруулах гэх мэт харилцаанд тавих нөхцөл шаардлага төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрөөс өөр байх, хэрэв тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад хууль заагаагүй нэмэлт нөхцөл, шаардлага оруулах, нэмж бий болгох шаардлагатай тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсний үндсэн дээр нөхцөл шаардлагыг тогтоох зэргээр зарчмын зохицуулалт шаардлагатай байна.
9	Зарчмын санал: Тарифын зохицуулалтыг эргэн харж, зах зээлийн зарчимд нийцүүлэх, чөлөөлөх
10	Эрчим хүчний тухай хуулийн 10.4.Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчээс сүлжээнд нийлүүлэх ЭХ-ийг энэ хуулийн 6.1.15-д заасны дагуу эрх авч гэрээ байгуулан, уг гэрээний дагуу зохицуулна. **ДҮТ ТӨХХК-д мэргэжлийн этгээдийн хувиар чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг олгох, энэ хүрээнд хуулийн заалтаас *эрх авч* гэдэг хэсгийг хасаж дараах байдлаар өөрчлөлт оруулах саналтай**. **10.4.Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчээс сүлжээнд нийлүүлэх ЭХ-ийг гэрээ байгуулан авч, уг гэрээний дагуу зохицуулна**
11	Эрчим хүчний тухай хуулийн 14.4.Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна. **Хувийн хөрөнгө оруулалтаар баригдах эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээний өмчөл болон тэдгээрийг ашиглах харилцааг тодорхой болгож хуульд хувийн өмчийн эх үүсвэр бүхий харилцааг зохицуулсан бүлгийг шинээр бий болгох, холбогдох нэр томьёо, нэгдсэн сүлжээний ойлголтод өөрчлөлт оруулах.**

12	Эрчим хүчний тухай хуулийн 22.1.Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрлийн хугацаа 5-25 жил, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацаа 5 хүртэл жил, бусад тусгай зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл жил байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 14.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргасан, холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа бол эрх бүхий этгээд тухайн зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацаагаар сунгана. хэмээн заасан бөгөөд тус хуулиудын зөвшөөрлийн сунгах хугацаа зөрчилдөж байна. Улмаар ЭХЗХ-с зөвшөөрлийг зөвхөн 5 жилийн хугацаагаар сунгах үндэслэлгүй шийдвэр гаргаж байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх ашигт хохиролтой байна. **Хууль хоорондын нийцлийг хангах.**
13	ЭХтХ-ийн 30.1.13 Хэрэглэгч нь нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барих тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх **Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 1.7; 11.8-д заасны дагуу, Эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг шилжүүлэхдээ, УК ажиллах үед тусгай зөвшөөрөл эзэмшигчид шууд шилжүүлдэг байх, мөн тус хөрөнгийг албан татвараас чөлөөлдөг байх.**
14	Эрчим хүчний тухай хууль 33.1.Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. **Хүн оршин суудаг суурин газарт хуулийн дагуу хамгаалалтын зурвасыг тогтоож, мэдээллийн сангийн актыг үндэслэн хамгаалалтын зурвасыг шууд тогтоох. Эрчим хүчний дэд станц, кабель шугам, ЦДАШ-н хамгаалалтын зурваст газар олгохгүй байх**
15	Эрчим хүчний тухай хуулийн ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ хэсэгт хувийн хэвшил буюу эрчим хүчний барилга угсралт, засвар, зураг төслийн ажил үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдүүдэд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг тодотгох, төрийн өмчит хуулийн этгээдэд хувийн хэвшилд олгодог хувийн хэвшлийг хийдэг ажлын тусгай зөвшөөрлийг олгуулахгүй байх заалтуудыг оруулж өглөө.
16	Эрчим хүчний тухай хуулийн тусгай зөвшөөрөл гэдэг хэсэгт үйлдвэрлэх, дамжуулах, түгээх ажил үйлчилгээг барилга угсралт, зураг төслийн ажлуудтай зарим хэсэгтээ ойлгомжгүй, зарим хэсэгтээ давхардуулсан санагдсан учраас ойлгомжгүй байгаа
17	Ер нь бол Эрчим хүчний тухай хуульд Барилгын тухай хуулийн заалтуудыг copy past хийгээд оруулчих зүйл маш их байгаа. Бараг тэр чигээр нь ..... Эрчим хүч болон барилгын бол нэр нь өөр салбар болохоос биш 2-лаа ижилхэн бүтээн байгуулагч салбар. Эрчим хүчний тухай хуулинд Барилгын тухай хуулийн ТЗ-тэй холбоотой заалтуудыг нэрлэж заагаад, салбарын онцлогийг тусгаад оруулахад болохгүй юм байхгүй. Эрчим хүчний тухай хуулийн ТЗ-н хэсэгт дандаа л Зөвшөөрлийн тухай хуулийн заалтуудыг нэрлэж зааж ашигласан байгаа. Тэгэхээр бас боломж байгаа
18	1. Өнөөдөр амьдралд бас нэгэн хүндрэл учраад байгаа нь асуудал бол Зөвшөөрлийн тухай хуудинд ТЗ олгох суурь нөхцөл шаардлагыг оруулсан явдал болоод байна. Шаардлагатай үед салбарын хэмжээнд өөрчилж болох шаардлагуудыг оруулахад заавал хууль өөрчлөх хүндрэл гарч байна. Тиймээс СНШ-г зөвшөөрлийн тухай хуулийн хавсралтаас хасаж тухайн салбар өөрийн мэдэлдэл авах нь хүндрлэийг бууруулна гэж үзэж байна. Жишээ нь ТЗ авахад заавал Мэргэшсэн, зөвлөх инженер хэрэгтэй гэж СНШ шаарддаг. Гэтэл ЭХ салбарт Мэргэшсэн, зөвлөх инженер бэлдэх журмыг ЭХЯ-с гаргахдаа мэргэшсэн, зөвлөхийн курст бүртгүүлэх, суралцахын тулд заавал МАСТЕРТ сурсан байх шаардлагыг тавьсан. Одоо ч Эрчим хүчний салбар мэргэшсэн зөвлөх инженерүүдийн дутагдалтай байхад ийм хүндрэлтэй журам гарсан нь салбарын бүтээн байгуулагч нар ТЗ авах нөхцлөлгүй болж байна. Учир нь одоо 2 жил мастерт сураад дараа нь 45 хоногийн курст сууж байж Мэргэшсэн зөвлөх болно. Энэ хооронд мэргэшсэн, зөвлөх инженерын хосмдол улас их болохоор байна. Өөрөөр хэлбэл 3-4 жилийн тасалдал бий болно гэсэн үг.
19	Эрчим Хүчний Зохицуулах Хороог Ерөнхий сайдын мэдлээс гаргаж УИХ-ын харъяаллын байгууллага болгох
20	Эрчим хүчний 100% төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох, өмчийн харьцааг 51:49 хувь болгох
21	Төрийн өмчит эрчим хүчний компаниудын гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах журмаар томилж байх
22	Төлөөлөн удирдах зөвлөлийг хаалттай биш, нээлттэй байдлаар сонгон шалгаруулдаг болох

23	Эрчим хүчний компаниудын ашиглалтаас бусад бүх засвар, үйлчилгээг хувийн хэвшилд бүрэн шилжүүлэх
24	Эрчим хүчний томоохон төслүүдэд салбарын олон нийт хяналт тавьдаг бүтэц бий болгох
25	Эрчим хүчний ажиллагсдын жилийн үр дүнгийн шагнал болох 13 дахь сарын цалинг хуулиар баталгаажуулах
26	Эрчим хүчний сайдаар тус салбарт 10-аас доошгүй жил ажилласан хүнийг томилох
27	ЭХ-ний тухай хуулийн 30-р зүйл Хэрэглэгчийн эрх үүрэг хэсэгт ЭХ-ний төлбөрийг хугацаанд нь төлөх, ЭХ-ний ажилтан ажлаа гүйцэтгэхэд саад учруулахгүй байх, дур мэдэн өөр хэрэглэгч холбохыг хориглох зэрэг үүргийг тодорхой зааж оруулах
28	Хэрэглэгчид тоолуураас цааших гэр доторх цахилгааны монтаж, разетка билк зэргийн ашиглалт бүрэн бүтэн байдлаа хариуцахыг хуулинд зааж өгөх,
29	Нийтийн эзэмшлийн ЦЭХ-ний төлбөр тооцоо, ашиглалт хариуцагчийг тодорхой зааж, хариуцлагыг нэмэгдүүлж заах /СӨХ-үүд цахилгааны төлбөрөө барагдуулалгүй хязгаарлалт хийсэн ч нийтийн эрх ашгийг зөрчлөө гэж оршин суугчид нь гомдол гаргасаар өр барагдуулахгүй улам ихэсгэх хандлага үүсч байна/
30	Хэрэглэгч хангагчийн эзэмшлийн заагийг тодорхой зааж өгөх, үйлчлэх хүрээ тодорхой бус байгаа нь хүндрэлтэй байна. Орон сууцны хэрэглэгчийн дуудлагыг конторууд авахаа больсон нь хангагчийн ажлын ачааллыг нэмсэн, цалингийн эх үүсвэр байхгүй тул орон тоо шийдэгдээгүй, дуудлага барагдуулж амжихгүй хэрэглэгчийг гомдоох зэрэг хүндрэлтэй байна. Хуульд тодорхой зааж холбогдох зардлын эх үүсвэрийг ЭХЗХ шийдвэрлэж өгөх шаардлагатай. Эсвэл дан айл өрхийн цахилгааны дуудлагыг хариуцах, үйлчилгээнээс санхүүжих байгууллагыг тусд нь байгуулах зэргээр шийдвэрлэх
31	Орон сууцны нийтийн эзэмшлийн хэсгийн эзэмшигч нь /СӨХ/ нийтийн эзэмшлийн дэд бүтцийн цахилгаан хангамжийн тоног төхөөрөмжийн эзэмшигч бөгөөд үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэн бүрэн бүтэн байдлыг хариуцахыг хуульд зааж өгөх,
32	Зүй бусаар ЦЭХ хэрэглэсэн хэрэглэгчид авах арга хэмжээг хуульд тодорхой зааж өгөх
33	ЦЭХ-ний төлбөр барагдуулалгүй алга болсон болон төлөхгүй байгаа хэрэглэгч хуулийн этгээдийг ЭХС-ийн нийт түгээх сүлжээнд ЦЭХ-р хангахгүй байх, техникийн нөхцөл олгохгүй байхыг хуульд зааж өгөх, ЦЭХ хангах гэрээ, техникийн нөхцлийн шалгуурт лавлагаа авч хавсаргадаг болгох
34	ЦЭХ-ний төлбөр барагдуулалгүй алга болсон болон төлөхгүй байгаа хэрэглэгч, хуулийн этгээдийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулж, санхүүгийн хязгаарлалт тавих зэргээр өр барагдуулуулах талаар хуульд заалт оруулах /Шүүхэд хандаад ч олдохгүй хэрэглэгчид байдаг ба тэр бүрт шүүхэд хандах нь шүүхийн болон хангагчийн ажлын ачаалал нэмэгдүүлдэг ба ингэж санхүүгийн хязгаарлалт тавьснаар ЭХ-ний салбарын авлага барагдуулахад илүү хялбар болж хүндрэл багасах юм/, мөн өртэй хэрэглэгчид хилийн хориг тавих зэрэг бусад оронд байдаг пратикаас хэрэгжүүлэх гэх мэт
35	ОСХотхонууд 16-с дээш давхар бол аваарийн дизель генератортай байх шаардлагын дагуу генератортай байгаа ч хариуцагч тодорхойгүй, СӨХ яваандаа чадамжгүй болж хаягдаж байгааг анхаарч хуульд тусгаж өгөх, хангагч хариуцах бол засвар үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх
36	Ёс зүйн харилцааг хуулиар зохицуулдаггүй. Хэрэглэгч үүргээ биелүүлэхгүй атлаа хангагчийн ажилтаныг элдвээр доромжлох дарамтлах асуудал ихээр гардаг,
37	Зайлшгүй шаардлагатай. Өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгчтэй харилцдаг бэрхшлүүдээс үүдэн дээрх өөрчлөлт, нэмэлтийн санлыг гаргаж байна.
38	ЭХ-ний хуулинд үйлдвэрлэгчийн тарифыг тогтоож өгөх бус чөлөөт өрсөлдөөнд оруулж хямд нийлүүлэх арга замыг нээх шаардлагатай. СЭХ-ний салбараас өндөр өртөгтэй ЦЭХ-ний нийлүүлэлтээс ЭХ-ний салбарын орлого зарлагын бланс алдагдаж их хэмжээний алдагдалд орох үндсэн шалтгаан болж байна.
39	Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, мөн үүргийг тодорхой зааж өгөх,
40	Салбарын үйл ажиллагааг сурталчилан таниулж эерэг хандлагыг нэмэгдүүлэх

41	ЭХ-ний хэмнэлт гаргаж буй хэрэглэгчийг урамшуулдаг тогтолцоо бий болгох, зүй зохистой хэрэглээтэй хариуцлагатай хэрэглэгчийг урамшуулдаг байх
42	ЭХ-ний салбарын ажилтаны цалин хөлсийг төр хувийн хэвшил ялгалгүй үр дүнгийн нэмэгдэл зэргийг олгох зэргээр зах зээлийн бодит үнэлгээнд хүргэх, нийгмийн баталгааг сайжруулах /ОС-ны асуудал шийдвэрлэх боломж олгох зэрэг/ бодлого баримтлах
43	Сэргээгдэх ЭХ-ний хуулинд үйлдвэрлэгчийн тарифыг тогтоож өгөх бус чөлөөт өрсөлдөөнд оруулж хямд нийлүүлэх арга замыг нээх шаардлагатай. СЭХ-ний салбараас өндөр өртөгтэй ЦЭХ-ний нийлүүлэлтээс ЭХ-ний салбарын орлого зарлагын бланс алдагдаж их хэмжээний алдагдалд орох үндсэн шалтгаан болж байна.
44	1. Шинээр баригдаж байгаа цахилгаан үүсгүүрүүд нь хүчин чадалдаа тохирсон цахилгаан хуримтлууртай байх.
45	2. Станцад үүсч болох эрсдэлийн үнэлгээ хийлгэж олон улсын найдвартай даатгалд хамруулсан байх.
46	3. Бусад бараа, үйлчилгээтэй цахилгааны үнэ өртөг нь уялдаа холбоотой байх зэрэг асуудлыг санал болгож байна.
47	Нүүдлийн соёлд нийцсэн төвлөрсөн бус эрчим хүчний систем Жишээлбэл Калифорнийн эрчим хүчний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж Монголд тохирсон загварыг гаргасnаар нүүдэлчин айл өрхүүд болон алслагдсан суурин газруудад сүлжээнээс гадуур эрчим хүч үйлдвэрлэх боломжийг олгож, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийн хүртээмжийг дамжуулах дэд бүтэц шаардахгүйгээр нэмэгдүүлэх боломжтой. Нар, салхи, СН (метан) болон усны системийг нүүдэлчин айлуудын хэрэгцээг хангахад ашиглах боломжтой.
48	Хэрэглэгчдэд чиглэсэн эрчим хүчний уян хатан үнэ Нүүдэлчид болон орон нутгийн үйлдвэрлэгчдэд үйлдвэрлэсэн эрчим хүчээ ойр орчмын хэрэглэгчдэд худалдах, түгээх эсэхээс үл хамааран өрсөлдөхүйц үнийг тогтоох боломжийг санал болгож болно. Энэхүү систем нь нүүдэлчдийг эдийн засгийн хувьд хүчирхэгжүүлж, орон нутгийн ядуурлыг бууруулах, Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой.
49	Орон нутгийн эрчим хүчний төслүүдийн урамшуулал, санхүүжилт Орон нутгийн эрчим хүчний төслүүдэд тодорхой урамшуулал санал болгох боломжтой. Татвараас чөлөөлөх, бага хүүтэй санхүүжилт олгох зэрэг нь эрчим хүч үйлдвэрлэх санаачилгуудыг дэмжинэ. Үе шаттай сургалт болон тоног төхөөрөмжийн дэмжлэгүүд нь айл өрхүүдэд сүлжээнээс гадуурх эрчим хүчний системийг бий болгоход дэмжлэг болно. Урамшууллын жишээ нь хөрөнгө оруулалтыг нөхөх хүртэл татвараас чөлөөлөх бодлого байж болно. Хэрэгжүүлсэн ижил төстэй туршлага манай гишүүн байгууллагуудад бий.
50	Аюулгүй байдал: Төвлөрсөн бус систем нь эрчим хүч үйлдвэрлэх цэгүүдийг орон даяар түгээх замаар үндэсний аюулгүй байдлыг бататгаж, төвлөрсөн сүлжээний тасалдалд өртөхгүй байх боломж олгодог.
51	уян хатан байдал: Байгалийн гамшиг эсвэл геополитикийн зөрчилдөөн гарах тохиолдолд төвлөрсөн бус сүлжээ нь Монгол Улсад стратегийн бүс нутгуудад эрчим хүчний хүртээмжтэй байх боломжийг олгож, тэг зогсолтыг даван туулах чадварыг нэмэгдүүлнэ.
52	Байгаль орчин, соёлын тогтвортой байдал: Орон нутгийн эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжсэнээр засгийн газар дэлхийн тогтвортой байдлын стандартад нийцүүлэн, түлшний хамаарлыг бууруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжтой. Төвлөрсөн бус, сэргээгдэх эрчим хүчний систем нь Монгол Улсын өвөрмөц онцлогийг дэмжих болно.
53	Эрчим хүчний салбарын оролцогч талуудын хоорондох Засаглалтай холбоотой харилцааны хэм хэмжээ нь хуулиар болон журмаар зохицуулагддаггүй. Хууль тогтоол, дүрэм журам байдаг ч эдгээрийг харилцагч талуудыг алагчлалгүй, хувийн ашиг сонирхолгүй, бусдад давуу тал олголгүйгээр, цаг хугацаанд нь шийдвэрлэх хүсэл зориг, тогтолцоог хэвшүүлэх дутагдаж байна. Мөн төр хувийн хэвшлийг оролцуулсан хамтарсан хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулдаг бүтэц дутагдаж байна.
54	Төрийн байгууллагуудтай харьцахад хүнд суртал, эс үйлдэл, шудрага бус явдал хувийн хэвшилд тулгардаг.
55	Нэг худалдан авагчийн загвараас зах зээлийн загвар луу шилжихийн тулд ЭХЗХ ны бие даасан байдал, үнэ тариф чөлөөлөх болон индексац, хувь эзэмшил, олон нийтийн оролцоо, засаглал гээд олон бодит шаардлага байна. Мөн хөрөнгө оруулалтын гэрээг хөрөнгө оруулагчид чирэгдэл багатай, тодорхой хугацаанд багтан байгуулах орчин нөхцөл энэ салбарт гадны хөрөнгө оруулалт татахад суурь нөхцлийн нэг болно.

56	1.Эрчим хүчний салбарт ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшууллын сүлжил, жишиг тогтоож мөрдүүлэх,
57	"Зохицуулах хороо нь төсвөөс санхүүжих бөгөөд албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг Засгийн газар батална" гэж оруулах;
58	**Ухаалаг сүлжээний хөгжлийг дэмжих:** Эрчим хүчний ухаалаг сүлжээг нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтыг бий болгож, харилцан уялдаатай технологи, стандартуудыг тогтоох.
59	**Дижиталчлал, автоматжуулалтыг дэмжих:** Эрчим хүчний системийн үйл ажиллагааг автоматжуулах, мэдээлэл цуглуулах, хянах үйл явцад шаардлагатай технологи, программ хангамжийн стандартыг батлах.
60	**Смарт төхөөрөмж, ухаалаг сүлжээний суурилуулалт:** Эрчим хүчний хэмнэлт, хэрэглээг оновчтой удирдахад шаардлагатай смарт төхөөрөмж, ухаалаг тоолуур зэргийг бүх хэрэглэгчдэд нэвтрүүлэх шаардлагыг хуульчлах. Мөн хуульд Орон сууц, гэр хорооллын хэрэглэгчдийн тоолуурын тавилыг тодорхой заасан байх.
61	**Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх:** Дэд бүтэц, шинэ технологи нэвтрүүлэхэд шаардлагатай урт хугацааны хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн хууль, журам бий болгох.
62	**Хувийн хэвшлийг дэмжих:** Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд тусгай зохицуулалт хийх, хөнгөлөлт үзүүлэх.
63	**Эрчим хүчний төлбөр тооцооны ил тод байдал:** Хэрэглэгчдэд эрчим хүчний хэрэглээ, үнийн мэдээллийг ойлгомжтой хэлбэрээр хүргэх, ил тод байдлыг хангах.
64	**Эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах:** Хэрэглэгчдийг тасралтгүй, найдвартай эрчим хүчээр хангах зорилгоор тасалдлын нөхөн олговор олгох, сүлжээний аюулгүй байдлыг хангах дүрмийг оруулах.
65	**Мэргэжлийн сургалтын дэмжлэг:** Эрчим хүчний салбарын ажилчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалт, олон улсын туршлага судлах хөтөлбөрүүдийг дэмжих.
66	**Судалгаа, инновацыг дэмжих:** Эрчим хүчний шинэ технологи, инновацыг дэмжих зорилгоор судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
67	**Цахилгаан хангамжийн эрсдэлээс хамгаалах:** Эрчим хүчний сүлжээнд тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үед хэрэглэгчдийг хамгаалах төлөвлөгөөтэй байх шаардлагыг хуульчлах.
68	**Сэргээн босгох сан:** Ослын болон гамшгийн үед эрчим хүчний сүлжээг хурдан сэргээх зориулалт бүхий сан байгуулах.
69	**Сэргээгдэх эрчим хүчний үндэсний зорилтууд:** Сэргээгдэх эрчим хүчний бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор уян хатан зохицуулалт, дэмжлэгийн сан бий болгох.
70	**Ногоон бонд гаргах боломж:** Сэргээгдэх эрчим хүчний төслийг санхүүжүүлэх ногоон бонд гаргах, олон улсын хөрөнгө оруулалтыг татах хууль эрх зүйн зохицуулалтыг хуульд тусгах.
71	**Эрчим хүчний экспорт, импортын зохицуулалт:** Монгол Улсын эрчим хүчний нөөцийг гадаад зах зээлд нийлүүлэх, бусад орнуудтай хамтран ажиллах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах талаар илүү тодорхой заалт оруулах. Ингэснээр бүс нутгийн эрчим хүчний сүлжээнд нэгдэх боломж нэмэгдэнэ.
72	Монгол Улсын Эрчим хүчний тухай хуульд "Гаднын эзэмшлийн шугам тоноглолын тоог нэмэгдүүлэхгүй, нийтийн сүлжээг өргөтгөх бодлого барих" талаар оруулах санал нь тус салбарт орон нутгийн цахилгаан эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг хангах, үндэсний сүлжээг бэхжүүлэх, стратегийн хувьд зөв шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Энэ саналаар хуульд дараах зүйлсийг тусгах боломжтой:
73	**Шугам, тоноглолын эзэмшил, хариуцлагын зохицуулалт:** Гаднын эзэмшлийн цахилгаан шугам, тоноглолын тоог нэмэгдүүлэхгүй байхаар хуульд тусгах. Энэ нь үндэсний эрчим хүчний сүлжээг хамгаалах, стратегийн ач холбогдол бүхий цахилгаан шугам, тоноглолыг гаднын эзэмшилд оруулахгүй байх зорилгоор хуульд тодорхой зохицуулалт оруулах шаардлагатай.
74	**Эрчим хүчний эрсдэлийг бууруулах:** Гаднын хөрөнгө оруулалтыг хязгаарлах нь эрчим хүчний салбарт орон нутгийн хязгаарлагдмал нөөц, тоноглолын эрсдэлийг бууруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор зайлшгүй шаардлагатай.
75	**Нийтийн цахилгаан сүлжээг өргөтгөх үндэсний стратеги:** Эрчим хүчний сүлжээг өргөтгөх үйл ажиллагааг зөвхөн төрийн болон үндэсний хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бодлого барих. Хуульд эрчим хүчний сүлжээг өргөтгөх, шинээр холбох асуудлыг үндэсний байгууллагууд болон төрийн оролцоотой зөвхөн дотоодын хүчин чармайлттайгаар хэрэгжүүлэх талаар тусгах.

76	**Сүлжээний өргөтгөлийн стратегийн чиглэл:** Эрчим хүчний сүлжээг өргөтгөхдөө зөвхөн орон нутгийн болон үндэсний хөрөнгө оруулалт, дотоодын компаниудын оролцоог дэмжих бодлогыг хуульд тодорхой заах. Үүнд гаднын компаниудын оролцоог зөвшөөрөхгүй байх бодлого хэрэгжүүлэх.
77	**Эрчим хүчний салбарын үр ашиг, найдвартай байдлыг сайжруулах** Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хэрэглээний шатанд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хооронд уялдаатай ажиллах нь системийн найдвартай байдал, чанарыг нэмэгдүүлнэ. Жишээлбэл, эрчим хүч үйлдвэрлэгчид болон түгээгч компаниуд мэдээлэл солилцож, хамтран ажилласнаар хэрэглэгчдэд тасралтгүй эрчим хүч хүргэх нөхцөл бүрдэнэ.
78	**Аюулгүй ажиллагаа, гамшгаас урьдчилан сэргийлэх:** Гамшгийн үед эрчим хүчний салбарын байгууллагууд болон холбогдох бусад байгууллагуудын (ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР гэх мэт) уялдаа холбоог сайжруулах нь гамшгийн үед түргэн хариу арга хэмжээ авах, эрчим хүчний хангамжийг түргэн сэргээх боломжийг нэмэгдүүлнэ.
79	**Төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа:** Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих, хөрөнгө оруулалтыг татахад төр, хувийн хэвшлийн түншлэл чухал үүрэгтэй. Хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, хамтран ажиллах зарчмыг хуульд тусгаснаар илүү үр дүнтэй хамтын ажиллагаа үүснэ.
80	Төрийн өмчит болон хувийн өмчийн цахилгаан түгээх, хангах компаниудад ижил нөхцөлд ажиллах боломжийг бүрдүүлэх. Тухайлбал: 1. Цахилгаан дамжуулах сүлжээнээс шинэ гаргалга авхад төрийн өмчит компани болон хувийн компаниудад тавигддаг шаардлага, бүрдүүлдэг бичиг баримт эрс ялгаатай байдаг. 2. Хөрөнгө оруулалт, зээлийн дооод, гадаадын сангуудтай хамтран ажиллахад холбогдох төрийн байгууллагаас төрийн өмчит компаниудад дэмжлэг ирдэг бол хувийн компаниудад байддаггүй нөхцөлтэй байна. Аливаа сангаас тавигддаг нөхцөл, шалгуурыг тухайн хувийн өмчит компани хангаж байвал холбогдох төрийн байгууллага нь түүнийг дэмжих үүрэг хүлээдэг тухайн сантай тус компанийг дэмжиж харилцдаг, ажилладаг болох.
81	Үнэ, тариф индексжүүлэх асуудлыг Эрчих хүчний зохицуулах хороо болон цахилгаан түгээх, хангах компаниуд аль аль нь бие даан шийддэг болох. Зах зээлд өрсөлдөөний зарчим үйлчилдэг буюу үнээрээ өрсөлдөх боломжтой болох
82	Цахилгаан түгээх, хангах компаниуд цахилгаан эрчим хүчээр хангах гэрээгээний нөхцөлөө өөрсдөө бие даан гаргаж хэрэглэгчтэйгээ харилцан тохиролож хууль эрх зүйн хариуцлагаа өөрсдөө хүлээх зарчимыг суулгах. Тухайлбал, одоогоор хэрэглэгчддээ үнэ, тарифын урамшуулал олгох эрх компаниудад байхгүй байна.
83	Цахилгаан, дулааны эрчим хүчний үнийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх. Тус арга хэмжээг ядаж эрчим хүчний салбар цаг алдалгүй болох хүртэл хэрэгжүүлэх
84	эрчим хүчний салбарын ялангуяа үйлдвэрлэл, түгээх сүлжээ, тэдгээрийг дагалдах дэд бүтэц, үйлчилгээнд өрсөлдөөний орчин бүрдүүлэх зорилгоор өмч хувьчлал, концесс, өмчийн олон хэвшил, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого, зохицуулалтыг цогцоор нь бий болгох шаардлага зүй ёсоор тулгамдсан асуудал байдаг.
85	Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар "Хуулийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, тарифын зохицуулалт хийгддэг, зохицуулах байгууллагатай салбарт энэ хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалт хамаарахгүй" гэсэн зохицуулалтыг тусгах замаар тус агентлагийн чиг үүргийг хязгаарласан нь нийгэм, эдийн засгийн суурь үнийг бүрдүүлэгч цахилгаан, дулаан, хэрэглээний цэвэр, бохир усан хангамж, харилцаа, холбоо зэрэг салбаруудад монополын хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Өөрөөр хэлбэл, зүй ёсны монополын жагсаалтад бүртгэлтэй 133 аж ахуй эрхлэгчдээс төмөр зам, тээврийн салбарын 12 аж ахуй эрхлэгч буюу 9 хувьд нь хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд цаашид монополын хяналтыг бодитойгоор хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд тухайн 2015 оны хуулийн нэмэлт өөрчлөлтийг цуцлах, хууль хоорондын хийдэлтэй байдлыг залруулах саналтай байна
86	Эрчим хүч (Power) гэдэг нь энергийн асуудал эрхэлдэг том салбарын нэгээхэн хэсэг тул шинэ хуулийг Энергийн тухай гэж нэрлэвэл зохистой
87	Энергийн тухай хууль нь энергийн нөөц, эрчим хүч, энергийн талаархи төрийн зохицуулалт, хувийн хэвшлийн оролцоо, хариуцлагын тогтолцоо гэсэн 5 үндсэн хэсгээс бүрдэнэ

88	Энергийн нөөцөд уран, нүүрс, занар, төрөл бүрийн шингэн түлш, байгалийн хий, олборлосон нүүрсний давхаргын метан, үйлдвэрлэсэн устөрөгч, сэргээгдэх эрчмийн нөөцийг хамруулна. Эрчим хүч гэдэгт төрөл бүрийн цахилгаан, дулааны станц, олон улсын, улсын, бүсийн дамжуулах сүлжээ, түгээх сүлжээнүүд болон эрчим хүчний хураагуурын үйл ажиллагаа эрхлэх салбарыг нийтэд нь хамруулна. Төрийн зохицуулалт нь хоёр хуваагдана. Нэгд, энергийн бодлого, хоёр, эрчим хүчний зохицуулалт. Эхний хэсгийг төрийн захиргааны төв байгууллага буюу энергийн яам, хоёрдахийг эрчим хүчний зохицуулах байгууллага хариуцна. Хувийн хэвшлийн оролцоо гэсэн хэсэгт дамжуулах сүлжээ, диспетчерийн удирдлага төрийн монополи байхыг хуульчилна. Бусад хэсэгт үйл ажиллагаа эрхлэх компаниуд зөвхөн олон нийтийнх байна гэдгийг хуульчлах. Хариуцлагын тогтолцоо гэдэг нь энэхүү хуулийг ягштал мөрдөх, зөрчвөөс хүлээх хариуцлагыг чангатгахыг хэлнэ
89	Эрчим хүчний томоохон төслүүдэд салбарын олон нийт хяналт тавьдаг бүтэц бий болгох
90	Эрчим хүчний удирдлагад төр, хувийн хэвшил, олон нийтийн оролцоог тэнцүү оролцуулах
91	Аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн зарим эрх үүргийг хуулиар тодорхой болгох
92	Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйл. 33.1.Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Энэ заалтыг нарийвчлах, хэрэв буусан тохиолдолд нүүлгэх, буулгах асуудлыг Газрын тухай хуулиар тухайн шатны Засаг даргын захирамжаар шийдвэрлэдэг ба уг асуудал нь тэр бүр хэрэгждэггүй.
93	Орон нутгийн хэмжээнд дийлэнх маргаан гомдлыг эхний ээлжид эрчим хүчний улсын байцаагчид шалгаж шийдвэрлэх ба уг заалтад улсын байцаагч гэж нэмэх
94	Эрчим хүчний системийн төлөвлөлтийг хариуцсан байгуулагыг тодорхой болгох. ДҮТ энэ үүргийг хүлээх ёстой
95	Энергийн нөөцийн асуудалд шинээр маш олон чиглэл нэмэгдэж байгаа тул одоогийн эрчим хүчний яамны бүтэц, зохион байгуулалт шаардлага хангахгүй нь тодорхой
96	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол улсын хэмжээнд мөрдөх норматив бичиг баримт, хөдөлмөрийн хөлсний хэмжээ/цагийн тариф/,төсөв зохиох аргачлал, стандартыг боловсруулах, батлах, мөрдүүлэхээр оруулах
97	Аймгийн засаг даргын дэргэдэх эрчим хүчний зөвлөлийн эрх, үүргийг тодорхой болгох
98	Гадаад дотоод сургалт хөрөнгө гаргах, мэргэжлийн холбоодод ажиллах хүн хүч, төсөв мөнгө тодорхой хувиар өгдөг болох
99	Салбарын шаардлагатай мэргэжилтний жагсаалт гаргаж ангилан тухайн мэргэжлээр сурч буй оюутнуудад хүүгий зээл, сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг болгох
100	ЭХ-ний байгууллагууд мэргэжилтнүүдийг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх тухай асуудлыг нэгдсэн бодлогын баримт бичгээр тогтворжуулан зохицуулах
101	ЭХ-ний салбарын ажилчдын цалингийн шатлалд өөрчлөлт оруулан орон нутагт мэргэжилтнүүд ажиллах бололцоог бүрдүүлэх
102	Технологийн томоохон хэрэглээтэй үйлдвэр аж ахуй нэгжид эрчим хүч нөөцлөх хадгалах хуримтлуулан оргил ачаалал хөнгөлөх талаар заалт оруулах
103	Эрчим хүчний тухай хуульд Эрчим хүчний хуримтлуурын байгууламжтай холбоотой шинээр нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах
104	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлүүд нь хүчин чадлын тодорхой хувьтай тэнцэх нөөц хуримтлууртай байх
105	Төсөв зохиох аргачлалд хувийн хэвшлээс санал авдаг болох тоимлолтын зардал, урсгал зардал тусгах
106	Тарифын зохицуулалттай хэсгүүдийн бодит зардал олон улсын хөрөнгийн удирдлагын ISO 55000 стандартын дагуу хянагдах
107	Монгол улсын нутгаар дамжин өнгөрөх болон хил дамнасан эрчим хүчний болон эрчим үйлдвэрлэх түүхий эд дамжуулах түгээх сүлжээний зохицуулалт хэрэгтэй

108	Салбарын зөвхөн монополь хэсгүүдийн зардалд тарифын зохицуулалт байна, бусад хэсгүүдийн тариф зах зээлийн зарчмаар явна
109	Эрчим хүчний төрийн өмчид компаниудын өмчийн хэлбэр бол компаний тухай болон бусад хуульд тусгагдах ёстой
110	Эрчим хүчний 100% төрийн өмчит компаниудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгох
111	Төлөөлөн удирдах зөвлөлийг хаалттай биш, нээлттэй байдлаар сонгон шалгаруулдаг болох
112	Төрийн өмчит эрчим хүчний компаниудын гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах журмаар томилж байх
113	ТУЗ-ийн гишүүд олон нийтийн сонгон шалгаруулалтаар томилогдож байх
114	Эрчим хүчний удирдах албан тушаалд (Сайд,Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад) Нам харгалзахгүй Эрчим хүчний салбарт багадаа 5 аас доошгүй жил ажилласан урд нь ЭХ-нд удирдах албан тушаалд ажиллаж байсан хүн тавих
115	Төрийн захиргааны байгууллагууд (яам) компаниудын хувь эзэмшихийг хориглох
116	Хувьчлах, нийтийн өмч болгох асуудлыг олон улсын зөвлөхөөр судлагаа гаргуулж оновчтой байдлаар өмчийн хэлбэрийг өөрчлөх
117	Жилийн үр дүнгийн шагнал болох 13 дахь сарын цалинг хуулиар баталгаажуулах
118	Эрчим хүчний салбарын ажилтнуудад орон нутгийн нэмэгдэл олгох
119	ЭХ-ний салбарын ажилчдын цалингийн шатлалд өөрчлөлт оруулан орон нутагт мэрэгжилтнүүд ажиллах бололцоог бүрдүүлэх
120	Эрчим хүчний тухай хуульд салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг нэг тусдаа бүлэг болгож нэмж оруулах
121	Нормчлолын сангийн хяналтыг шилэн болгох
122	Салбарын дотоод мэдээллийг нийтэд хүртээмжтэй болгох
123	Хуулийн 14.4 -т Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна гэж заасан байгаа. Гэтэл 110 кВ-ын шугам, дэд станцаа өөрийн хөрөнгөөр барьсан компаниудын мэдэлд байсаар байгаа хөрөнгийг хэзээ яаж төрийн өмчид авах вэ. Авч чадахгүй бол энэ заалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай
124	3.1.29 "Хэрэглэгчийн ангилал" гэж цахилгаан, дулаан үйлдвэрлэсэн эрчим хүчний нөөцийн төрлөөс хамаарч эрчим хүчний хэрэглээни шинж чанар, эрчим хүчээр хангах зардал зэргийг үндэслэн хэрэглэгчийн тарифыг тогтоох зорилгоор хэрэглэгчийг ангилахыг
125	17.4.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх хэрэглэгчдийн цахилгаан, дулааны хэрэглэгчийн ангилал, тэдгээрийн тариф, тарифын шатлалыг тогтоох зорилгоор жил бүр судалгаа хийж, ЭХЗХ-оор батлуулах тарифын саналдаа тусгана.
126	17.5.Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх СЭХ-ний хэрэглэгчдийн захиалга болон хэрэглээний балансыг жил бүр гаргаж, ЭХЗХ-д тайлагнана. Баталгаажсаны дараа тухайн жилийн СЭХ-ний хэрэглээний мэдээллийг СЭХ хэрэглэгчийн ангилал бүрт баталгаажуулж сертификат олгоно.
127	Тоолуурын өмчлөлийн асуудал, хувийн дэд станц шугам сүлжээг өмчлөх асуудлыг нэг мөр шийдэх хэрэгтэй. Хувийн компани, хувь хүн өөртөө шугам сүлжээ дэд станц бариад хөрөнгө гаргаж байхад нэмээд, алдагдал гээд мөнгө аваад байдаг! Зарим нь дэргэдэх шугамнаас аваад хөрөнгө ч гаргахгүй, алдагдал төлөхгүй яваад байдаг
128	Тоолуурыг улсын, хяналтын гэж 2 янз байх хэрэгтэй. Мөнгө тооцож авч байгаа бүгд нь улсын (одоогийнхоор), хяналтын тоолуур нь хэрэглэгчийн (хэрэглэгч хүсвэл өөрийн үзэмжээр тавих) хэрэгтэй л юм шиг. Одоо бол утгаа алдсан

129	Тусгай зөвшөөрөлд нэр орж байгаа мэрэгжилтэн бүрээс зөвшөөрлийн магадлагаа авдаг болох ?
130	Ашиглалтаас бусад бүх засвар, үйлчилгээг хувийн хэвшилд бүрэн шилжүүлэх
131	Олон улсын жишгийн дагуу Захиалагчийн хяналтыг зөвлөх үйлчилгээгээр буюу хувийн хэвшлээр хийлгэдэг болгох
132	Зургын экспертиз хяналтыг зөвлөх үйлчилгээгээр буюу хувийн хэвшлээр хийлгэдэг болгох
133	Их засварын дараа баталгаат хугацаа 6 сараас ихгүй байх
134	Бүтээн байгуулалтын бүх ажлыг зөвхөн хувийн хэвшил хийх. ТӨХК-ууд хувийн хэвшлийн ажлыг тендерт өрсөлдөн авч хийдэг асуудлыг таслан зогсоох эрх зүйн орчинг бий болгох
135	Тусгай зөвшөөрөл олгох асуудлыг салбарын ТББ-дад буцаан олгох, ТӨҮГ-дад зураг төсөл, БУА-н ТЗ олгохыг хориглох эрх зүйн орчинг бий болгох
136	Нормчлолын санг салбарын ТББ-дад хариуцуулах
137	Батлагдсан засварын төсвийг шилжүүлэн ашиглах өөр зорилгоор хэрэглэхийг хориглох
138	Мэргэшсэн, зөвлөхийн сургалт, зэрэг дэв олгодог асуудлыг салбарын мэргэжлийн ТББ-дад шилжүүлэх
139	Тендерийн хуульд өөрчлөлт оруулах эрчим хүчний салбарт ажилласан жил , ур чадвар, туршлага гол үзүүлэлт байх , урьдчилгаа төлбөр өгдөг байх гэх мэт
140	Аймгуудын эрчим хүчний зөвлөлийг чиглэлийн тендерт оруулах
141	ЭХ-ний үнэ нэмэх, эсвэл чөлөөлөх талаар Нүүрс, эмийн сонсгол хийсэн шиг сонсгол хийх
142	Хуучин ЭХ-ний зуухны горимын групп гэж байсаныг сэргээн байгуулах. Зуух, турбин тус бүрээр
143	Реактив чадал тооцдог тоолуурыг хэрэглээнд нэвтрүүлэх

Хавсралт-2

Эрчим хүчний тухай хуульд орсон нэмэлт,
өөрчлөлтийн агуулгын талаарх судалгаа

№	Нэмэлт өөрчлөлтийн огноо	Нэмэлт өөрчлөлт орсон зүйл, хэсэг, заалт	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	2001.11.30	6.1.5, 6.1.7, 9.1.1	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн өөрчлөлт орсон. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс “Тусгай зөвшөөрөл олгох журам”, “ хот, тосгон, бусад суурины нийтийн хэрэгцээнд эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар түлш импортлох, эскспортлох зөвшөөрөл олгох” гэсэн үүргүүдийг хассан.
2	2002.07.04	28.2, 30.1, 28.1, 30.1.8, 29.1	Иргэний хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт орсон. Иргэнтэй байгуулах эрчим хүчээр хангах гэрээнд эрчим хүч дамжуулах шугам сүлжээний эзэмшлийн заагийг тусгах, Хэрэглэгчийн эрх үүрэгт “эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй" гэсэн агуулгыг нэмсэн.
3	2007.1.11	2.2, 11.3.3	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй холбоотой харилцааг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар зохицуулах тухай заалтыг нэмсэн. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн эрх үүрэгт 11.3.3.Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх тухай заалт нэмсэн.
4	2008.12.19	6^1.1	Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд 5 чиглэлийн нэмэлт хийсэн. Үүнд: эрчим хүчний талаарх төрийн бодлого боловсруулахад шаардагдах тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх; төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах; шинэ эх үүсвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах; уламжлалт бус эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах, эрчим хүчний алдагдлыг бууруулах,


			эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах .
5	2009.07.16	2.3, 3.1.21, 3.1.22, 3.1.23	Цөмийн энергийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон. Цөмийн эрчим хүч ашиглахтай холбогдсон харилцааг Цөмийн энергийн тухай хуулиар нарийвчлан зохицуулах тухай нэмэлт заалт, өөрчлөлтийг оруулсан.
6	2011.12.09	Хэсэг, заалт нэмсэн 2.4, 5.1.4, 5.1.5, 6.1.8- 6.1.11, 7.3, 9.1.14-9.1.19, 10.2, 12.6, 17.3, 27.7 6^1.1.3, 9.1.12 өөрчлөн найруулсан 3.1.1-3.1.29, 6.2, 8.1-8.9, 9.1.4, 9.1.13, "10.1, 11.2, 11.3.3, 15.2.6, 16.3.7, 17.2.4, 19.3, 25.1.5, 26.2.8, 26.4, 27.1 Өөрчилсөн 5.1.2, 9.1, 9.2, 12.2, 12.3, 21.1, 21.3, 9.1.14, 13.2, 15.2.3, 18.1, 24.2, 26.2.2, "9.1.20 хүчингүй болгосон 6.1.3, 6.1.7, 10.1.1, 10.1.2, 10.1.3	Засгийн газар, Төрийн захиргааны төв байгууллага /ТЗТБ/, бүх шатны засаг дарга, Эрчим хүчний зохицуулах хороо /ЭХЗХ/, Диспетчерийн үндэсний төв/ДҮТ/, Эрчим хүчээр зохицуулалтай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч /ЭХЗХТЗЭ/, Тариф, гэрээний үнэ хэсэг, бүлгүүдэд нэмэлт эрх үүрэг нэмсэн. Үүнээс онцлох заалтуудыг дурдвал: **Засгийн газарт**-Эрчим хүчний аюулгүйн нөөц болон хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нөөцийн жагсаалтыг батлах; **ТЗТБ-д** 6.1.10.эрчим хүчний салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах; 6.1.11.халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох; **ЭХЗХ-нд** "9.1.14.эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлалыг батлах, тооцоог хянах; 9.1.15.энэ хуулийн 25.1.9-д заасан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх, 9.1.16.эрчим хүчний үнэ, тарифыг индексжүүлэх журам батлах; 9.1.17.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчид эрчим хүчний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах; **ДҮТ ТӨХХК-д** 10.2.Нэгдсэн сүлжээний арилжааны үйл ажиллагааг удирдан явуулна. **ЭХЗХТЗЭ**-д тусгай зөвшөөрөлд заасан нутаг дэвсгэр дээрх зарим хэрэглэгчдийн цахилгаан, дулааны борлуулалтыг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэх мэт заалт нэмсэн. 3-р бүлэгт байгаа нэр томъёоны тодорхойлолтыг өөрчлөн найруулж, дэс дараалал, утга агуулгыг илүү ойлгомжтой болгосон. Зохицуулах хорооны чиг үүргийг өөрчлөн найруулсан. Эрчим хүчний зохицуулах хороог орон тооны 3, орон тооны бус 2, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирдана гэдэг өөрчлөлт хийсэн. “Эрчим хүчний

			зохицуулах газар”-ийн нэрийг Эрчим хүчний зохицуулах хороо болгосонтой холбоотой хууль байсан нэршлийг өөрчилсөн. ДҮТ ТӨХХК-ийн эрх үүрэгт байсан “Эрчим хүчний талаархи ойрын болон хэтийн бодлого, чиглэлд үндэслэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бодлого хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, салбарын боловсон хүчнийг мэргэшүүлэх” зэрэг үүргүүд бүхий заалтыг хүчингүй болгосон.
7	2012.08.17	6.1.12-6.1.16 6^1	2011 онд хуульд оруулж, ДҮТ эрх, үүргээс хасаж, хүчингүй болгосон зарим заалтыг төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд нэмж, давхацсан агуулга бүхий 6^1 хэсгийг хүчингүй болгосон. Үүнд: 6.1.12.эрчим хүчний талаарх төрийн бодлого боловсруулахад шаардагдах тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх; 6.1.13.эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах; 6.1.14.эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах; 6.1.15.уламжлалт бус эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах; 6.1.16.эрчим хүчний алдагдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах."
	2015.06.19	хэсэг, заалт нэмсэн 2.4, 3.1.30-3.1.34, 5.1.6, 6.1.15, 6.1.18, 9.1.19, 9.1.21, 9.1.22, 10.3, 10.4, 12.1.12, 14.4, 15.2.5, 18.2.3, 27.8, 29.1.9, 30.1.13, 37.2, 37.3, Нэмсэн 3.1.7, 3.1.8, 3.1.22, 6.1.5, 6.1.12, 8.1, 9.1.18, 9.1.19,	Энэ онд хийсэн нэмэлтээр дараах онцлох өөрчлөлтийг оруулсан. “Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгч” болон “эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-ний нэр томъёоны тодорхойлолтыг нэмсэн. **Засгийн газарт** бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлэх, **ТЗТБ-д** эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг байгуулах эрхийг холбогдох байгууллагад өгөх, **ЭХЗХ-нд** бие даасан үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг баталгаажуулах, **ДҮТ ТӨХХК-д** “бие даасан үйлдвэрлэгчээс сүлжээнд нийлүүлэх худалдах, худалдан авах гэрээ байгуулах”, “нэгдсэн сүлжээгээр цахилгаан эрчим хүч импортлох, экспортлох”, “нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх” зэрэг эрх үүргүүдийг өгч үйл ажиллагааг нь өргөжүүлсэн.

8		10.1, 21.7, 9.1.3, 30.1.1 өөрчлөн найруулсан 3.1.1, 3.1.5, 5.1.5, 6.1.14, 12.3, 12.6, 19.2, 25.1.5, 26.1, 26.2.4, 29.2, 36.1, 37.1.1-37.1.6, өөрчилсөн 3.1.28, 5.1.3, 6.1.8, 8.6, 9.2, 11.2, 14.2.2, 16.3.2, 16.4, 17.3, 20.1, 21.2, 21.3, 26.2.6, 26.3, 27.3, 27.5, 30.2, 35.1, 27.1, 27.4, 28.2, 29.1.2, 33.2, 34.1, Заалт дотроос үг хассан 9.1.3, 12.4, 16.3.3, 26.2.7, 32.1.1, 32.1.4 Хүчингүй болгосон 7.2	Дамжуулах сүлжээний дэд станц болон эх үүсвэрээс хэрэглэгчийн тоноглол руу явсан 110 кВ түүнээс доош хүчдлийн сүлжээ түгээх сүлжээнийх байх боломжийг бүрдүүлсэн. Эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байхыг анх удаа албан ёсоор хуульчилсан. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл, төслүүд нэмэгдсэнтэй холбоотой Дэмжих тарифийг Тарифт оролцуулж тооцуулахаар болсон. **Эрчим хүчээр хангагчийн эрх үүрэгт** хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхийг нээж өгсөн. 12.6.Хэрэглэгчийн өөрийн технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тухайн хуулийн этгээдэд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдэд цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй. Энэ мэтчилэн хуулинд байгууллагуудын эрх үүрэгт зарчмын өөрчлөлтүүдийг оруулсан нэмэлт болсон.
9	2015. 12. 04	37.1, 37.2	Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөлт орсон. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ, 37.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ." Заалтыг өөрчлсөн найруулсан
10	2017.01.26	өөрчлөн найруулсан	Арбитрын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн өөрчлөлт орсон. Арбитрийн хэлэлцээртэй бол маргааныг арбитрийн журмаар шийдэх болон бусад тохиолдолд зохицуулах зөвлөл шийдвэрлэх,

		35.1-35.3	эс зөвшөөрвөл шүүхэд хандаж, гомдол гаргаж болно гэдгийг өөрчлөн найруулсан.
11	2022.04.22	7.1, 33.2	Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 7.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн "нийслэл, сум," гэснийг "сум, нийслэл," гэж тус тус өөрчилсөн
12	2022.11.11	29.2, 34.1,	МУЗГ-н 2022 оны 417-р тогтоолын дагуу мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай нийцүүлэн өөрчлөлт орсон. Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн "мэргэжлийн хяналтын" гэснийг "эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэж өөрчилсүгэй. Эрчим хүчний тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн "мэргэжлийн" гэснийг хассан.
13	2022.12.09	6.1.19	Энэ хуулийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нийцүүлэн нэмэлт орсон. Төрийн захиргааны төв байгууллагын эрхэд “....төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, холбогдох байгууллагад төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих” үүргийг нэмж өгсөн.
14	2023.01.06	хэсэг, заалт нэмсэн 12.1.13, 12.7, 20[1] , 21.9, 24, өөрчлөн найруулсан 21.1, 21.2, 21.4, 21.5, 22.3, 24.1, 24.3, хүчингүй болсон 24.2	Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх." "12.7.Тусгай зөвшөөрлийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэхийг хориглоно." заалт нэмсэн. “Эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, засвар, туршилт, тохируулгын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг албан ёсоор хуулинд тусгаж, шинээр оруулсан. Тусгай зөвшөөрлийн хууль заасан 34 нэр төрлийн тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын зааг, ялгааг тусгаж өгсөн.
15	2024.06.05	9.1.24	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн нэмэлт орсон. Нийслэл Улаанбаатар хот болон бусад хотын дэд бүтцийн санд орлого төвлөрүүлэх үүргийг ЭХЗХ-нд өгч энэхүү нэмэлтийг хийсэн.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ, НЭМЭЛТ ОРУУЛСАН ҮНДСЭН ШАЛТГААНУУД



Дээрх судалгаанаас үзэхэд Эрчим хүчний тухай хуульд 2001 оноос хойш нэмэлт өөрчлөлт оруулсан 15 удаагийн тохиолдлын 10 нь Сэргээгдэх эрчим хүчний тухай, Цөмийн энергийн тухай, Зөрчлийн тухай, Арбитрийн тухай, Иргэний тухай, Хот тосгоны эрхзүйн байдлын тухай гэх мэт бусад хуулиудад шинэчилсэн найруулга хийсэнтэй холбогдуулан нэмэлт өөрчлөлт хийсэн байна.

Өөрөөр хэлбэл эрчим хүчний тухай хуулинд байсан дээрх хуулиудтай хамаарал бүхий заалтуудад зохих өөрчлөлт оруулах эсвэл тухайн хуулиараа бие дааж зохицуулагдахаар болсон.

Ерөнхийдөө бусад хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой оруулсан өөрчлөлт бөгөөд эрчим хүчний салбарын бодлого, зорилт, бүтцэд оруулсан өөрчлөлт, шинэчлэлтийн чиглэлтэй заалт, нэмэлт өөрчлөлтүүд хомс гэж дүгнэхээр байна.

Харин 2008 оны 12 дугаар сарын 19, 2011 оны 12 дугаар сарын 09, 2012 оны 08 дугаар сарын 17, 2015 оны 06 дугаар сарын 19, 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрүүдэд хийсэн хуулийн нэмэлт өөрчлөлтүүд салбарын үйл ажиллагааг зохицуулах, удирдах, чиглүүлэх асуудалд тодорхой өөрчлөлт хийсэн.

Түүнчлэн дээрх хуулийн нэмэлт өөрчлөлтүүд дотор логикийн алдаатай, цаашид хэрэгжилтүүлэлт учир дутагдалтай байж болохоор заалтууд ч байдаг.

Тухайлбал:

- 2015 оны хуульд хийсэн нэмэлт өөрчлөлтөөр Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, түүнийг олгох хэсгийн “12.6.Хэрэглэгчийн өөрийн технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тухайн хуулийн этгээдэд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдэд цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй." гэж заасан.

  Энэ заалтын дагуу технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнд тухайн хуулийн этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд цахилгаан, дулаан, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй гэж ойлгогдох бөгөөд нэгдмэл сонирхолтой биш бол тусгай зөвшөөрөл авч болохоор байна.

  Үүний сөрөг тал нь томоохон хэрэглэгчдийн түгээлт, хангах үйл ажиллагааны борлуулалтын орлого дурын хуулийн этгээд рүү шилжиж, үүний зөрүү, дутагдсан орлогыг ахуйн жижиг хэрэглэгчдийн үнэ тарифийг нэмэгдүүлэх замаар нөхөх эрсдэлтэй юм.

  Дээрх заалтыг 12.6.Хэрэглэгчийн өөрийн технологийн хэрэгцээнд зориулан татсан шугам, дэд станц, түүнээс авсан хэрэглэгчийн шугам сүлжээнээс цахилгаан, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл олгохгүй." гэж өөрчлөн найруулах нь зүйтэй.
- 2015 оны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр ДҮТ ТӨХХК-д “15.2.5. нэгдсэн сүлжээний горим тооцоо, реле хамгаалалт, автоматик, шуурхай удирдлага, холбоо мэдээллийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх” гэсэн эрх, үүрэг нэмэлтээр өгсөн. Нэгдсэн сүлжээний шуурхай удирдлага, хяналт мэдээллийн СКАДА системийг ДҮТ ТӨХХК эзэмшдэг. Гэтэл өөрийн санхүү, үндсэн хөрөнгө, үндсэн тоноглол байхгүй зэрэг шалтгаанаас үүдэн уг системийг цаашид хөгжүүлэх, сайжруулах, шинэчлэх, өргөтгөх ажил хангалтгүй явж ирсэн. Энэ нь ДҮТ ТӨХХК-н өөрийн гэсэн шугам тоноглол байхгүй, эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээлттэй холбоотой бодит орлого байхгүй зэрэгтэй холбоотой байх. Иймээс нэгдсэн бодлогын хэрэгжилт хангалтгүй талдаа байдаг.
- 2011 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн нэмэлтээр өөрчлөн найруулж, Цахилгаан, дулаан түгээх тусгай зөвшөөрөл хэсгийн “16.3.7.энэ хуулийн 9.1.13-т заасан холболтын журмын шаардлага хангасан хэрэглэгчтэй урьдчилан тохиролцсоны үндсэн дээр энэ хуулийн 17.3-т заасан гэрээг байгуулж, тухайн хэрэглэгчийн шугамаас бусад хэрэглэгчийг холбох” гэж заасан. Энэхүү заалт нь харилцааг бүрэн зохицуулж чадаагүй хэт ерөнхий байдлаар тусгагдсан тул маргаантай, монополь байдал үүсгэх, анхны шугам барьсан этгээд өөрийн дурын үнэ, холболтын төлбөр авах зэрэг сөрөг тал бий болгосон. Иймд анхны төсөвт өртөг, зураг төслийг үндэслэх, холболтын суурь төлбөр гэсэн ойлголтыг хуульд оруулах нь зүйтэй. /УБЦТС ТӨХК-нд хэсэг мөрдөж байсан туршлагатай/

Дээр дурдсаны дагуу 5 удаагийн нэмэлт өөрчлөлтийн зарим заалт нь бодит байдалд хэрэгжилт хангалтгүй, сөрөг гэж болохоор үр дагавар бий болгосон байдаг.

Түүнчлэн бүхэлдээ нэмэлт өөрчлөлтүүд нь эрчим хүчний салбарт өрсөлдөөн үүсгэх, ил тод байдлыг хангах, эрчим хүчний салбарыг төрийн болоод улстөрийн хамаарлыг багасгах, үйлдвэрлэгч болон түгээх-хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудыг нээлттэй хувьцаат компани болгож олон нийтийн хяналт-дэмжлэгийг бий болгох, шинэ эх үүсвэр барихтай холбоотой зохицуулалтыг илүү тодорхой, хөрөнгө оруулагчдийн сонирхлыг татах хэлбэрээр өрсөлдөөн үүсгэж зохион байгуулах, уг эрх нь тодорхой хэмжээний дэнчин, барьцаатай байх, эх үүсвэр барих ажлаа гэрээнд заасан хугацаанд эхлүүлээгүй, хэрэгжүүлээгүй бол барьцааг улсын орлого болгох зэргээр шинэчлэлт, реформын шинжийг агуулсан өөрчлөлт хангалттай хийгдэж чадаагүй.

Үүнээс үүдэн эрчим хүчний салбарын хөгжил бусад салбараас хоцорсон, зогсонги байдал руу шилжихэд онцгой нөлөөлөл үзүүлсэн гэж үзэж болно.

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД СУДАЛГААНУУД





ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАГДААГҮЙ ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГАА


ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧИНД ХОЛБОГДООГҮЙ

906 ААН, 34372 айл өрх

Монгол улсын 21 аймаг, бүх сум төвлөрсөн цахилгаан эрчим хүчний системд холбогдсон. Гэвч аймаг, нийслэл, сумдын шинэ сууршлын бүс буюу шинээр ААН, иргэд үйл ажиллагаа явуулах, байнга оршин суудаг болсон байршлуудад хөрөнгө оруулалтаас шалтгаалж цахилгаан эрчим хүчний хангамж, шугам сүлжээ баригдаагүй.

Мөн тухайн хэсгийн дамжуулах болон түгээх шугам сүлжээний хүчин чадал хүрэлцэхгүй болсон тул шинээр хэрэглэгч холбох боломжгүй нөхцөл бий болсон.

Цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй хэрэглэгчдийн тоо Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээний үйлчлэх бүсэд хамгийн их буюу 30765 айл өрх байна.



Дамжуулах болон түгээх шугам сүлжээний хүчин чадал хүрэлцэхгүй болсон тул шинээр хэрэглэгч холбох боломжгүй.

Хөрөнгө оруулалт байхгүй.